

Гүнзгий мэд

MONGOLIAN ECONOMY



Бизнес дагуулсан бизнес


Айлын том хүүхэд

Ирээдүйн машин
үйлдвэрлэлийн төвд

2016 оны 04 сар №08 (110)

mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮЧЭЭ "ЭРДЭНЭТ"



COAL MONGOLIA

METALS MONGOLIA

MineTech

ОЛОН УЛСЫН УУЛ УУРХАЙН ГУРВАН ТОМ АРГА ХЭМЖЭЭ
НЭГ ТАСАЛБАРААР НЭГ ГАЗАР

2016 ОНЫ 5-Р САРЫН 6 - 7
КОРПОРЭЙТ КОНВЭЙНШ ТӨВ
УЛААНБААТАР ХОТ

COAL & METALS MONGOLIA-2016

УУЛ УУРХАЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

ЧУУЛГАНЫ САЙТААР ЗОЧИЛНО УУ

WWW.COALANDMETALS.MN

Монгол улсын дэд бүтэц, нүүрс, металлын салбарт хөрөнгө оруулалт татах зорилгоор жил бүр зохион байгуулагддаг олон улсын нэр хүнд бүхий томоохон чуулга уулзалт болох Coal Mongolia, Metals Mongolia болон уул уурхайн техник технологийн хамгийн том үзэсгэлэн MineTech нэгдэж "Coal & Metals Mongolia" нэрийн дор жил бүр зохион байгуулагдахаар боллоо.

"Coal & Metals Mongolia-2016" чуулга уулзалт, үзэсгэлэн нь Монгол улсын уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, шинэ дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх зорилготой бөгөөд 2016 оны 5-р сарын 6-7 өдрүүдэд Корпорейт Конвэйшн төвд зохион байгуулагдана.

PLATINUM SPONSOR




GOLD SPONSORS



SILVER SPONSORS



EVENT SPONSORS



BANK OF EVENT



OFFICIAL SIGHTSEEING



MAIN ORGANIZER



MEDIA SPONSORS




EVENT SUPPORTERS



ХАЯГ:
УЛААНБААТАР, БГД
БАРУУН 4 ЗАМ
МҮЭСТОРДОН, 300 ТООТ
«ГЛОЖЕКС» ХХК

УТАС:
(976) 9911 6135
(976) 7711 5590
ФАКС:
(976) 7012 5590

И-МЭЙЛ:
NARANBAATAR@GLOGEX.MN
ВЭБСАЙТ:
WWW.COALANDMETALS.MN



ЧУУЛГАНЫ УРЬДЧИЛСАН ХӨТӨЛБӨР

Эхний өдөр буюу 2016 оны 5-р сарын 06

Хоёр дахь өдөр буюу 2016 оны 5-р сарын 07

08:00	Зочдыг бүртгэж, танхимд оруулах, үзэсгэлэнгийн талбайг нээх
08:50	Нээлтийн арга хэмжээ
09:00	Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн мэндчилгээ
09:20	Уул уурхай, аж үйлдвэрийн салбарын бодлого, хөрөнгө оруулалтын орчин
11:00	Цайны завсарлага
11:30	Эрчим хүчний нүүрсний салбар хурал
13:00	Өдрийн хоолны завсарлага-Корпорэйт зочид буудал
14:00	Коксжих нүүрсний салбар хурал
15:30	Цайны завсарлага
16:00	Төмрийн хүдрийн салбар хурал
18:00	Эхний өдрийн хурал, үзэсгэлэнг хаах

08:00	Зочдыг бүртгэж, танхимд оруулах, үзэсгэлэнгийн талбайг нээх
09:00	Алтны салбар хурал
11:00	Цайны завсарлага
11:30	Зэсийн салбар хурал
13:00	Өдрийн хоолны завсарлага-Корпорэйт зочид буудал
14:00	Ураны салбар хурал
15:30	Цайны завсарлага
16:00	Засгийн газрын цаг-Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа
18:00	Хоёр дахь өдрийн хурал, үзэсгэлэнг хаах
18:30	Хүндэтгэлийн хүлээн авалт-Корпорэйт зочид буудал

ЧУУЛГАНЫ ИЛТГЭГЧ НАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨЛӨӨЛЛҮҮД



Уул уурхайн сайд
Р.Жигжид



Аж Үйлдвэрийн сайд
Д.Эрдэнэбат



Монгол Улсын сайд
М.Энхсайхан

БИЗНЕСИЙН ГОЛ ТӨЛӨӨЛЛҮҮД



Б.Бямбасайхан
Гүйцэтгэх захирал
Эрдэнэс Монгол ХХК



Эндрю Вудлэй*
Ерөнхийлөгч бөгөөд
Гүйцэтгэх захирал
Оюу Толгой ХХК



Ц.Даваацэрэн*
Ерөнхий захирал
Эрдэнэт үйлдвэр ХХК



Тьерри Плэзант*
Ерөнхий захирал
Арева Монгол ХХК,
Кожеговь ХХК



Г.Батцэнгал
Ерөнхий захирал
Монголиан Майнинг
Корпорэйшн ХХК



Д.Батжавхлан
Ерөнхий захирал
Дарханы Төмөрлөгийн
Үйлдвэр ХК



Д.Ганболд
Ерөнхий захирал
Алтандорнод Монгол ХХК



Ч.Мөнхбат
Ерөнхийлөгч бөгөөд
Гүйцэтгэх захирал
Саусгоби Сэндс ХХК



Жонн Белл
Гүйцэтгэх захирал
Хаан банк



Род Чанин
Ерөнхийлөгч бөгөөд
Гүйцэтгэх захирал
Бороо Гоулд ХХК



Р.Сэлдорж
Гүйцэтгэх захирал
Тавантолгой ХК



Т.Гантөмөр
Ерөнхий захирал
Очир Учдраа групп ХХК

БУСАД ИЛТГЭГЧ НАР

С.Жавхланбаатар Хөрөнгө оруулалтын газрын дарга
Эйжи Тоёошима ЗАМайн Сервисез ХХК-ийн гүйцэтгэх захирал
Стив Поттер Вагнер Ази Тоног төхөөрөмж ХХК-ийн гүйцэтгэх захирал
Гонзало Шанчез Гантөмөр Интернэйшнл ХХК-ийн Гүйцэтгэх захирал
М.Сүхбаатар Болдтөмөр Ерөө гол ХХК-ийн дэд захирал
Д.Болдсүх Трансвест Монголиа ХХК-ийн Худалдааны газрын дарга
Винлин Суэ Фэнвэй Энержи Консалтинг ХХК-ийн Ерөнхий менежер
Веншен Фан Шанси Кокинг Коал ХХК-ийн Ерөнхий менежер

Жон Дэвис Би Эм Ай Ресеорч байгууллагын ахлах судлаач
Б.Тэмүүжин Тавантолгойн Цахилгаан Станц төслийн захирал
Н.Тэгшбаяр Геологийн төв лабораторийн гүйцэтгэх захирал
Б.Оюунгэрэл Геологи уул уурхайн мэргэжлийн институтийн гүйцэтгэх захирал
Л.Наранбаатар Гложекс ХХК-ийн Ерөнхий захирал
Эдмонд Лай Женерал Электрик ХХК-ийн Уул уурхайн Хятад Монголын бүс хариуцсан ерөнхий менежер

Жич:

Чуулганд илтгэл тавих хүсэлтийг maralardene@glogex.mn хаягаар, эсвэл 70115590, 99865687 утсаар авах бөгөөд зохион байгуулах хороогоор баталгаажуулсны дараа илтгэлийг хөтөлбөрт оруулна. Хурлын хөтөлбөр 2016 оны 4-р сарын 15-ны өдөр эцэслэн зарлагдах ба түүнээс хойш илтгэл тавих хүсэлт хүлээн авах боломжгүйг мэдэгдэж байна.

Тайлбар: *Илтгэл тавиулахаар ярилцаж буй бөгөөд харахан баталгаажуулаагүй.



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН
14 ХОНОГ ТУТМЫН АНГЛИ, МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ СЭТГҮҮЛ

Mongolian Economy

www.mongolianeconomy.mn

Утас: 94092904, 88006228, 70115476, 70115477
И-мэйл: info@mongolianeconomy.mn

ДЭЛХИЙН ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн “The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна. Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох. ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг үг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг. Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904

Редакцийн зурвас

Манай сэтгүүл энэ удаа Монголын эдийн засгийг тэр дундаа улсын төсвийг олон жил нуруундаа үүрч яваа нэгэн том “айлын” тухай бүрэн цогц мэдээлэл хүргэж байна. Энэ бол уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн тухай юм.

Үүсэн байгуулагдсан цагаасаа хойш өдгөө 38 дахь жилтэйгээ золгоод буй Монгол-Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэрийн Монголын нийгэм, эдийн засагт үзүүлэх хувь нэмэр их.

“Эрдэнэт” үйлдвэрийн эдийн засаг руу гүн өнгийхийн тулд манай сэтгүүлийн сурвалжлах баг Эрдэнэт хотод ажилласан юм.

Саяхныг болтол хэвлэлүүд тус үйлдвэрийн тухай “Саалийн ганц үнээ” гэж цоллон бичсээр ирсэн. Эдийн засгийн хүндрэлтэй энэ үед ч “Эрдэнэт үйлдвэр” саалийн ганц үнээнийхээ үүргийг гүйцэтгэж байна. Өнгөрсөн хугацаанд тус үйлдвэрийн тухай мөр

тавиагүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монголд бараг байхгүй гэхэд хилсдэхгүй. Сайнтай муутай нь бишгүй л бичсэн. Гэхдээ төдийгөөс өдий хүртэл улсын авч яваа энэ том айлын тухай, тэнд буй асуудлын тухай олон өнцгөөс харсан бүрэн цогц мэдээллийг ийнхүү нэг дор хүргэж байсан тохиолдол байхгүй байх. Тиймээс хуучин, шинэ цагийн алинд ч улсын төсвийн тулах багана байж ирсэн уг үйлдвэрт эдийн засгийн сэтгүүл бүтэн дугаараа зориулахад буруудах зүйлгүй болов уу. Ингэхдээ бид тус үйлдвэрийг хий хоосон магтан дуулах гэсэнгүй. Бидэнд тэгэх

шаардлага ч байхгүй. Хамгийн гол нь дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн уналт удаан үргэлжилж, Хятад улс зэсийн импортын хэмжээгээ багасгаж, ханш ойрын хугацаанд сэргэх найдлага бага байгаа энэ цаг дор “Эрдэнэт” үйлдвэрийн ашиг орлого ямар байгаа, улсын төсөвт оруулах татварын төлөвлөгөөгөө биелүүлэх эсэх, хүндрэлийг давах ямар стратеги төлөвлөгөөтэй ажиллаж байгаа болон Эрдэнэт хотын аж амьдрал ямар байна вэ гэдэг талаас нь харлаа. “Эрдэнэт”-ийн эдийн засаг руу гүн өнгийхийн тулд манай сэтгүүлийн сурвалжлах баг Орхон аймагт ажилласан юм.

Монгол Улсын уул уурхайн салбарын ууган үйлдвэрийн хувьд “Эрдэнэт” зөвхөн улсын төсвийг нуруундаа үүрээд зогсоогүй ашигт малтмалын салбарын хөгжилд олон зүйлийн шинэ эхлэл, үлгэр жишээ болсон байдгийг уншигч та манай сэтгүүлийн хуудсуудаас харах болно.

Түүнчлэн компанийн санхүүгийн байдал хүнд байгаа ч хүндрэлийг амжилттай давах нэг бус шинэ бодлого хэрэгжүүлж, техник технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг чухалчилж ажилласнаар бодит үр дүн гаргаж буйг холбогдох баримт, статистикүүдээс тод томруун харах боломжтой.

6000 ажилтантай тус үйлдвэр хямралын үед нэг ч хүн ажлаас нь халахгүйгээр зохицуулж, улсад төлөх татвараа цаг хугацаанд нь өндөр дүнтэй хийхийн төлөө ажиллаж байгаа нь аргагүй л онцлох амжилт байлаа. “Эрдэнэт” үйлдвэрийн ирээдүй ч тодорхой харагдана. Эрхэм та сэтгүүлээ таалан уншина уу. ■

“Mongolian Economy” сэтгүүлийн редакци



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999 4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800 6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
О.Түвшин

СЭТГҮҮЛИД:
Б.Үүрийнтуяа
Б.Энхцэцэг
Г.Орхон
Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:
Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Барянжав /9409 2904/

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
I хороо, Экспресс тауэр. 1101 тоот
Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn
Утас: 976-7011 5476

Борлуулах цэгүүд:

“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетин бүх салбар
“Макс” супермаркетин бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн:
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дахь салбарууд

facebook.com/
Mongolian.Economy

twitter.com/
EconomyMongolia

youtube.com/user/
MongolianEconomy

Эдийн засаг

10 Үйлдвэр дагасан хот

Аймгуудыг өрсөлдөх чадвараар жагсаахад Орхон аймаг бүх үзүүлэлтээр 100 (хамгийн дээд) оноо авчээ.

12 Ц.Даваацэрэн: Үйлдвэр хэвийн ажиллаж байгаа нь хөөсрөлийг бодит хөрсөнд буулгасантай холбоотой

“Эрдэнэт” үйлдвэрээр Монголын ард түмэн бахархдаг

18 Уурхай хаагдвал...

Монгол Улсын гурав дахь хот Эрдэнэтэд 100 мянган хүн оршин суудаг бөгөөд эдийн засаг нь “Эрдэнэт” үйлдвэртэй бараг хүйн холбоотой гэж болохоор өндөр хамааралтай.

20 “Эрдэнэт” үйлдвэрийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр

Уул уурхайг тэргүүлэх салбар болгосон манай улсын хувьд эрдэс баялгийн үнэ хаашаа савлана түүнээс эдийн засгийн өсөлт бараг шууд шалтгаалдаг гэж хэлж болно.

22 Есөн асуудал, есөн шийдэл

Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн сүүлийн гурван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн бодлогыг тун энгийн тодорхойлж болно.

26 Хямралын эсрэг авсан арга хэмжээнүүдийн үр дүн

“Эрдэнэт үйлдвэр” ХХК үйлдвэрлэл-эдийн засгийн төлөвлөгөөт үзүүлэлтүүдээ тогтмол амжилттай биелүүлж, ашигтай ажиллаж байна

28 Тоон мэдээлэл

2013-2015 онд улсын болон орон нутгийн төсөвт

төлсөн татвар нь нийт орлогын 35-43 хувийг эзэлж байна

30 Бизнес дагуулсан бизнес

Орхон аймагт 2014 онд мэндэлсэн гарааны бизнесүүдээс гэхэд өдгөө долоон компани амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

31 Үр ашигт шинэчлэлүүд

Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ шалдаа буусан өнгөрсөн хугацаанд “Эрдэнэт” үйлдвэр зардлаа бууруулж, үр ашгаа нэмэгдүүлэхэд нэлээд анхаарч ажилласан.

34 Тэндээс онцлох 10 үйл явдал

Европын холбооноос гарах уу, үлдэх үү?

36 Айлын том хүүхэд

Байгалийн баялаг мөнх бус учир тус үйлдвэрийн дараагийн том зорилтуудын нэг Эрдэнэт хотыг чирэгчгүй хот болгох.

40 Ирээдүйн машин үйлдвэрлэлийн төвд “Эрдэнэт” үйлдвэрийн

Засвар, механикийн завод нь Монголдоо хамгийн том машин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв.

42 Оюунлаг Эрдэнэт

Монгол, Америкийн хамтарсан “Эрдмин” үйлдвэр жилдээ 300 тонн цэвэр зэс гаргах юм байна.

44 Эрдэнэт ба...хаялга, улс төр, шороон үхэр...

“Эрдэнэт” үйлдвэр нь хямралыг даван гарч чадах менежмент нэвтрүүлж, туршлага хуримтлуулж чадсан гэдэгт итгэлтэй байна.




Ц.Даваацэрэн: Үйлдвэр хэвийн ажиллаж байгаа нь хөөсрөлийг бодит хөрсөнд буулгасантай холбоотой

Цаашдаа зөвхөн зэсийн баяжмал биш, эцсийн бүтээгдэхүүн хийх, зэс хайлуулах үйлдвэр барих, хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнүүдийг нийлүүлдэг үйлдвэрүүдийг барьж байгуулах хэрэгтэй, хуудас 12



Үр ашигт шинэчлэлүүд

Энэ мэт цаг үеэ олсон олон хөрөнгө оруулалт хийснээр “Эрдэнэт” үйлдвэрийн олон жилийн тогтвортой ажиллагаа хангагдаж байна, хуудас 32



Ирээдүйн машин үйлдвэрлэлийн төвд

“Эрдэнэт” үйлдвэрийн Засвар, механикийн завод нь Монголын аж үйлдвэрийн том түшиц байж иржээ, хуудас 40



Оюунлаг Эрдэнэт

2013 оноос эхлэн Инновацийн төвийг хөгжлийн төвийн дэргэд байгуулан ажиллаж байна, хуудас 42

Монголд

Экспорт

Эрдэс бүтээгдэхүүний экспорт энэ оны нэгдүгээр улирлын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 137.7 сая ам.доллараар буурсан байна. Эрдэс бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 88.1 хувийг эзэлж байгаа юм.

Хэдийгээр экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөн ч үнийн зөрүүнээс үүдэн түүнээс олох орлого буурсаар байгаа юм. Тухайлбал зэсийн баяжмалын экспортын хэмжээ 33 хувиар өссөн ч мөнгөн дүнгээр тооцвол зургаан хувиар буурсан үзүүлэлт. Мөн 2.2 сая баррель газрын тос экспортолж тоо хэмжээ нэмэгдсэн ч, үнийн зөрүүнээс үүдэлтэйгээр орлого 20 хувиар буурчээ. Төмрийн хүдрийн экспорт мөн улиралд 992 орчим мянган тонн байсан нь өмнөх оныхтой бараг дүйж байгаа ч орлогын хувьд өмнөх оныхоос 50 хувиар буурч 29 сая ам.доллартай гарчээ.

Түүнчлэн нүүрс, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ буураагүй ч үнийн дүн мэдэгдэхүйц буурчээ. Нүүрсний экспортын орлого 99 сая ам.доллар байгаа нь өмнөх оныхоос 30 хувиар бага дүн юм. Харин алтны экспорт мөн хугацаанд 2.9 тоннд хүрч, 111.3 сая ам.долларын орлого оруулжээ. Энэ нь өмнөх оныхоос биет жингээр 18 хувь, үнийн дүнгээр 13.6 хувиар өссөн гэсэн үг.

Бүтээмж

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл эхний улиралд 1787.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 15.4 тэрбум төгрөг буюу 0.9 хувиар өсчээ. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 1180.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 49.1 тэрбум төгрөг буюу 4.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үеийнхээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт молибдений баяжмал, газрын тос, зэсийн баяжмал, алт зэрэг бүтээгдэхүүний олборлолт 0.2-92.7 хувиар өссөн бол нүүрс, цайрын баяжмал, хайлуур жонш, буталмал чулуу, төмрийн хүдрийн олборлолт 7.1-75.7 хувиар буурчээ.

Удаашрал

Гадаад орчин тогтвортой байж, уул уурхайн салбар дахь томоохон хөрөнгө оруулалт сэргэснээр энэ онд Монголын



эдийн засаг таван хувьд хүрч өсөх боломжтой гэсэн таамгийг дотоодын мэргэжилтнүүд хийж буй. Тэгвэл бүс нутаг, дэлхийн чиг хандлага, уул уурхайн салбарын бүтээмж буурснаар

манай улсын эдийн засгийн өсөлт энэ онд 0.1 хувь, 2017 онд 0.5 хувьтай байна хэмээн АХБ таамаглаж байна. Төлбөрийн тэнцэл дэх хүндрэлүүд даамжирч, өрийн менежмент зэргээс үүдэн төсвийн болоод мөнгөний бодлогыг чангаруулах шаардлагатай гэж тэд зөвлөж байна.

АХБ-ны тодорхойлсноор нэгтгэж тооцсон төсвийн алдагдал өнгөрсөн онд ДНБ-ий 11.5 хувьд хүрсэн нь дээд хэмжээ болж буй. Ирэх хоёр жилд зарим зээлийн эргэн төлөлтүүд эхэлж буйг анхааран авч үзэх хэрэгтэй. Түүнчлэн “Эдийн засгийн өсөлтийг тогтмолжуулж, ажлын байр бий болгох зорилгод үндсэн хөрөнгө ихээр шаарддаг уул уурхайн салбар төдийлөн хувь нэмэр оруулахгүй учир олон тулгуурт эдийн засгийг цогцлоох нь үндсэн сорилт хэвээр байна” хэмээн АХБ-наас мэдээлжээ.

Технологи

“Эрдэнэт үйлдвэр”-ийн Засвар, механикийн заводын Механик цехэд 2000 тонноор шахах хүчин чадалтай, бүрэн автомат шингэн шахуурга угсарч байна. Тайваньд үйлдвэрлэсэн уг төхөөрөмжийг суурилуулснаар том оврын резинэн эдлэл тухайлбал, тээрмийн резинэн хуяг, шигшүүрийн тор зэрэг импорт орлох бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх юм.

Засвар механикийн заводын хамт олон энэхүү шахуургыг энэ сарын 15-нд багтаан ашиглалтад оруулах зорилттой байна. Мөн тоног төхөөрөмжийн ажиллах зааварчилгаа боловсруулан, ажилтнуудаа сургаж байгаа аж. Тус цех өнгөрсөн онд 1000 тонноор шахах хүчин чадалтай шингэн шахуурга ашиглалтад оруулж байсан туршлагатай юм.

Үзэсгэлэн

“Mongolia Mining 2016” олон улсын уул уурхайн үзэсгэлэн энэ сарын 6-8-ны өдрүүдэд амжилттай болж өнгөрлөө. Үзэсгэлэнг Буянт Ухаа спортын ордонд зохион байгуулсан бөгөөд гадаад дотоодын 120 ханган нийлүүлэгч хамгийн дэвшилтэт технологио танилцуулсан юм. Тэдгээрийн дотор Беларусийн Белаз үйлдвэрийн 90 тоннын даацтай, цахилгаан ба шатахуунаар ажилладаг гибрид хөдөлгүүртэй аварга өөрөө буулгагчийг анх удаа Монголын зах зээлд танилцууллаа.

Мөн энэ үеэр “Оюу толгой” компани далд уурхайн төслийн төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөгөө танилцуулсан бол “Эрдэнэт үйлдвэр” худалдан авалтын менежментээ мөн танилцуулав. Жилд ойролцоогоор 300 тэрбум төгрөгийн худалдан авалт хийдэг тус компани нь үндэсний үйлдвэрүүдээ дэмжих зорилгоор аль болох дотоодын үйлдвэрүүдээ худалдан авалт хийх зорилт тавин ажиллаж байгаа аж.

Усны менежмент

“Эрдэнэт үйлдвэр” ХХК Баяжуулах фабрикийн нунтаглан баяжуулах хэсгийн хаягдал усыг дахин ашиглах судалгаа хийж байна. Энэ ажлын угсралт тохируулгыг ирэх наймдугаар сард хийхээр төлөвлөжээ. Туршилт амжилттай болбол импортоор авдаг өндөр үнэтэй тоног төхөөрөмж хэрэглэхгүй болж, насосны ашиглалтын хугацааг уртасгах давуу талтай юм байна. ▶

► Дэлхий дахинд

Хятадын нөөц

Хятад улс асар их хэмжээний зэсийн нөөц дээр сууж байна. Тус улс 2015 онд түүхий эдийн импортоо эрчимжүүлсний дүнд дэлхийн зэсийн нөөцийн 80 гаруй хувийг хуримтлуулсан гэх. Түүнчлэн тус улсын удааширч буй барилга болон үйлдвэрлэлийн салбараас үүдэн цэвэршүүлсэн зэсийн дотоод эрэлт буурч буй тул энэхүү хуримтлуулсан нөөц дэлхийн зах зээл дээр арилжигдах магадлал өндөр байна. Хятад улс дэлхийн зэсийн 40 гаруй хувийг хэрэглэдэг учир шинжээчид жил бүрийн хоёрдугаар улиралд өсдөг эрэлт өсдөгөөрөө өснө хэмээн таамаглаж байгаа юм. Гэсэн ч энэ нь өмнөх жилүүдээс сул байх магадлалтай аж. “Голдман Сакс” БНХАУ-ыг 1.8 сая тонн зэс хуримтлуулсан гэж тооцоолж байгаа бөгөөд эрэлт энэ жил төдийгүй ирэх жил ч зогсонги байх болно гэж байгаа юм. Дөрөвдүгээр сарын эхээр Чилид болсон салбарын уулзалтын үеэр 16 мэргэжилтний зөвхөн дөрөв нь зэсийн үнэ аль хэдийнэ шалдаа буусан гэж үзжээ. Тус хуралд оролцсон “Туркойз Хилл Ресурс” компанийн гүйцэтгэх захирал Жефф Тигесен хэлэхдээ зэсийн урт хугацааны төлөвт итгэсээр байгаа ч богино хугацаанд байдал хүнд байна гэжээ.


Зэсийн үнэ уналаа

Нийлүүлэлтийн илүүдэл болон олны санааг зовоосон Хятадын нөхцөл үргэлжилсээр буй энэ үед Лондонгийн Металлын бирж дээрх зэсийн гурван сарын фьючер үнэ дөрөвдүгээр сарын 8-наар төгссөн долоо хоногт 3.8 хувиар унаж тус долоо хоногийг нэг тонн нь 4,650 ам.доллараар хаасан байна. Ингэснээр энэ онд өсөлттэй байсан зэсийн үнэ уналаа. Энэ нь нэгдүгээр сарын 8-наас хойшхи хамгийн өндөр уналттай долоо хоног болж байгаа юм. Өнгөрсөн намар зэсийн үнэ ойролцоогоор 5.260 ам.доллар байсан. Олон хүмүүс энэ оны сүүлээр нэг тонн зэсийн үнэ 4.000 ам.доллар болж буурна гэж таамаглаж байна. Зэсийн үнэд найдаж байгаа нэгэн байхад итгэлгүй байгаа хөрөнгө оруулагчид ч цөөнгүй байгаа нь зах зээлд тодорхой бус байдлыг бий болгож буй. Гэвч өөдрөг үзэлтнүүд хүртэл өөрсдийн байр суурьд эргэлзэж эхэлжээ.

Нийлүүлэлтийн илүүдлийг аль хэдийнэ мэдэрч эхэлсэн дэлхийн зах зээлд Хятад улс өөрийн нөөцөө борлуулж эхлэхэд юу болох нь тодорхойгүй байна. Газрын тосны үнийн уналт үргэлжилж, зарим улсын дотоодын валютын ханш суларч байгаа нь зэс болон зарим бусад түүхий эд үйлдвэрлэгчдэд эерэгээр нөлөөлж гэдэнд зардлаа танах боломж бий болгож байгаа юм.

Таваар ба өр

Дэлхийн түүхий эдийн үнийн уналт болон чангарч буй ам.доллар ядуу орнуудад илүү хүндээр тусч байна. Газрын тос, төмрийн хүдэр, зэс болон бусад металл зэрэг түүхий эдийн үнэ унаж байгаа нь улсын орлогод сөргөөр нөлөөлж, олон орныг төсвийн алдагдалд ороход хүргэж байна. Үүний зэрэгцээ өсөж байгаа ам.доллараар төлж буй өрийн дарамт нэмэгдэж байна.



“Jubilee Debt Campaign”-ийн гаргасан тайланд 2016 онд бага болон бага дунд орлоготой орнуудын гадаад өрийн эргэн төлөлт дунджаар Засгийн газрын орлогын 10.8 хувь байх болно гэжээ. Харин гурван жилийн өмнө энэ үзүүлэлтийг 6.1 хувь байх болно хэмээн урьдчилан таамаглаж байсан юм. Дөрөвдүгээр сарын дундуур болох Олон Улсын Валютын сангийн хурлын гол сэдэв 1980 онд ам.долларын ханшийн өсөлт болон түүхий эдийн үнийн уналт өрийн хямрал авчирсантай адил нөхцөл байдлаас хэрхэн сэргийлэх талаар байх магадлалтай байна.

Огцрох өргөдөл

Панамын баримт бичгүүдээр илчлэгдсэн баримтаас шалтгаалж хэд хэдэн томоохон албан тушаалтнууд өртөж, огцрох өргөдөл эхнээсээ гарч

эхэлж байна. Огцрох өргөдөл ирүүлсэн эхний томоохон албан тушаалтан Исландын Ерөнхий сайд Сигмундур Гуннлаугссон байлаа. Ерөнхий сайдын гэр бүл Исландын дампуурсан банкуудыг эзэмшдэг оффшор хөрөнгө оруулалтын компанитай болох нь илэрснээр иргэд Рейкьявик хотын гудамжинд жагсаж эсэргүүцэл илэрхийлжээ. Бусад хэсгүүдээс дурьдвал, Аргентины Ерөнхийлөгч Маурисио Макри шүүхийн өмнө ямар ч буруу зүйл хийгээгүй хэмээн няцаасан бол улсын прокурор мөрдөн байцаалт явуулах санал гаргажээ. Харин Их Британийн Ерөнхий Сайд Дэвид Камерон түүний нас барсан эцгийн байгуулж байсан оффшор итгэлцлийн сангаас ашиг хүртдэг байснаа хүлээн зөвшөөрчээ. Гэвч тэрбээр түүний бие болон Ерөнхий сайд болохоосоо өмнө хувьцаагаа зарсан гэжээ.

Харин дэлхийн хөлбөмбөгийн удирдах байгууллага ФИФА-гийн хувьд тус байгууллагын ёс зүйн хорооны гишүүн Хуан Педро Дамиани баримт бичгээр ФИФА-гийн авлигын хэрэгт холбогдсон гурван хүнтэй холбоотой байсан нь тогтоогдсоноор албан тушаалаа хүлээлгэн өгчээ. Дамиани нь Зепп Блаттерийг хөлбөмбөгийн ертөнцөөс хөөх шийдвэрийг гаргасан бүрэлдэхүүнд байсан юм. Швейцарийн эрх баригчид Европын хөлбөмбөгийн чиглүүлэгч байгууллага болох УЕФА-д “нэгжлэг” хийжээ. Хятад болон ОХУ уг баримт бичигт хамгийн ихээр дурьдагсан улс байлаа. Хятад улсаас Си Жиньпин болон Улс төрийн товчооны байнгын хорооны найман гишүүн уг баримт бичигт багтжээ. Гэсэн ч уг мэдээллийг интернет болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гаргахыг хориглосон байна. Харин ОХУ-ын хувьд Ерөнхийлөгч Путин оффшор санхүүгийн үйл ажиллагаанд ямар ч оролцоо байхгүй хэмээн үгүйсгэсэн бөгөөд Панамын баримт бичгийг түүнийг болон ОХУ-ыг унагах гэсэн Барууны хуйвалдаан гэжээ. Энэхүү мэдээ ОХУ-ын иргэдийн Путинд итгэх итгэлд сэв суулгаж чадсангүй.

Албан тушаалаасаа огцрох магадлалтай болсон бусад хүмүүсийг дурьдвал Пакистан болон Мальт улсын Ерөнхий сайд, Украйны Ерөнхийлөгч болон олон улсын бусад өндөр албан тушаалтан болон бизнесийн ертөнцийнхнийг дурьдаж болох аж. ■



“Эрдэнэт үйлдвэр” хотыг хөгжүүлж буй хэрэг биш. Шинэ хот байгуулсан юм.

Түншлэл

Үйлдвэр дагасан хот

Ц.ЭЛБЭГСАЙХАН

100 гаруй мянган хүн амтай хот бий болох үндэс болсон “Эрдэнэт” үйлдвэр Монголын уул уурхайн салбарт үлгэр жишээ болж, өндөр босго тогтоогоод буй. Шулуухан хэлэхэд нийгмийн хариуцлага гэдэг ойлголтыг уул уурхайн компаниуд хэрхэн ажил хэрэг болгох ёстойг Эрдэнэтийн жишээгээр л харж, харьцуулах нь бий.

Аймгуудыг өрсөлдөх чадвараар жагсаахад Орхон аймаг бүх үзүүлэлтээр 100 (хамгийн дээд) оноо авчээ. Энэ нь тэнд засаглал үр дүнтэй, эдийн засаг нь чадамжтай, бизнес эрхлэхэд хамгийн таатайг илтгэж байгаа юм. Товчхондоо “Эрдэнэт” үйлдвэрийн болон аймгийн удирдлагуудын нягт хамтын ажиллагааг үүнээс харж болно.

Орхон аймгийн иргэд зөв хөгжүүлбэл орон нутгийн хөгжилд уул уурхай ихээхэн хувь нэмэртэйг хэдийнэ сайн ойлгосон ажээ. Үүнийг өнгөрсөн жил “Непко паблишинг” компанийн хийсэн судалгааны дүн харуулж байгаа юм. Энэ нь “Эрдэнэт” үйлдвэрийн үр шим орон нутгийн өрх,

иргэн бүрт хүртээмжтэй байгаагийн илрэл. Тэгвэл бараг л аймаг бүрт уурхайн олборлолт хийгдэж, иргэн бүр Тавантолгойн хувьцаа эзэмшиж, хөгжлийн сангаас сар бүр 21 мянган төгрөг хүртэж байсан атал бусад яагаад тэгж үзэхгүй байна вэ?

Эрдэнэтийн бизнесийн, зах зээл их онцгой мөчлөгтэй аж. “Эрдэнэт” үйлдвэрийн цалин буухад бүх хэрэглээний барааны үнэ өсч, хэсэг хугацааны дараа эргэн буурдаг гэх. Энэ нь “Эрдэнэт” үйлдвэрийн 6000 ажлын байр хотын 100 мянган хүний амьдралд ямар их үр нөлөөтэйг харуулж буй бодит жишээ. Зөвхөн үүгээр эрдэнэтийнхний амьдрал Эрдэнэт үйлдвэртэй холбогдож байгаа хэрэг биш. Өөр олон зүйл бий. “Эрдэнэт үйлдвэр” дам замаар Эрдэнэт хотыг тэтгэхээс илүү шууд хөрөнгө оруулалт хотод ихийг хийж уул уурхай, орон нутаг хэрхэн хоршин харилцан үр ашигтай оршиж болохыг 38 жилийнхээ түүх туршлагаар харуулж буй.

Ерөөс Эрдэнэтийн бүх дэд бүтцийн бүтээн байгуулалт үйлдвэрээ

даган бий болсон. Хотын зам, дулаан цахилгааны шугам, иргэдийн амьдарч буй орон сууцууд гэх мэт. Одоо ч үйлдвэрээ даган өргөжин тэлсээр байна. “Сархиа” цанын баазын зүүн урд суурьшлын шинэ бүс үүсгэхээр аймгийн захиргаа шийджээ. Энэ нь гэр хороололд амьдардаг “Эрдэнэт үйлдвэр”-ийн ажилчдын амьдрах орчныг сайжруулах, орон сууцжуулах үндсэн нөхцөл болж буй аж.

Өнгөрсөн жил л гэхэд Орхон аймгийн төдийгүй зэргэлдээх аймаг сумдын иргэдэд олон улсын чанартай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх эмчилгээ оношилгооны шинэ төвийг ашиглалтад оруулсан. “Эрдэнэт медикал” эмнэлэг өдөрт 500 гаруй иргэнд үйлчлэх хүчин чадалтай. Монгол Улсын эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай байгаа MRI, судсан дотуур оношилгоо хийх технологитой хөдөө орон нутгийн анхны эмнэлэг болж байна. Тухайлбал, MRI буюу соронзон резонанс томографи аппарат нь Улсын клиникийн III эмнэлэгт л нэг бий. Япон стандартаар байгуулсан ▶



Фотог О.Лхагвахорол

► эмнэлэг цахим системд бүрэн холбогдож, алсын зайн оношилгоо хийнэ. Шаардлагатай тохиолдолд гадаадын өндөр хөгжилтэй орны эмнэлгүүдтэй өвчтөнг холбож, эрүүл мэндийн тусламж хүртэхэд нь туслах хөтөч нь болох аж. Эмнэлгийг байгуулахад “Эрдэнэт үйлдвэр” ХХК 50 орчим тэрбум төгрөг зарцуулсан байна. Гэр хороолол гэж зам харгуй нь энхэл донхол, шороо тоостой, шөнө нь харанхуй, тохигүй газар гэж төсөөлдөг бол энд эсрэгээрээ. Гудамжаар нь хар зам зурайж, гэрэлтүүлгийг хотын төвөөс ялгаагүй шийджээ.

Өмнөх асуултын хариу нь магад энэ болов уу. Хэдэн арван жил үйлдвэрээ даган хөгжиж буй хотод өнгөрсөн бүх хугацаанд үйлдвэрээс хийсэн хөрөнгө оруулалт, хийсэн ажлыг дурдаж барамгүй. Зөвхөн сүүлийн гурван жилд л гэхэд Орхон аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллах гэрээний хүрээнд төрийн үйлчилгээ, эрх зүй, байгаль орчин, экологи, үйлдвэрлэл технологийн парк, зам тээвэр, харилцаа холбоо, нийгэм, эдийн засаг, боловсрол, бүтээн байгуулалтын чиглэлд нийт 55.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

“Эрдэнэт” үйлдвэр бусад аймаг орон нутагтай харьцуулшгүй өргөн нөөц боломжийг Орхон аймагт бий болгосон. Энэ нөөц боломжид тул-

гуурлан шинжлэх ухаан, технологийн парк байгуулах хөгжлийн төлөвлөгөө боловсруулаад байна. Одоогоор аймгийн ЗДТГ-тай хамтран техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг хийгээд байгаа аж. Шинжлэх ухаан технологийн паркттай болсноор Эрдэнэтийн үйлдвэрүүд инноваци, өндөр технологи бүтээж, Технологийн сургууль нь “Эрдэнэт” их сургууль болон өргөжиж, томоохон их сургуулиудын салбарууд судалгаа эрдэм шинжилгээний том төв болно. Эцэстээ 30-аад жилийн дараа уурхайн

олборлолт зогсоход “сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн инкубатор” нь орон нутгийн хөдөлмөрчдийн ажлын байр, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн орчин болох учиртай. Зөвхөн нэг хот бус, хангайн бүсэд байгуулагдаж буй ганц шинжлэх ухаан технологийн парк болох учир зэргэлдээ аймгуудын эдийн засагт ихээхэн эерэг нөлөөтэй байх юм. “Эрдэнэт” үйлдвэр бол зүгээр ч нэг хотыг хөгжүүлж буй жишиг биш. Шинэ хот байгуулсан уул уурхайн үйлдвэр. Тийм ч учраас хотын маргаашийн хөгжилд ч ийн сэтгэл гарган ажиллаж байна. ■



Менежмент

Ц.Даваацэрэн: Үйлдвэр хэвийн ажиллаж байгаа нь хөөсрөлийг бодит хөрсөнд буулгасантай холбоотой

Д.БЭХБАЯР

Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирал Ц. Даваацэрэнтэй ярилцлаа.



Шахааны бизнестэй тэмцэж олон хүний дургүйг хүргэлээ

–Бид “Эрдэнэт” үйлдвэрийн үр шимээр төсвөө бүрдүүлж, улсаа хөгжүүлж, амьдарч яваа улс. Энэ үйлдвэрийн улс орны хөгжилд оруулсан хувь нэмрийг та хэрхэн илэрхийлэх вэ?

–“Эрдэнэт” үйлдвэрээр Монголын ард түмэн бахархдаг. Сайхан үйлдвэр, сайхан хамт олон. 1978 онд байгуулагдсанаас хойш 38 дахь жилдээ ажиллаж байна. Энэ хугацаанд нийтдээ дөрвөн сая гаруй тонн цэвэр зэс үйлдвэрлэж экспортод гаргажээ. Улсын төсөвт таван их наяд төгрөг оруулж, 1,3 тэрбум ам.долларын ашигтай ажилласан байна. Эдийн засагт маш их өгөөжөө өгсөн үйлдвэр гэдгийг энэ тоонуудаас харж болно. Нийгэмдээ ч ашгаа гаргаад

явж байгаа. Үйлдвэрийг дагаад 100 гаруй мянган хүн амтай Эрдэнэт хот бий болжээ. Эдгээр нь Монгол Улсын хөгжил цэцэглэлтэд оруулсан бодитой хувь нэмэр.

Мөн уул уурхайн салбарт ашигт малтмалын нөөцийг зөв тооцоолж, зөв бодлого бариад явбал уул уурхай хөгжил авчирдаг гэдгийн бодит жишээ юм. Байгаль орчинд нөлөөлөх талд томоохон бодлогууд хэрэгжүүлж ирсэн. Цаашид анхаарах асуудлууд бий. Тухайлбал, тоосжилттой тэмцэж, байгаль орчны талаар тодорхой арга хэмжээнүүд авч ажиллах шаардлагатай. Дэргэдээ өнчин хүүхдүүдийг асрах төвийг 20 гаруй жил ажиллуулж ирлээ. Энэ асрамжийн төвөөр 250 гаруй хүүхэд өсч хүмүүжиж, ажил амьдралын дөрөөнд хүрсэн. Өнөөдөр 40 орчим хүүхэд өсөж бойжиж байна. Үүний зэрэгцээ ахмадуудаа улсын тэтгэвэр тэтгэмжээс нь гадна дэмжлэг үзүүлдэг. Энэ мэтчилэн улс нийгэмдээ үзүүлж буй өгөөж маш их юм аа.

–Хэдэн ажилтантай байна вэ?

–6000 гаруй ажилтантай.

–Байгууллагууд өнөөгийн хүнд нөхцөлд тэсэж тэвчихийн тулд ажилтнуудаа халж байгаа. Танайх ямар байдалтай байна вэ?

–Ажлын байрыг хэвээр хадгалж байгаа. 6000 хүний цаана ар гэрийнхэн нь бий. Энэ олон хүний амьжиргааг таслахгүйн төлөө ажиллаж ирсэн. Бусад ижил төстэй, хүчин чадалтай үйлдвэрүүдэд өнөөдөр 4-5 мянга орчим хүн ажиллаж байна. Эдийн засаг хүнд ч бид нэг ажлын байрыг ч хадгалах, мөн улсдаа төлөх тагвараа цаг хугацаанд нь гайгүйхэн дүнтэй өгөхийн төлөө явж байгаа.

–“Эрдэнэт” үйлдвэрээс улсын бас хоёр аймгийн төсөв шууд хамаардаг. Өнгөрсөн гурван жилд хэдий хэмжээний татвар өгсөн байна вэ?

–Өнгөрсөн жил улсын болоод орон нутгийн татварт нийлээд 381 тэрбум татвар төлжээ. Монгол Улсын хамгийн том татвар төлөгчөөр олон жил шалгарч байгаа компани. Өмнөх жилүүдтэй харьцуулахад татварын хэмжээ буурсан. Тухайлбал, 2014 онд 462 тэрбум төгрөг улсад төвлөрүүлсэн байна. Мөн Орхон, Булган аймгийн төсвийн ихэнхийг бүрдүүлдэг.

Энэ жилийн хувьд өмнөх жилийнхээс бага төлөх байх. Дэлхийн зах зээл дээр он гарангуут зэсийн үнэ огцом уначихлаа. Нэг тонн нь 5200 ам.доллар байсан зэсийн үнэ 4200 хүртэл буурчихсан шүү дээ. Одоо ялимгүй өссөн л дөө. Сүүлийн хоёр жил огцом унасан. 2011 онтой харьцуулахад хоёр дахин ▶

► буурсан. Нэг тонн зэсийн үнийн оргил үе таван жилийн өмнө 9800 ам.доллар байлаа. Тэгээд жил бүр унасаар өнөөдөр 4600 болсон. 2011 онд тэрбум гаруй ам.долларын борлуулалт оруулж ирж байсан бол өнгөрсөн жил 500 сая ам.долларын орлого хийсэн. Үнийн зөрүү ингэж нөлөөлж байгаа юм.

-Зэсийн үнээс уулын баяжуулах үйлдвэрийн ашиг, орлого шууд шалтгаалдаг. Цаашид ямар дүр зураг харагдана вэ?

-Дэлхийд зэсийн үнийн прогноз хийдэг арав гаруй томоохон компаниудын судалгааг харж байна. Тэдний судалгаа, дүгнэлтээс харвал үнэ өсөхөөргүй байна. Тэгэхээр бид үнийн ийм уналттай үед зохицож ажиллах ёстой. Өртөг зардлаа бууруулж, үндсэн хөрөнгө худалдан авахгүй байх ч юм уу, засварын зарим ажлыг түр хугацаагаар хойшлуулах гэх мэтчилэн хэмнэлтийн горимоор ашигтай ажиллахын төлөө явах ёстой. 2013 оны эхээр намайг энэ ажлыг авах үед тонн зэсийн үнэ 6625 ам.доллар байсан. Бидний тооцоогоор тонн нь 4500-4900 ам.долларын хооронд байвал үйлдвэр амьдраад байх чадвартай гэж үзэж байгаа.

-Та ерөнхий захирал болонгуутаа “Би шахааны бизнестэй хатуу тэмцэнэ” гэж хэлж байсан. Хир тэмцэнэ бэ, үр дүн гарсан уу?

-Өөрийн өртөг зардлыг бууруулахын тулд шахааны бизнесийг зогсоож, авлигаас ангид байхад хамгийн их анхаарал тавьсан. Манай баг сайн ажилласан. Тиймээс багийн зарим хүмүүсээ шагнаж урамшуулснаас болж, асуудалд орж, янз бүрээр хэлүүлээд сууж байна. Нөгөө талаасаа шахааны бизнесийг зогсоож, эдийн засгийн тэмцэл хийгээд ирэхээр хүмүүсийн дургуйцлийг их хүргэдэг юм байна. Олон хүний бизнесийг хааж байгаа болохоор яаж сайн байх вэ дээ. Гэхдээ миний зорилго үйлдвэрийг зах зээлийн хүнд үед аваад гарахын тулд төрийн өмчийн үйлдвэрт шинэчлэл хийхийг л зорьж зүтгэсэн. Бодит байдалд анализ хийж ажиллах шаардлагатай байсан. Энэ үйлдвэрийн ашиг сайн байвал улс орон, ард түмэнд л ачтай тустай. Гурван жилийн туршид хөөсөрсөн эдийн засгийг хөрсөнд нь буулгаж, зөв бодлогоор зангидаж ажиллахыг хичээсэн нь олонхид таалагдсан байх аа.

-Энэ олон ажлын байрыг хэвээр хадгалж, улсдаа ч өгөх татвараа цаг хугацаандаа төлөөд явж буйг уг нь төр сайшаах ёстой санагдана.

-Гурван жилд хийсэн эдийн засгийн хэмнэлтийн бодлого, мөн уурхайчдын маань нэмүү бүтээгдэхүүн хийх гэж зүтгэсний хүчинд бид хүнд үеийг даван туулахаар явж байна. Зарим хүн ажил явдгаараа л явж байна гэж хардаг. Үнэндээ бол тийм биш. Тухайлбал, нэг тонн зэсийг 6625 ам.долларын өөрийн өртгөөр нь хийчихээд 4800 доллараар зарвал ямархуу хэмжээний алдагдалд орох уу. Гэтэл өнөөдөр компанийн эдийн засаг хэвийн явж байна гэдэг нь менежментийн багийн, уурхайчин хамт олны маань, тэдний надад итгэсэн итгэлийн үр дүн гэж харж байгаа. Эдийн засгийн хэмнэлтийн бодлогыг, менежментийн арга хэмжээ зөв тодорхойлж, цаг алдалгүй ажиллаагүй

бол байдал өнөөдөр хүнд байх байсан. Тэр утгаараа багийн ажиллагааг үнэлэх ёстой. Тэгээд өөрийн эрх мэдлийн хүрээнд зарласан болзлынхоо дагуу удирдлагын багийн хүмүүсээ шагнасан. Хэмнэвэл шагнана, үр дүн гаргавал урамшуулах болзол зарлаж ажилласны үр дүнд манай үйлдвэр энэ хүнд үед хэвийн ажиллаж байгааг дахин хэлмээр байна. Удирдлагын зүгээс зарласан ажлаа дүгнэж, шагнаж, урамшуулах ёстой. Гэтэл үүнээс болж, дарга нараа их мөнгөөр шагнасан гэх яриа гарсан байгаа.

-Манай улсын төрийн өмчийн том үйлдвэрүүдийн захирал хэл ам ихтэй албан тушаалууд. “Эрдэнэт” үйлдвэрийн захирал ч адил. Байнга л хардлага сэрддэг, дарамт шахалт, асуудалтай. Сүүлийн үед Оюутолгойтой Эрдэнэтийг харьцуулах болж. Төрийн томчууд Оюутолгойн захирал руу утас цохиж чадахгүй. Тэгвэл “Эрдэнэт” үйлдвэрийн удирдлага руу дуртай цагтаа ярьдаг гээд л. Танд хэцүү байна уу?

-Уг нь адилхан л гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд. Эрдэнэтийн хувьд Монголын тал 51 хувийг эзэмшдэг учраас захирлын томилгоо, үүрэг даалгавар өгөхөд ойрхон, эрх мэдэл нь байна. Оюутолгойн 34 хувь Монголын мэдэлд байдаг учраас төрөөс гүйцэтгэх удирдлагыг томилох боломжгүй. Үүгээрээ том ялгаатай. Монголын төрөөс томилогдож очоогүй учраас улс төрийн, өөр шахалт дарамтад байх боломжгүй. Зөвхөн хууль л дагана.

Шахааны бизнес, хөөсрөлт, хүнд суртлыг зогсоох, улс төрийн нөлөөллийг багасгах тал дээр би болон төрийн удирдлагууд бүгд санал нэгтэй байсан. Ерөнхий сайдаар Н.Алтанхуягийг байхад би томилогдсон. Энэ бүгдтэй тэмцэнэ шүү гэж л хэлж байсан. Өнөөдрийн Ерөнхий сайд, Их хурлын дарга нар ч санал нэгтэй байгаа. Тиймээс ийм бизнестэй тэмцэхэд эерэг нөлөө үзүүлсэн. Яаж өөрийн өртгийг нь бууруулах уу, 10 төгрөгөөр авдаг зүйлийг үйлдвэрт 30 төгрөгөөр өгдөг асуудлыг л болиулах гэж зүтгэсэн. Миний талхаар оролдоод байвал чамаар оролдсон шиг оролдоно шүү гээд загнуулж ч байсан. Зарим нь сүрдүүлж дарамтална, нэг хэсэг нь өвчин зовлон ярьж ирнэ, нөгөө нь ийм ч тийм ч арга хэмжээ хийх гэж байгаа тусалж дэмж гэнэ. Дэлгүүрээс бараа худалдаж авч байгаа юм шиг сэтгэхүйгээр олон жил явчихсан учир тэр нүдээрээ хараад байдаг юм байна.

Оюутолгой орд дээр орчин үеийн, менежмент нь өөр гээд олон зүйл яригдана. Инженер ажилтнууд нь манай хүмүүсээс хэд дахин илүү цалин, хангамжтай. Оюутолгойгоос геологич авчрахад “Би Оюутолгойгоос тав дахин бага цалин авч байна. Зөрүүг яах вэ” гэж асууж байх жишээтэй. Тэгэхээр нарийн мэргэжлийн хүмүүсдээ сайн цалин, ►

10 төгрөгөөр авдаг зүйлийг үйлдвэрт 30 төгрөгөөр өгдөг асуудлыг л болиулах гэж зүтгэсэн. Миний талхаар оролдоод байвал чамаар оролдсон шиг оролдоно шүү гээд загнуулж ч байсан.

► урамшуулал өгч байж л тэднийг тогтоон барьж, үйлдвэртээ ажиллуулна. Хүн бүрийн хийдэггүй ажил манай компанид олон бий. Оюутолгой нь улс төрийн нөлөөлөлгүй учир дотоод сахилга бат, дэг журам өндөр байж чадаж байна. Гэтэл манай ажилтнууд олон захирлын нүүр үзсэн хүмүүс. Намуудад элсчихсэн, лоозон бариад гүйдэг олон хүн байдаг учир асуудалд намын өнцгөөс харж эсэргүүцнэ. Бизнес шахааны компаниудын төлөөллүүд ч байдаг тул дотроосоо гадагш мэдээлэл тараагаад явж байна. Нэг талдаа олон хүний ажлын байрыг хадгалж, тэжээж байгаа ч нөгөө талдаа олон хүнийг нэг удирдлагаар зангидаж ажиллана гэдэг тийм ч амар биш, хүнд асуудал байдаг.

Атаа жөтөө ч их бий. Тэр агаархал дээр нь тоглож, танай дарга төдөн төгрөгийн цалин авдаг гэнгүүт нөгөөдүүл нь хэл ам хийнэ. Ингээд ирэнгүүт үйлдвэрийн ажил доголдоно, тэгэхээр нь өнөөдрийн удирдлагын баг ажиллаж чадахгүй байна хэмээн яриад эхэлнэ гэсэн иймэрхүү улс төрийн зорилготой, явуургүй үйлдэл байхыг үгүйсгэхгүй. Өмнө нь далд бизнес, эдийн засаг яваад байна гэж ерөнхий ярьдаг байсан болохоос биш нэр зааж ярьдаггүй байлаа. Өндөр үнэтэй шахааны бизнес хийгээд маш их ашиг олж амьдраад байхад асуудал ярьдаггүй байсан. Харин тэр бүгдийг ил тод болгоод болзлынхоо дагуу хүмүүсээ урамшуулчихаар ийм яриа гаргаж байна. Энэ чинь хоёр өөр асуудал.

Нэг хэсэг нь ил тод шударгаар хүмүүсээ шагналаа гэхэд нөгөө нь ямар том шагнал вэ, юу хийсэн гэж гээд агаархлын нүдээр харж байна. Хүн бүр өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ өөр өөр түвшинд ажиллаж, түүндээ тохирсон цалин, урамшуулал аваад амьдраад явдаг шүү дээ.

-Ажилчдын цалин буурсан уу?

-Буураагүй. Удирдлагын багийн шагнал урамшууллын тухай яриад байна. Үүний цаана гурван жилийн хугацаанд би 22,5 тэрбум төгрөгөөр ажилтнуудаа шагнасан. Шахааны бизнесийг багасгаж, хэмнэсэн мөнгөөрөө ажилчдаа шагнасан. Гэтэл цалингаас гадна яагаад ийм мөнгө ажилтнууддаа өгөв гэдэг асуудлыг хэн ч ярихгүй байгаа юм. Цалинг 2013 онд арав, 2014 онд 10 хувиар нэмсэн. Зэсийн үнэ унасан, эдийн засаг хүндхэн нөхцөлд манайх цалингаа нэмсэн. Өнгөрсөн онд цалинг өсгөөгүй ч ажилчдын гар дээр ийм хэмжээний мөнгөн урамшуулал өгсөн.

-Дэлхий дээрх ижил төстэй үйлдвэрүүдийн шагнал урамшуулалтай харьцуулахад “Эрдэнэт” үйлдвэрийн цалин, хангамж, урамшуулал нэлээд бага байдаг юм биш үү? Та хэр өндөр шагнал өгсөн гэж бодож байгаа вэ?

-Миний хувьд өндөр урамшуулал өгсөн гэж үзэхгүй байна. Ижил төстэй үйлдвэрүүдийн бизнес,

үйл ажиллагааг байнга судалж, туршлага судалж, харж байна. Тэдний удирдлага, ажилтнууд, нарийн мэргэжлийн хүмүүсийн цалин, урамшуулал үнэхээр өөр, өндөр түвшинд яригдана шүү дээ. Хойд хөршүүд ч өөр болсон. Манай 49 хувийг эзэмшдэг ОХУ болон орос ажилтнууд энэхүү шагналыг яаж хүлээн авч байна вэ гэхээр тэд “Бид хамтарсан хөрөнгө оруулалттай компанид маш бага цалингаар ажилладаг. Оросод нарийн мэргэжлийн хүмүүс хэд дахин өндөр цалин авдаг шүү” гэж байгаа юм. Миний Нэгдүгээр орлогчоос эхлээд орос мэргэжилтэн олон бий.

-Төрийн өмчийн үйлдвэр, компаниудын ийм л сул талыг арилгах, чадвартай болгох зорилгоор “Эрдэнэт Монгол” компани ажиллалаад байгаа гэж би ойлгож байгаа.

-Засаглалыг сайжруулах тал дээр компаниудын бие даасан байдлыг сайн хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах, мөн улс төрийн нөлөөллийг бага байлгах ёстой. Төрөөс цалинждаг байгууллагуудад шилэн данс үйлчлэх нь зөв. Харин манайх шиг зах зээлд өрсөлддөг, өөрөө баялаг бүтээдэг, төсвийг бүрдүүлдэг компани дээр бодолцох ёстой. Зах зээлд өрсөлдөж буй компаниуд эдийн засгийн сайн хөшүүрэггүйгээр явахгүй. Сайн хөшүүрэг, сайн урамшуулал, сайн болзолтой байж хүмүүсийг ажиллуулна.

Монгол дахь уул уурхайн гадаад зөвлөхүүд маш өндөр цалинтай ажилладаг. Гадаадын мэргэжилтнүүд техник, эдийн засгийн үндэслэлийг хэдэн сая ам.доллараар боловсруулдаг. Гэтэл монголчууд яг адилхан төслийг маш бага мөнгөөр гүйцэтгэдэг. Хүнийг үнэлэх үнэлэмж, чадвар өөр байна. Төрийн өмчийн компаниуд компани шиг ажиллаж байж ашгийн тухай ярина. Төр, хувийнх ялгаагүй шүү дээ.

Миний хувьд улс орноо хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж яваа том үйлдвэрийг удирдан ажиллаж байгаагаараа бахархдаг. Мөн үйлдвэрийг зөв аргаар ажиллуулах зорилго дээр ойлгож хамтарч ажиллаж байгаа хамт олон, багаараа бахархаж байна. Харин улс төрийн үүднээс хагарал зөрчилдөөн үүсгэж, хүмүүст буруу ойлголт өгч байгаад харамсаж байна.

“Эрдэнэт үйлдвэр” өгөөжгүй байсан гэвэл утгагүй

-“Эрдэнэт үйлдвэр” улсын хөгжилд цаашид олон жил хувь нэмэр оруулсаар байх нь тодорхой. Одоо Оюутолгой, Тавантолгойн талаар ярьсаар л байна. Салбарын мэргэжилтний хувьд ирээдүйг хэрхэн харж байна вэ?

-Сүүлийн үед уул уурхайн салбар руу хэтэрхий улстөржсөн байдлаар хандаж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын ихэнх нь уул уурхайн салбарт л орж ирсэн байдаг. Ер нь цаашдаа ч гадаадын хөрөнгө оруулалт түлхүү энэ салбарт чиглэх байх. Ингэж байж цааш хөгжинө. Үүний тодорхой жишээ нь манай үйлдвэр. Хамгийн гол нь “Эрдэнэт” мөнхийн биш. Тус орд газрыг зөв ашиглах ёстой. Ашигтай ►

Цаашдаа зөвхөн зэсийн баяжмал биш, эцсийн бүтээгдэхүүн хийх, зэс хайлуулах болон хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнүүдийг нийлүүлдэг үйлдвэрүүдийг барьж байгуулах хэрэгтэй.

► ажиллаж байх үед нь эдийн засгийн хүртээмжийг зөв хуваарилж, бусад салбарыг хөгжүүлэх нь чухал юм. Манай компанийн хувьд зөвхөн ашигт малтмал гаргаад л орлого олоод байх асуудал биш шүү дээ. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, уурхай дагасан үйлдвэрүүдээ хөгжүүлэх, уурхайн нөөц дуусахад түүнийг дагасан уул уурхайн үйлдвэрлэл мөн олон жижиг, дунд үйлдвэрлэл бий болчихсон байх ёстой. Эдгээр асуудлыг уурхайн хаалт хөгжлийн менежментээр төлөвлөж хийх шаардлагатай. Тиймээс сүүлийн үед хаалт хөгжлийн менежментийн тухай нэлээд ярьж байна.

-Та Эрдэнэт хотын ирээдүйг хэрхэн төсөөлж байна вэ?

-Уурхайн нөөцийг одоогоор 30-40 жил гэж тодорхойлж байгаа. Гэхдээ технологийн болон хөрөнгө

хуваагаад идчихсэн үү, эсвэл хүн амьдрах орчныг бүрдүүлсэн үү. Таван их наяд төгрөг авч идчихээд “Эрдэнэт” үйлдвэр өгөөжгүй байсан гэвэл утгагүй. Тэгэхээр уул уурхайн ордуудыг зөв бодлогоор зөв ашиглаад газар доорх баялгийг харамлахдаа гол нь биш эргэлтэд оруулж, өгөөжийг нь улс орон, ард түмэндээ хүртээгээд сайхан хөгжөөд явах ёстой.

-Зэс хайлуулах үйлдвэрийг “Эрдэнэт хотод барих ёстой. Уурхайн нөөц дуусахад зэс хайлуулах үйлдвэр баригдчихсан, хотыг цааш нь аваад явах нь зөв хувилбар гэх хүмүүс байдаг. Та ямар бодолтой байгаа бол?

-Зэс хайлуулах үйлдвэрийг Бор-Өндөрт байгуулахаар болсон нь Засгийн газрын шийдвэр. Би зөв гэж харж байгаа. Учир нь Эрдэнэт бол Орхон, Сэлэнгийн



Ц.Даваацэрэн: Хэмнэвэл шагнана, үр дүн гаргавал урамшуулна

оруулалтын бодлогоо зөв авч явах ёстой. 40 жилийн нөөц байгаа ч түүнийг олборлож чадах уу гэдэг асуудалтай. Технологи, эдийн засгийн үр ашгийн хувьд байнга үр өгөөжтэй байж чадах уу.

Ер нь дэлхий дээрх зэсийн үнэ ямар байхаас ашиг орлого нь шууд л шалтгаалдаг үйлдвэр. Цаашдаа зөвхөн зэсийн баяжмал биш, эцсийн бүтээгдэхүүн хийх, зэс хайлуулах, хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнүүдийг нийлүүлдэг үйлдвэрүүдийг барьж байгуулах хэрэгтэй. Энэ тохиолдолд уурхайн нөөц дууслаа ч суурь бааз дээр тулгуурлан хот цааш хөгжих боломжтой болно. Уул уурхайгаас хамааралгүйгээр хот цааш хөгжинө гэсэн үг. Ашигт малтмалын орд газрыг улс орондоо, эдийн засагтаа зөв шингээж авч үлдэхийн тод илрэл нь энэ болох юм.

Манайханд өнөөдөр нэг айдас бий. Үйлдвэрийг зогсохоор бүх зүйл зогсоно. Ухсан нүх л үлдэнэ гэж. Одоо харин ч ашигтай ажиллаж байх үедээ улсад өгсөн өгөөжөөр юу хийсэн бэ гэдэг асуулт гарна. Ашгийг

сав газрын бүс. Усны эх газар, байгаль орчны хувьд их эмзэг бүс. Тэгээд ч усны эх газарт Урт нэртэй хууль үйлчилдэг. Тэгэхээр ойн бүс, байгаль экологийн эмзэг газарт хүнд үйлдвэр барих нь эрсдэлтэй. Ийм эрсдэлийг сайтар бодолцох ёстой. “Эрдэнэт” үйлдвэр өнөөдөр цагаан тоосныхоо асуудлыг бүрэн шийдэж чадаагүй л байгаа, шийдэхийн төлөө багагүй мөнгө зарж, ажиллаж байна.

Нэг талдаа металлургийн хайлуулах үйлдвэр, нөгөө талдаа химийн үйлдвэр шүү дээ. Зэс хайлуулах үйлдвэрээс маш их хүхрийн хүчил, химийн бодис гарна. Үүнийг яах вэ гэдэг нь асуудалтай. Манайхан их амар зүйл ярьдаг. Хөвсгөлөөс фосфорит авчраад хүхрийн хүчил хоёрыг холиод бордоо хийчихнэ гэж. Энэ нь маш нарийн технологи. Фосфорит, хүхрийн хүчлийг холиод бордоо хийнэ гэвэл химийн өөр нэг үйлдвэр барих болно. Зэс хайлуулах үйлдвэрээс ганцхан хүхрийн хүчил гарахгүй. Төмрийн агуулгатай хаялгал шаар их гарна. Тэр шаараар барилгын материал, ►

► эсвэл овоолго хийх үү гэх мэтчилэн олон асуудал зэс хайлуулах үйлдвэрийг дагаад яригддаг. Экологигоос хамааралтай химийн асуудлуудыг яах вэ гэдэг нь хамгаас чухал. Тийм учраас Бор-Өндөр нь Эрдэнэтийг бодвол ой хээрийн бүс тул экологийн эмзэг талдаа харьцангуй гайгүй бөгөөд хүхрийн хүчлийг жоншны бүтээгдэхүүнүүдтэй холиод хөнгөн цагааны түүхий эд, фторт устөрөгч гэх мэт хоёр дахь түүхий эдүүдийг хийх боломжууд байгаа юм.

Жоншны тархац ихтэй бүс нутгийн давуу тал нь энэ. Жоншны баяжмалаар хөнгөн цагааны түүхий эд хийдэг. Технологи нь ч бий. Экологийн хувьд эмзэг биш, эрсдэл бага, зэс хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн хүчил нь дараагийн зах зээлдээ ойрхон зэрэг давуу тал Бор-Өндөрт бий.

Уул уурхайн ордуудыг зөв бодлогоор зөв ашиглаад газар доорх баялгийг харамлахдаа гол нь биш эргэлтэд оруулж, өгөөжийг нь улс орон, ард түмэндээ хүртээгээд сайхан хөгжөөд явах ёстой.

Хэрэв хүхрийн хүчлээр ямар нэг бүтээгдэхүүн хийж чадахгүй бол Хятад руу л экспортлох болно. Зах зээл тэнд бий. Эрдэнэтээс вагоноор, эсвэл Бор-Өндөрөөс тээвэрлэх үү гэдэг асуудал бас байгаа юм.

Намайг Бор-Өндөрт ажиллаж амьдарч байсан болохоор зэс хайлуулах үйлдвэрийг тэнд бариулахаар яваад байна гэсэн мэдээлэл явдаг. Би хаана ажиллаж амьдарч байгаагаас илүүтэй улс орны эрх ашиг, байгаль экологийн зүй тогтол чухал шүү дээ. Хүнд таалагдахын тулд Эрдэнэтэд барих нь зөв гэж яриад байж болно. Гэхдээ барьсны дараа улс түүнээс хэд дахин илүү хохирол хүлээхээр байгааг анхаарах хэрэгтэй.

Сэтгэ, бод, нэвтрүүл, урамшуулна

-“Эрдэнэт” үйлдвэр хир инновацлаг хамт олон бэ? Хамгийн шилдэг, инженер, мэргэжилтнүүдтэй компани гэж бид ойлгодог.

-Дэлхий нийтээрээ инновацм гэж ярих болж. Манай улс ч хууль, дүрэмтэй. Инновацийг хөгжүүлэх боломж, шаардлага ч байна. Бид инновацийг хөгжүүлэх талд нэлээд ажил зохион байгуулаад явж байна. Санасан хэмжээнд хүчтэй өрнөхгүй байгаа ч амжилттай. Жил бүр 1000 инженерийн зөвлөгөөн хийдэг. Гол зорилго нь сэтгээч, бодооч, ажлын туршлага, оюуны чадамжаа үйлдвэртээ шингээгээч гэж байгаа юм.

Тэдний оюуны санааг үйлдвэртээ авч ашиглаад байвал байгууллагын ажил сайжирч, өнгө үзэмж сэргэж улам сайхан болно. Оюуны өмчийн шинэ санаанд мөнгө төлөх ёстой. Сэтгэ, бод, нэвтрүүл, урамшуулна. Энэ зарчмыг нэвтрүүлэхийн төлөө хичээж ирлээ. Оюуны өмчийн газартай хамтран ажиллаж байна. Тус газартай хамтран ирэх сард 1000 инженерийн зөвлөгөөнөө хийнэ. Сайн инноваци гаргасан хүмүүсдээ сайн урамшуулал өгнө. Өнгөрсөн жил шилдгүүдийг шалгаруулж, шилдэг инноватор цом өгсөн. Хэд хэдэн

төсөл гарсан. Төслүүдийг санхүүжүүлэх ажил ч эхэлчихсэн явж байгаа.

-Уулын баяжуулах үйлдвэрийн орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр мөн л их. Энэ талаар тодруулах уу?

-Орхон аймгийн төсвийг бүрдүүлж байна. Аймгаас зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцдог. Орхон аймгийн удирдлагатай урт хугацааны хамтарч ажиллах гэрээ байгуулсан. Жил бүр гэрээгээ дүгнэж, юу хийх талаараа ярилцаж, төлөвлөөд явдаг. Аймгийн зам засварт оролцож, техникийн туслалцаа үзүүлнэ. Булган аймгийн удирдлагатай мөн л хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Орон нутгийг хөгжүүлэх, ард иргэдийн аж амьдралыг сайжруулах талд хамтарч дэвжихийн төлөө явдаг. Тиймээс “Эрдэнэт” үйлдвэрийн орон нутаг дахь хаялга маш их.

Бид Сэлэнгийн сав газраас усаа авдаг. 60 км орчим газраас гэсэн үг. Булган аймагт ус дамжуулах хоолой байрлаж буй газрын татвар, ашигласан усны татвар, зарим объект Булганы нутаг дээр байрладаг тул газар ашигласны төлбөрөө өгнө.

-Танай компани ойрын хугацаанд ямар ажил хийхээр төлөвлөсөн бэ?

-Дулааны цахилгаан станцын өргөтгөлийг хийхээр ажиллаж байна. Энэхүү станцаа 48 Мв болгож, өргөтгөх зураг төслийн ажил ид явж байна. Өнгөрсөн жил тендер зарлаад шалгаруулсан. Тус бүр нь 12 Мв-ын дөрвөн турбин суурилуулах юм. Эрчим хүчний үйлдвэрлэл, эх үүсвэр нэмэгдэх ач холбогдолтой. Мөн дотоодын хэрэглэнийхээ 30-40 хувийг өөрсдөө үйлдвэрлэх, өртөг зардлаа бууруулах боломжтой болно.

Түүнчлэн удахгүй компанийн хөрөнгө оруулалтаар барьсан Эмчилгээ оношлогооны төвийн нээлт Эрдэнэтэд хотод болно. Үйлдвэрийн бүс нутагт амьдарч буй иргэдийнхээ эрүүл мэндэд оруулж буй том хөрөнгө оруулалт гэж үзэж байгаа. Орчин үеийн техник технологи бүхий энэ эмнэлгийг Япон менежментээр ажиллуулахаар төлөвлөж, Япон улсдаа олон эмнэлгийн менежментийг хэрэгжүүлсэн байгууллагатай хамтарч ажиллахаар гэрээ байгуулсан. Монголчуудын гадагш явж эмчлүүлэх урсгалыг сааруулах, иргэддээ чанартай, өндөр технологийн эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх зорилготой эмнэлэг байгуулахыг хүссэн. Зөвхөн Орхон аймаг бус, бүс нутгийн хэмжээнд оруулж буй бодитой хөрөнгө оруулалт, нийгмийн хариуцлага юм.

-Оросуудтай ажиллахад ямар байдаг вэ?

-Хамтарсан үйлдвэр. Компанийн бүх дүрэм журмыг Монгол-Оросын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр зохицуулдаг. Хэлэлцээрт Монгол Улсын хууль дүрмийг чиглэлээ болгож баримталж ажиллана гээд заачихсан байдаг. Оросын 300 гаруй мэргэжилтэн гэрээгээр ажилладаг. Гэр бүл, үр хүүхэд нийлээд 500 гаруй хүний эрх ашгийг бид хамгаалж, бүрдүүлж ажиллах нь зүй ёсны хэрэг юм. Хувьцаа эзэмшигчийн хувьд иргэдээ ажиллуулахыг хүсэх нь мэдээж. Харилцан ойлголцож, зөвшилцож, биенээ дэмжээд, хүндлээд ажиллах хэрэгтэй л дээ. Бидний хувьд ганцхан өөрсдийгөө бодож улстөржөөд байж болохгүй. Оросын талын эрх ашиг гэж байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй. ■

“Mongolian Economy”-Гүнзгий мэд



Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн “2013 оны Шилдэг сэтгүүр”

Монголын бизнесийн зөвлөлийн

“Бизнесийн салбарын дэмжлэг хэвлэл мэдээллийн шилдэг байгууллага - 2012”

МУХАУТ-ЫН “Хэвлэлийн салбарын Оны онцлох Entrepreneur-2011”

www.mongolianeconomy.mn

Бизнес хөгжлийн концепци

Уурхай хаагдвал...

Б.ЭНХЦЭЦЭГ

Эрдэнэт үйлдвэр нэг л өдөр илбэдүүлсэн мэт алга болчихлоо гэж төсөөлье л дөө. Хэрэв ингэвэл Эрдэнэт хот нэн тэргүүнд ундны усгүй болж, бохир нь хальж, багш, цагдаа гэх мэт төрийн үйлчилгээний олон албат цалингүй болж, орон нутгийн төсөв төрийн толгой дээр бууж ирнэ. Энэ бол зөвхөн Эрдэнэт хотын хэмжээн дэх багахан төсөөлөл.

Уул уурхайг ашиглах тал дээр хоёр гараа бараг хөлтэйгээ нийлүүлэн өргөн дэмждэг эрдэнэтийнхэн уурхайн хаалт гэх үгэнд дургүй. Энэ үгийг хэлэхэд тэд ихээхэн эмзэглэж хүлээж авдаг. 1978 оноос хойш олборлож ирсэн Эрдэнэтийн-Овоо ордын баялаг дундарч өдгөө цаашид ашиглах хугацааг 30-40 жил гэж тооцож буй. Энэ богино хугацаа биш ч гэлээ тус үйлдвэрээр тэжээгддэг Эрдэнэт хотын хувьд ганцаар алхах цаг ойртсоны дохио.

Монгол улсын гурав дахь хот Эрдэнэтэд 100 мянган хүн оршин суудаг бөгөөд эдийн засаг нь Эрдэнэт үйлдвэртэй бараг хүйн холбоотой гэж болохоор өндөр хамааралтай. 2014 оны байдлаар Орхон аймгийн төсвийн 83.5 хувийг Эрдэнэт үйлдвэрийн төлсөн татвар, төлбөр бүрдүүлж байна. Эрдэнэт үйлдвэр ХХК нь 2010 онд түүхэндээ хамгийн их буюу 624 тэрбум төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төлжээ. Энэ бол улсдаа ч тэр, орон нутагтаа ч тэр цойлсон үзүүлэлт. Мөн тус үйлдвэрийн эрчим хүчний цех нь Сэлэнгэ мөрнөөс буюу 64 километрийн цаанаас, шугамаар дамжуулан Эрдэнэт хотын ард иргэдийг ундны усаар хангадаг. Үүний зэрэгцээ Эрдэнэт хотын бохир усыг үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаар оруулан цэвэрлэдэг. Энэ нь бүс нутгийн

нийгэм, эдийн засагт Эрдэнэт үйлдвэрийн хаалттай холбоотой эрсдэл онцгой үр дагавартай болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, Эрдэнэт үйлдвэр хаагдвал иргэдийн анхдагч хэрэгцээнд суурилсан дээрх хоёр зардал аймгийн төсвийн “нуруунд” бууна гэсэн үг.

Иймд уурхайн төлөвлөгөөт болон болзошгүй гэнэтийн хаалттай холбоотой цочирдол үүсгэхгүйн тулд уг хамаарлыг урт хугацаанд бууруулах, Эрдэнэтийн эдийн засгийг төрөлжүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий. Товчхондоо, Эрдэнэт хотын ирээдүйг одооноос зураглаж, хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзганд хүргэхгүй аваас 40 жилийн дараа уурхай хаахад балгасаар дүүрэн хот болох эрсдэлтэй. “Уурхай хаагдахад хүмүүс нь яваад “Сүнстэй хот” болгочихгүйн төлөө, амьтай байлгахын төлөө одооноос ажлууд хийж байна” гэж Эрдэнэт үйлдвэрийн Хөгжлийн хэлтсийн дарга П.Ганбат хэлж байна. Уурхайд хөтлүүлж хөгжөөд эцэстээ баялаг нь дуусаад уурхай хаагдахад иргэд нь дайжиж хэдэн өгөр барилгатай үлдсэн сүнстэй хотууд дэлхий даяар цөөнгүй. Тэдний нэг болгохгүйн тулд Эрдэнэтэд хийх ажил их бий.

Эрдэнэт үйлдвэрийн шинэ удирдлагын багийн дэвшүүлсэн есөн зорилтын нэг нь Хаалт-хөгжлийн бодлого юм. Уг зорилтын хүрээнд Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм эдийн засаг дахь нөлөөллүүдийг уурхайн хаалт, бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлуудын цар хүрээнд судалж эхлээд байна.

Өнгөрсөн арван жилд хоёр удаа хөгжлийн концепци боловсруулсан байдаг. 2005-2015 оны концепцийн гол зорилго



► рилго нь баяжуулах фабрикийн хүчин чадлыг хэвээр хадгалж, зэсийн баяжмал, бага агуулгатай болон исэлдэлт өндөртэй хүдрийг гидрометаллургийн аргаар боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оршиж байсан. Харин 2010-2015 онуудад (2020 он хүртэл) хөгжүүлэх концепцийн шинэчлэгдсэн төслийн зорилго нь үйлдвэрийн тоног төхөөрөмжийг цахилгаан эрчим хүч бага зарцуулдаг, орчин үеийн шинэ техник-технологи нэвтрүүлэн сайжруулж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөх замаар нэгж бүтээгдэхүүний зардлыг бууруулахад оршино. Харин дараагийн буюу 2016-2025 онд хөгжүүлэх концепцийг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа, хүний нөөц, нийгмийн цехүүд болон хараат компаниудыг хамруулах замаар бодлогыг цогц байдлаар шийдвэрлэнэ. Тус концепци нь Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандарттай нийцүүлэн уурхайн тогтвортой хөгжил, хаалтын менежментийн төлөвлөгөөг оруулж байгаагаараа түрүүчийн концепцидаас нэлээд онцлогтой.

Эрдэнэт үйлдвэрийн зүгээс нийгэмд зориулан зарцуулж буй зардал өндөр бөгөөд жил бүр өссөөр байгаа нь дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ унаж буй үед компанийн бизнест дарамт учруулж байна. Тухайлбал, 2014 онд тус үйлдвэр нийгмийн зардалдаа 70.2 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд үүний 23 тэрбум нь буюу 33 хувийг нийгмийн цехүүдийн зардал эзэлж буй. Түүнчлэн зэсийн үнийн мөчлөгийг дагаж компанийн нийгмийн зардал нэмэгдэж, буурч байх нь компанид болон орон нутагт олон талын шууд болоод шууд бус сөрөг нөлөөллүүд бий болгох эрсдэлтэй тул үүнийг урт хугацаанд оновчтой шийдвэрлэх тогтолцоо шаардлагатай. Эрдэнэт үйлдвэрийнхний зүгээс зарим нийгмийн цехүүд тухайлбал, Уурхайчин соёлын ордон, “Сэлэнгэ” амралтын бааз, Эмнэлэг сувиллын цогцолбор, Спорт ордон тэргүүтэй байгууллагуудыг менежментийг нь одооноос зөв хийгээд явбал бүрэн биеэ даах боломжтой гэж үзэж буй. Нийгмийн цехүүд Эрдэнэт үйлдвэрээс 90 хувь орчим тагаас авч байгаа бөгөөд нийт зардалд цалин 57 хувь, элэгдэл 12.4 хувь эзэлж байгаа бөгөөд нийлээд тогтмол зардал 70 хувьтай байна.

“Өрсөлдөх чадварын хүрээлэн” судалгааны байгууллагын гаргасан тайланд сүүлийн жилүүдэд байнга аймгууд дундаа тэргүүлж буй Орхон аймгийн Эрдэнэт хотын дэд бүтэц Эрдэнэт үйлдвэрээс хэт хамааралтай байгааг онцолжээ. Мөн хотын ус хангамж, цэвэрлэх байгууламж зэрэг дэд бүтцийн зардлаа хот өөрөө дааж чадахгүй байгаа нь уг эрсдэлийг улам нэмэгдүүлж байгааг дурдсан байдаг. Бүс нутгийн нийгэм, эдийн засаг Эрдэнэт үйлдвэрээс өндөр хамааралтай болох нь харагдаж байна.

Эрдэнэт үйлдвэр нь импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бизнесийг дэмжих замаар Орхон аймгийн эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн санаачлагын хүрээнд молибдений баяжмал боловсруулах, цэвэр зэс үйлдвэрлэх, амны хаалтны, төмөрлөгийн цогцолбор үйлдвэр, түүхий резин, резин бүтээгдэхүүний үйлдвэр, нано технологийн даавууны үйлдвэр, лед гэрлийн үйлдвэр зэрэг олон жижиг, дунд үйлдвэрийг дэмжин ажиллаж байна. Эрдэнэт үйлдвэрийг хаагдахад дагаад унах бизнес байгаа ч учраа олоод цааш явчих бизнесүүд Эрдэнэтэд эхнээсээ бий болж буй. Тухайлбал, тус үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар боссон “Эрдэнэт медиал” эмнэлэг нь санхүүжилтээ эргэн төлөх нөхцөлтэйгээр бие даасан үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

“Эрдэнэт үйлдвэрээс хамааралгүйгээр хөгжиж болох бизнесүүдийг дэмжих замаар зэрэгцээ эдийн засгийг бий болгохоор зорьж байна. Мөн ирээдүйд үйлдвэр хаасан ч биеэ даагаад хөгжөөд явах үйлдвэрийн харьяа нэгжүүдээ дэмжинэ” гэж Ганбат дарга хэлсэн юм.

Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захирлын 2015 оны тавдугаар сарын 26-ны тушаалаар уурхайн тогтвортой хөгжил, хаалт, байгаль орчны дэд хэсэг байгуулагдан ажиллаж, уурхайн хаалт-хөгжлийн бодлогыг тодорхойлон, түүний хүрээнд концепцид тусгах асуудлуудыг одоогоор боловсруулж байна.

Уурхайн Тогтвортой хөгжил, хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгагдах гол асуудлууд

Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн бааз суурийг ашиглан бие даасан шинэ бизнесүүд хөгжүүлэх

Орхон аймгийн эдийн засаг эрдэнэт үйлдвэрээс хамаарч байдаг шууд нөлөөллийг бууруулах

Орон нутгийн бизнесийн санаачлагуудыг бодлогоор дэмжих замаар Орхон аймагт Эрдэнэт үйлдвэрээс үл хамаарсан “зэрэгцээ” эдийн засгийг хөгжүүлэх

Орхон аймаг, Эрдэнэт хотын суурь дэд бүтцийн бие даасан байдлыг хангах

Байгаль орчин, хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой төслүүд

Уурхайн хаалттай холбоотой нийгмийн асуудлуудыг тодорхойлох

Бусад томоохон төслүүдийг санхүүжүүлэх тогтвортой хөгжлийн сан байгуулах

Дээрх ажлын хүрээнд хамруулах томоохон төслүүдийг дурдвал, Эрдэнэт хаагдсан ч Засвар механикийн заводыг Уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэгийн үндэсний хэмжээний томоохон үйлдвэр болгох нь онцгой ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн Шинжлэх ухаан-үйлдвэрлэлийг хослуулах замаар Эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци, зураг төслийн хүрээлэн байгуулах. Үүний зэрэгцээ Уурхайн тогтвортой хөгжил, хаалтын менежментийн төлөвлөгөөнд байгаль орчин, нөхөн сэргээлттэй холбоотой төслүүд багтах аж.

Уурхайн нөөцийнхөө тал хувийг нь ашиглаж буй Эрдэнэт үйлдвэрийн хувьд ашигтай ажиллаж байгаа үедээ хаалт-хөгжлийн сангаа бүрдүүлж эхлэх зайлшгүй шаардлага тулгараад байна. Энэхүү хөгжлийн санг компанийн ашиг, охин ба хараат компаниудын ногдол ашиг, технологийн бус хүдрийн овоолгуудыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар үүсэн бий болох хуримтлал болон бусад эх үүсвэрээс бүрдүүлнэ гэж үйлдвэрийн мэргэжилтнүүд үзэж байна.

Уул уурхайн тогтвортой хөгжил, хаалтын менежментийн урт хугацааны хөтөлбөрийг шинэ Концепцитай уялдуулан, олон улсын түвшинд боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр Эрдэнэт үйлдвэрийг хөгжлийг Орхон аймгийн бодлоготой нийцүүлэн шийдэж байгаа. Эрдэнэт үйлдвэр Эрдэнэт хотыг хөл дээрээ бүрэн зогсол гал алдахгүй явах зорилготой. Сүнстэй хот байх уу, хүнтэй хот байх уу гэдгийг одооноос зураглаж эхлэх нь тус концепцийн гол чиг. ■

“Эрдэнэт” үйлдвэрийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Д.ГАЛБААТАР

Уул-уурхайн инженер-эдийнзасагч, доктор (Ph.D.)

Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр байгуулагдсаны ач холбогдлыг олон өнцгөөс харж, онох онохгүй, ойлгож, мэдэхгүй олон янзаар төсөөлөн бичдэг боловч эрдэнэтчүүдийн бүтээн байгуулалт, ажил хөдөлмөрийн үр дүн, хаашаа ч хөдлөшгүй статистик түүхийн бичиг баримт болон үлдэх болно. Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр байгуулагдсны ач холбогдлыг өргөн утгаар авч үзвэл улс орны аж үйлдвэрийн бүтцэд чанарын өөрчлөлт оруулж, экспорт, импортын хэмжээг үлэмж нэмэгдүүлж, манай орны эдийн засаг, соёлын томоохон төвийн нэг болох орчин үеийн Эрдэнэт хотыг үүсгэн хөгжүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн явдал билээ. Энэ ч утгаар нь “Эрдэнэт” үйлдвэр байгуулагдсаны ач холбогдлыг хэд хэдэн чиглэлээр авч үзэж болно Үүнд:

1. Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжил түргэсч, улс ардын аж ахуйд түүний эзлэх байр суурь өссөн. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн нь “Эрдэнэт” үйлдвэрийг ашиглалтад орохоос өмнө, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 4-5 хувийг эзэлж байсан бол 2015 оны байдлаар 77.0 хувийг эзэлж байна. Өндөр хувь эзэлж байгаа нь сайн хэрэг ч гэхдээ уул уурхайн менежментийг зөв чиглүүлэхгүй бол эрдэс баялгийн үнэ зах зээл дээр унахад манай улс баялгийн хэт хамааралтай орон болсныг харуулж байна. Тийм болохоор боловсруулаагүй эрдэс экспортлох биш, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх тухай саяхнаас Аж үйлдвэрийн яамтай болсноор яригдаж байгаа нь сайн хэрэг.

2. Экспорт, импорт, гадаад худалдааны эргэлт нэмэгдэж Монгол Улсын валютын сан арвижин төсвийн орлогын ихээхэн хувийг бүрдүүлдэг болсон. 1980 онд Монгол Улсын нийт

төсвийн орлого 4.0 тэрбум төгрөг байсан бол, 2015 оны байдлаар 5.97 их наяд төгрөг болж “Эрдэнэт” үйлдвэр нийт төсвийн 5.7 хувийг, зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр хэдий унасан ч гэсэн экспортын бүтээгдэхүүний 12 хувийг бүрдүүлж байна. Өнөөдөр Монгол улсын зэсийн салбарт Эрдэнэтээс гурав дахин илүү валютын орлого олдог Оюу-толгойн улсын төсвийн орлого хангалттай өндөр биш байгаатай харьцуулахад Эрдэнэт үйлдвэрийн улсдаа оруулдаг өгөөжийн үнэ цэнэ цууд мэдрэгдэнэ. Оюутолгойг уг нь Эрдэнэтийн дайтай удирдвал манай улсын валютын сан хөмрөг дорхноо л босоод ирнэ.

3. Өнөөдөр “Эрдэнэт” үйлдвэр аж үйлдвэрийн салбарын хөгжилд түлхэц үзүүлж, ялангуяа төмөр замын тээвэрлэлтийн 10 хувь, эрчим хүчний орлогын 20 хувийг дангаараа бүрдүүлж, импортын бүтээгдэхүүнийг орлох үндэсний жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжихэд бодитой хувь нэмэр үзүүлэн 2015 онд л гэхэд дотоодын компаниудаас 53.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авснаар 2012 онтой харьцуулахад зургаа дахин өссөн байна.

“Эрдэнэт” үйлдвэрийг дагаад түүнтэй үйлдвэрлэлийн болоод технологийн холбоотой шинэ үйлдвэрүүд бий болсон нь “Эрдэнэт”-ийн хэрэгцээг дотоодоосоо хангах нөхцлийг бүрдүүлж эхэлсэн. Дархан хотын хар төмөрлөгийн үйлдвэрээс жилд 24000 тонн ган бөмблөгийн бэлдэц авч ашиглаж байгаа нь тус үйлдвэрийн борлуулалтын орлогын бараг 20 хувьтай тэнцдэг болжээ. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрээс жилд 30.000 тонн шохой, баяжмалын уут, нүүрсний хэрэгцээгээ зуун хувь дотоосоо хангах жишээтэй. Эрдэнэтээс л гэхэд ган бөмбөлөг, түүхий резин, тоосноос хамгаалах амны хаалт гэх мэт нэр

төрлийн бараа материалыг ханган нийлүүлж байгаа нь импортоос олон мянган ам.доллар хэмнэж, дээрх үйлдвэрүүдэд олон арван ажлын байр шинээр үүсэхэд бодитоор нөлөөлжээ.

4. Эрдэнэт хот үйлдвэр дагасан хот болохоор түүний хөгжлийг “Эрдэнэт” үйлдвэргүйгээр төсөөлөхийн аргагүй өнөөдөр Орхон аймгийн төсвийн 85-90 хувийг “Эрдэнэт” үйлдвэр дангаараа бүрдүүлж байна.

5. Уул уурхайн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх нэгэн том уурхай болсны үр дүнд мэргэжлийн боловсон хүчнээр бэхжсэн, хамт олныхоо нийгмийн асуудлыг шийдвэрлэх чадвар бүхий хамт олны хариуцлагатай, ил тод, нээлттэй дэлхийд томоохонд тооцогдох нийгмийн хариуцлагатай уул уурхайн цогц кластерийн үлгэр жишээ болж хөгжссөн түүхтэй гээд бичээд байвал олон зүйлийг тодотгож болно. Гэхдээ энэ бүхнийг зэсийн үнэ 10000 ам.доллар байсан үед биш 2.2 дахин унасан буюу үнийн хямрал дэлхийг бүрхсэн үед амжуулсан тооцоог үндэслэсэн гэж бодохоор үнэхээр эрсдлийг сөрж чадаж буй юм, бид.

Ийнхүү Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр Монголын эдийн засаг, нийгмийн хөгжлийн нэг тулгуур аж ахуйн нэгж болсоор ирсэн бөгөөд цаашид улам тэлэн хөгжиж, түүний эдийн засгийн ач холбогдол өсөн бэхжих төлөв байдал 2013 онд боловсруулсан хаалт хөгжлийн төлөвлөлтөд бодитой тусгагдсан байдаг. Өнгөрсөн хугацаанд “Эрдэнэт” үйлдвэрийн хамт олон өмнөө тавьсан зорилтоо амжилттай биелүүлж, орчин үеийн өндөр бүтээмжтэй техникээр тоноглогдсон, нарийн технологи бүхий үйлдвэр болж удирдлага зохион байгуулалт, материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан, үйлдвэр болон хөгжиж ▶



► байна.

Үйлдвэр байгуулагдаж, бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн эхний найман жилд, экспортын жилийн дундаж орлого 117 сая рубль, ашиг 60 сая рубль болж үйлдвэрийн зориулалт бүхий анхны хөрөнгө оруулалтаа нөхсөн байдаг.

Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийн эхний ээлжийг хүлээн авснаас хойш 38 жил болж байна. Энэ хугацаанд нийт 760.3 сая тн хүдэр боловсруулж, 15.5 сая тн зэсийн, 120.8 мянган тн молибдений баяжмал үйлдвэрлэж, улсын болон орон нутгийн төсөвт нийт 9.0 их наяд төгрөгийг төвлөрүүлжээ. Энэ хөрөнгө нь 1978 оны ханшаар тооцоход Эрдэнэт үйлдвэр шиг долоон үйлдвэрийг хоттой нь хамт байгуулах, Оюутолгойд хөрөнгө оруулалтыг тогтвортой байдлын гэрээндээ тусгаж чадсан бол гурван Оюутолгойг барихад хүрэлцэх хөрөнгө гэж бодохоор түүний өгөөж хэчнээн үнэ цэнэтэй болох нь шууд ойлгогдоно.

Энэ их хөгжил, үр дүнд хүрэхэд “Эрдэнэт” үйлдвэрийн гадаад дотоод нөхцөл байдал тийм ч дардан байгаагүй зах зээлийн хуулийг дагаж ямар араншин гаргана түүнийг сөрөн давж ирсэн туршлагатай хамт олон. “Эрдэнэт” үйлдвэрийн хувьд зах зээлийн үнийн уналтын хямрал гурван ч удаа нүүрлээд байна. 1997-1998, 2008-2009 онд тус тус үнэ унаж байсан ч

нэг тонн баяжмал үйлдвэрлэх өөрийн өртөгөөс давж унаагүй, хугацааны хувьд богино байсан ч бүтээгдэхүүнээ олон жилээр барьцаалж зээл авах замаар давж байсан юм. 2011 оноос эхлэлтэй энэ удаагийн нэг тонн цэвэр зэсийн үнийн уналт 10106 ам. доллараас эхэлж (2011 оны жилийн дундаж үнэ 8821 ам.долл.) одоог хүртэл үргэлжилж байна. Өөрөөр хэлбэл үнийн уналт таван жил үргэлжлэх хугацаанд 2.2 дахин доошилсон гэсэн үг. Үүний зэрэгцээ үнийн уналтаас шалтгаалж нэг тонн зэсийн баяжмалын борлуулалтын үнэ худалдан авагч нарын зэсийн баяжмалыг хайлах цэвэршүүлэх зардлаас доогуур тогтоогдох болж АМНАТ-ын тооцооллоос давхар татварын аргаар хоёр давхар алдагдал хүлээх нөхцөл бүрдсэн юм. Энэхүү нөхцөл зөвхөн төрийн данстай “Эрдэнэт” үйлдвэрт л хамааралтай болохоос хувийнхны хувьд дэмжлэг авч хөнгөлөлт эдлэх нь арай илүү.

Тийм болохоор шинэ удирдлагын баг өр зээлд дулдуйдах биш, ханцуйгаа шамлах буюу орлогоо нэмэгдүүлэх, бүсээ чанглах зардлаа хэмнэх бодлогыг стратеги тактик болгон амжилттай хэрэгжүүлж эхэлсэн, түүний үр дүн ч гарсан. Уул уурхайг тэргүүлэх салбар болгосон манай улсын хувьд эрдэс баялгийн үнэ хаашаа савлана түүнээс эдийн засгийн өсөлт бараг шууд шалтгаалдаг гэж хэлж болно. 2011 онд

зэсийн үнэ 8821 ам. доллар байхад эдийн засгийн өсөлт 17.3 хувьтай дэлхийд тэргүүлж байсан бол зэсийн үнэ эрдэс баялгийн үнэ зах зээл дээр унах бүрд эдийн засгийн өсөлт шууд хамааралтай саарч байсан. Жишээ нь: 2012 онд зэсийн үнэ 7950 болоход өсөлт 12.3 хувь, 2013 онд зэсийн үнэ 7326 болоход өсөлт 11.6 хувь, 2014 онд зэсийн үнэ 6859 болоход өсөлт 7.8 хувь, 2015 онд зэсийн үнэ 5502 болоход эдийн засгийн өсөлт 2.5 хувь болж буурлаа шүү дээ, нэг салбараас шууд хамааралтай байхын бодит үр дүн ийм л байдаг. Дэлхийд мөн адил зэсийн салбарт бидний мэдэх Чилийн Salvador, Ministro Hales, Замбийн Fist Quantum, Шинэ Гвинейн Ok-Tedi, Өмнөд Африкийн Palavoga, Канадын Lockerby гээд олон үйлдвэрүүд үнийн уналтаас шалтгаалж үйлдвэрлэлээ зогсоосон. Монголд ч ялгаагүй уул уурхайн ихэнх үйлдвэр ашиг орлогогүй болж цалингаа тавьж чадахгүй хаалгаа барих боллоо. Харин “Эрдэнэт” үйлдвэрийнхэн бид улс болон оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийн зэрэгцээ нэг ч хүний ажлын байрны цомтгол явуулаагүй ба харин ч хэмнэлтийнхээ үр дүнгээс ажилчдынхаа бодит орлогыг сүүлийн гурван жилд 10-20 хувиар нэмэгдүүлж хямралыг боломж болгохоор харж байна.

Үйлдвэр нийгмийн хөгжлийн сангаа бууруулалгүй ахмадуудад тэтгэвэр, тэтгэмж олгох, ажилчдын ►

▶ амралт, сувиллын газар, соёлын болон биеийн тамирын арга хэмжээ, хүүхдийн зуслан, дугуйлангууд ажиллуулах, өнчин хүүхдийн төвийн зардлыг санхүүжүүлэх, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барих, үндсэн хөрөнгө худалдан авах, ажилчдын хоолны үнийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээнд тасралтгүй шийдвэрлэсээр байна. Үйлдвэрийн олон ажиллагсдын орон сууцны асуудлыг шийдвэрлэж, ажилчдын мэргэжлийн сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ үр хүүхдийнх нь сургууль боловсролд ихээхэн хөрөнгө зарцуулж, тэтгэвэрт гарсан эцэг, эхийнх нь оронд ажилд авч байна.

Энэхүү зорилгуудаа хэрэгжүүлэхийн тулд ҮЭ-ийн холбоотойгоо хамтран нийт 12 бүлэг, 116 заалттай хамтын гэрээ байгуулан 2013 онд 98 хувь, 2014-2015 онд 99.1 хувиар биелүүлэн хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд жилд 220 гаруй тэрбум төгрөг зарцуулдаг ба энэ нь үйлдвэрлэлийн нийт зардлын 20 гаруй хувь болж байна. Хамтын гэрээгээр ийм том үүрэг хүлээж түүнийгээ хэрэгжүүлдэг компани өнөөдрийн хувьд Монголд ганцхан “Эрдэнэт” үйлдвэр л байна.

“Эрдэнэт” үйлдвэр ОХУ-ын тоног төхөөрөмж ашигладаг хэрнээ нэг тонн хүдэр олборлох, боловсруулах зардлаа сүүлийн гурван жилд авч хэрэгжүүлсэн орлого нэмэгдүүлэх, зардал хэмнэх бодлогын хүрээнд дэлхийн дундаж үзүүлэлтийг давж, техник технологи, менежментийн хувьд дэлхийн тэргүүлэх үйлдвэрүүдийн түвшинд ойртож очсныг харуулдаг.

Монгол Улсын бахархал, дэлхийн уул уурхайн олборлох салбарын манлай үйлдвэрүүдийн нэг болж чадсан “Эрдэнэт” үйлдвэрийн хувьд хэдийгээр уурхайн уул геологийн нөхцөл хүндэрч, хүдэр дэх зэсийн агуулга жил дараалан буурч байсан ч компанийн гол бүтээгдэхүүн болох баяжмал дахь зэс болон молибдений гаргалтыг бууруулахгүй байх, үр ашгийн үзүүлэлтийн түвшинг хэвээр хадгалах нь үйлдвэрлэлийн гол зорилтын нэг байсан. Энэ зорилтыг биелүүлэхийн тулд өнгөрсөн онд зургаан сая тонн хүдэр боловсруулах шинэ өргөтгөлийг ашиглалтад оруулан хүчин чадлаа нэмэгдүүлж, чанарын үзүүлэлтүүдийг дээшлүүлэн, дэвшилтэт орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр шинэчлэл

хийсний үр дүнд үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдээ түүхэндээ байгаагүй дээд түвшинд хүргэж чадсан юм.

Өнгөрсөн жилүүдэд үйлдвэрийн доголдолгүй ажиллагаа, үйлдвэрт нэвтрүүлж буй шинэ технологи, оновчтой санаа болон чадварлаг боловсон хүчин, нийт ажилтан албан хаагчдын нөр хөдөлмөрийн үр дүн юм.

“Эрдэнэт” бол зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэр төдийгүй, уул уурхайн шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бааз, боловсон хүчний уурхай юм. Энд ирээдүйн шинэ, шинэ үйлдвэрүүдийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх суурь бааз нэгэнт тавигдсан. Дэлхийд томоохонд орох тус үйлдвэрийг өргөтгөн шинэчлэх, гадаад зах зээл, борлуулалтыг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг хангах, инженер-техникийн ажилтнуудыг бэлтгэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд удирдлагууд ихээхэн анхаарч байна.

Удирдлагын есөн бодлого

Есөн асуудал, есөн шийдэл

Ц.БУЯН

Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн сүүлийн гурван жилийн хугацаанд есөн зүйлд гол анхаарлаа хандуулж, чиглэсэн бодлого хэрэгжүүлжээ. Тэгэхдээ тэдгээрийг гурван бүлэгт хувааж болно.

Эхнийх нь “Ил тод байх”. Үүнд хүний нөөцийн бодлого, худалдан авалт, санхүү эдийн засгийн бодлого багтана. Хамгийн ойрын жишээ гэвэл “Эрдэнэт үйлдвэр” гүйцэтгэх удирдлагын тайлангаа нээлттэй зохион байгуулдаг болсон. Эрдэнэтийн хувьд төдийгүй, уул уурхайн салбарт шинэ туршлага болсон. Гурван жилийн өмнө “Эрдэнэт үйлдвэр”-ийн алдагдал 360 орчим сая ам.долларт хүрээд байсан бол өнгөрсөн онд есөн тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. 2014 онд бүр 127 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж байв. Энэ нь санхүүгийн зохион байгуулалтын өөрчлөлт хийж, хэмнэлтийн бодлого

Зах зээлийн эдийн засгийн амаргүй үед “Эрдэнэт” үйлдвэр өөрийн үйлдвэрлэлийн хувь заяа, ирээдүйг өөрсдөө шийдэж байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэх орчин үеийн мэргэжил, чадвар бүхий инженер техникийн ажилтан, ажилчид байдаг оршдог. Өнөөгийн байдлыг бодитойгоор үнэлээд зогсохгүй маргаашаа харж чаддаг, өөрсдийн боломж, хөгжлийн янз бүрийн хувилбарыг тооцож тодорхой төсөөлж, ард түмнийхээ амьдралыг сайн сайхан болгохын төлөө хөдөлмөрлөж буйгаараа уурхайчид бахархдаг. Нэг үгээр хэлбэл, аливаа хүндрэлийг урдчилан харж, угтуулж төлөвлөж, сөрж гардаг иргэй хүмүүсийг уурхайчид гэдэг. Тэд байгалийнхаа хишгийг хүргэж амьдардаг, бусдад хүртээдэг болохоороо эх орончид байдаг. Уурхайчдын маань сэтгэлдээ өргөсөн ерөөлийн хундага үүрийн цолмонгийн тоотой тэнцүү байг. ■

баримталж, ил тод болгосонтой холбоотой гарч буй ахиц дэвшил гэж шууд хэлж болно.

“Эрдэнэт үйлдвэр” бол маш том худалдан авагч. Тийм ч болохоор ашиг хонжоо хайгчдын ашиг сонирхлоос холуур байж чаддаггүй. Нэг барааг хоёр гурав дахин нугарсан үнээр үйлдвэрт “шахдаг” асуудал бодитой байсан. Байсан гэхийн учир нь өнгөрсөн хугацаанд энэ шахааны бизнесээс бүр мөсөн салж чадсан гэж Эрдэнэт үйлдвэрийнхэн дээр, дооргүй ярьж байна. Өнөөдөр ингэж ам бардам хэлэхийн тулд худалдан авалтаа ил тод болгож авч байгаа барааны үнэ нь зах зээлийн үнэд нийцэж байна уу гэдгийг хянаж нягталдаг болсон байна. Өнгөрсөн гурван жилд 100 тэрбум төгрөгийг зөвхөн худалдан авалтаас хэмнэжээ. Ингэхдээ барааны тоо хэмжээг бууруулаагүй. Гагцхүү өмнө нь өндөр үнэ төлдөг байсан бараагаа ▶

► шударга үнэд нийцүүлснээс гарсан хэмнэлт.

Дараагийн бүлэг нь Ангид байх. Авлигаас ангид байх асуудал. Үүний тулд хамгийн түрүүнд ил тод байдал суурь болж байгаа бөгөөд худалдан авалт, хүний нөөцийн асуудал олон нийтийн хяналтад орсноор авлига авах, өгөх боломж ч хязгаарлагдаж байгаа юм. Дээрээс нь тэнд ажиллаж буй албан хаагчид, удирдлагууд бодлогодоо үнэнч байх, өөрсдийн дүрэм журам, хууль ёсыг мөрддөг байх, түүнд харилцан хяналт тавих нь чухал.

Уул уурхай, барилга угсралтын салбарт бизнес эрхлэгчдийн чадавхийг үнэлэх чухал үзүүлэлт нь осол аваар хэр бага гаргадаг вэ гэдэг асуудал. “Эрдэнэт үйлдвэр” бол энэ асуудалд үлгэр жишээ компаниудын нэг. Ангид байх ёстой дараагийн асуудал нь улс төржилт. Үйлдвэрийн орчинд улс төржих нь сайн үр дагаварт хүргэхгүй. Хамгийн чухал нь үйлдвэрийн тогтвортой, доголдолгүй хэвийн үйл ажиллагаа. Тэгж байж гэмээ нь улсад татвар төлж, цаашлаад төрийн бусад албан хаагчид цалин, хүүхэд хөгшид тэтгэмж авах нөхцөл бүрдэнэ.

Гурав дахь бүлэг нь “Тодорхой болгох”. Энэ хүрээнд мөн л гурван зүйлийг тодорхой болгосон аж. Өнгөрсөн хугацаанд геологийн бодлого нь ерөнхийдөө алдагдсан байжээ. Тухайлбал, нийт нөөцийн хэчнээн нь

ИЛ ТОД БАЙХ

АНГИД БАЙХ

ТОДОРХОЙ БОЛГОХ

1. Хүний нөөц
2. Худалдан авалт
3. Санхүү, эдийн засаг
4. Авлига
5. Осол, аваар
6. Улс төр
7. Геологийн бодлого
8. Техникийн шинэчлэл
9. Хаалт, хөгжлийн бодлого

ашиглаж болохуйц юм, яг хэдэн хувийн зэс, молебдений агуулгатай вэ, түүнд хүрэхэд өөр юу тохиолдох вэ, нөөцийг нэмэгдүүлэхийн тулд юу хийх ёстой вэ, зэрэг асуултын хариуг хайсан хэрэг. Тиймээс нарийвчилсан хайгуул хийж бүгдийг нарийн тогтоогоод үлдэж буй хугацаанд хийх ажлуудаа тодорхойлжээ. Үр дүнд нь ил уурхайг 37 жил ашиглах нөөц байгаа нь тогтоогдсон байна.

Өнгөрсөн хугацаанд техникийн шинэчлэлийн бодлогуудыг нэлээд хэрэгжсэн ч тодорхойгүй зүйлүүд ч их байжээ. Техникийг шинэчлэх төлөвлөгөө нь тодорхой хөрөнгө оруулалтын бодлого байгаагүй, ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх нь ямагт тодорхойгүй явж ирсэн байна. Харин санхүү эдийн засгаа ил тод болгосноор

хөрөнгө оруулалтын боломжууд ч тодорхой болж иржээ.

Хамгийн чухал асуудал бол “Хаалт хөгжлийн бодлого”-той болсон явдал. Монголын уул уурхайн компаниудад энэ бодлого огт байхгүй гэж хэлж болно. Налайх зэрэг хаагдсан томоохон уурхайн өнөөгийн байгаа байдал нь үйл ажиллагаа нь зогсооны дараа ямар байх вэ гэсэн ч төлөвлөгөө байгаагүйтэй л холбоотой. Эрдэнэтийн овоо орд шавхагдахад хотынхны амьдрал ахуй хэрхэн өрнөх вэ, тэдэнд юу үлдээх вэ гэдэг асуудалд өнөөдрөөс санаа тавьж, сан байгуулж, бодлого менежмент хэрэгжүүлж эхлээд байна. Ямартай ч хоосон тогоо, шороон овоолго, хөндий гражууд, эзэнгүй барилга үлдээх төлөвлөгөө “Эрдэнэт үйлдвэр”-т үгүй. ■





Эрдэнэт үйлдвэрийн 38 жилийн хугацаанд
(1978-2015 он) улсын төсөвт оруулсан хөрөнгө

**5 ИХ НАЯД
ТӨГРӨГ**

Энэ хугацаанд нийтдээ

**4 САЯ ГАРУЙ
ТОНН** цэвэр зэс үйлдвэрлэж
экспортод гаргажээ



Эрдэнэт үйлдвэрийн улсын төсөвт оруулсан татвар
(тэрбум төгрөгөөр 2012-2015 он)

2013
520,3

2014
462,4

2015
381,2

Бодлого

Хямралын эсрэг авсан арга хэмжээнүүдийн үр дүн

Д.НАРАНТУЯА (“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЭЗМХ-ийн төлөвлөлт, шинжилгээний товчооны дарга)


Сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр зэсийн хэрэглээ буурч, биржүүдийн нөөц огцом өсөж, үүний зэрэгцээ уурхайн уул геологийн нөхцөл хүндэрч, хүдэр дэх зэсийн агуулга жил дараалан буурч байгаа ч үйлдвэрийн гол бүтээгдэхүүн болох баяжмал дахь зэс болон молибдений гаргалтыг бууруулахгүй байх, орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, үр ашгийн үзүүлэлтүүдийн түвшинг хэвээр хадгалах нь үйлдвэрлэлийн гол зорилт юм. Энэ зорилтыг биелүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, чанарын үзүүлэлтүүдийг дээшлүүлэх, хуучин тоног төхөөрөмжүүдийг шинэ дэвшилтэт орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр шинэчлэх, шинэ технологи судлах, турших, нэвтрүүлэх, дотоод нөөц бололцоогоо ашиглан өртөг зардлыг бууруулах, өглөг авлагыг барагдуулах зэрэг олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК үйлдвэрлэл-эдийн засгийн төлөвлөгөөг үзүүлэлтүүдээ тогтмол амжилттай биелүүлж, ашигтай ажилласаар ирсэн.

2013-2015 оны хүдэр олборлолт ба боловсруулалтын болон зэс молибдений төлөвлөгөөнөөс нэмж үйлдвэрлэсэн хэмжээг доорх тоон үзүүлэлтээс харна уу.



Эрдэнэт үйлдвэрийн ашиг орлогод, дэлхийн зэсийн зах зээл дээрх 1 тонн цэвэр зэсийн үнэ шууд нөлөөлдөг. 2011 онд зэсийн жилийн дундаж үнэ түүхэнд байгаагүй дээд төвшинд буюу 8821 ам.доллар байсан бол энэ үнэ өнөөдрийг хүртэл зогсолтгүй буурсан. (2012-2015 оны дэлхийн зах зээлийн зэсийн ханшийг графикаас үзнэ үү). Зэсийн болон молибдений үнийн бууралтаас л гэхэд 2013 онд 157,3 тэрбум төгрөг, 2014 онд 0,6 тэрбум төгрөг, 2015 онд 123,5 тэрбум төгрөг олох боломжийг тус тус алдсан боловч өөрсдийн

Нэг тонн зэсийн жилийн дундаж үнэ, 2011-2015



дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллаж өмнөө тавьсан зорилтоо амжилттай биелүүлсээр ирлээ. Хэдийгээр зэсийн үнэ унаж, бүтээгдэхүүний зардал өссөөр байгаа боловч Эрдэнэт үйлдвэрийн бүтээлч хамт олны шаргүй хөдөлмөрийн үрээр болон удирдлагын багийн ухаалаг, оновчтой, цаг үетэйгээ нийцүүлэн гаргасан шийдвэрүүдийн дагуу хямралын эсрэг олон талт арга хэмжээнүүдийг шат дараалан авч хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн 3 жилд 45,7 мян.тн зэсийн баяжмал, 2,9 мян.тн молибдений баяжмал буюу 127,9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг нэмж үйлдвэрлэсэн байна. Үүний зэрэгцээ импортоор авч байгаа бараа, материалын үнэ нэмэгдсэн, валютын ханш өссөн, цахилгаан эрчим хүчний үнэ, төмөр замын тариф өссөн зэрэг гадаад хүчин зүйлүүд зардалд шууд нөлөөлж байгаа боловч сүүлийн 3 жилд зардлыг 131,6 тэрбум төгрөгөөр хэмнэж чадлаа. Зөвхөн 2015 онд л гэхэд 2012 онтой харьцуулбал албан томилолтын зардлыг 0,4 тэрбум, гадны байгууллагын ажил үйлчилгээний зардлыг 10,4 тэрбум, гадны байгууллагаас авдаг хуулийн үйлчилгээний зардлыг 1,1 тэрбум, хөнгөн тэргэний зардлыг 0,8 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан байна. Үүнтэй уялдан цэвэр зэсийн тооцоот өртөг тогтмол буурч 2015 онд 4820 ам.доллар болсон нь 2012 онтой харьцуулбал 20,5%-иар буурсан байна.

Үүнээс гадна зөвхөн валютын ханшны зөрүүгээс 2013-2015 онуудад авлага талаасаа 23,4 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон боловч импортын бүтээгдэхүүний гэрээний үнийн ханшийн зөрүүгээс 100,1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь ашгийн хэмжээ буурахад нөлөөлсөн.

Гэвч цэвэр ашгийн төлөвлөгөөг тогтмол давуулан биелүүлж 2013 онд 125,0 тэрбум төгрөгийн, 2014 онд 167,5 ▶



► тэрбум төгрөгийн 2015 онд 9,1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа. Эрдэнэт үйлдвэр нь борлуулалтынхаа орлогын 35-43%-ийг татвар, төлбөрт төлдөг бөгөөд 2013-2015 онуудад Монгол улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт нийтдээ 1364 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна. Үүнээс:

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 765,6 тэрбум төгрөг;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 206,2 тэрбум төгрөг;
- Газар ашигласны төлбөрт 29,8 тэрбум төгрөг;
- Ус ашигласны төлбөрт 31,9 тэрбум төгрөг;
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварт 13,3 тэрбум төгрөг;
- Гадаадын мэргэжилтнүүдийн ажлын байрны төлбөрт 6,0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлээ.

Компанийн санхүү-эдийн засгийн байдал хүнд байгаа хэдий ч богино хугацаат ашиг, орлого авчрах техник, технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын ажлуудыг нэн түрүүнд хийх бодлого баримтлан ажилласны үр дүнд 2013 онд 151,3 тэрбум төгрөгийн, 2014 онд 303,3 тэрбум төгрөгийн, 2015 онд 230,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ.

Эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй байгаа үед Ерөнхий захирлын тушаалаар “Онцгой комисс” байгуулан зөвхөн өдөр тутмын хэрэгцээт технологийн нормчлогдсон материалууд (түлш шатахуун, нүүрс, ган бөмбөлөг, химийн урвалж, тэсэлгээний материал, дугуй) болон зайлшгүй хэрэгцээтэй сэлбэг, материалыг худалдан авах зарчим баримтлан ажиллаж байгаа, мөн бараа материалын худалдан авалтыг нээлттэй, ил тод болгож, худалдан авалтын тоо хэмжээг нарийвчлан тогтоож, үйлдвэрлэгчидтэй шууд гэрээ байгуулах, харьцуулсан үнийн саналын аргачлалаар худалдан авалтыг хийсний үр дүнд:

- 2013 онд 31 сая ам.долларын 65 гэрээг шууд үйлдвэрлэгчтэй байгуулж байсан бол 2014 онд 52,8 сая ам.долларын 103 гэрээг, 2015 онд 51,8 сая ам.долларын 85 гэрээг шууд үйлдвэрлэгчтэй байгуулсан.
- Мөн худалдан авалтын гэрээг байгуулахдаа урьдчилгаа төлбөргүй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. 2015 онд нийт гэрээний 61%-ийг ямар нэгэн урьдчилгаа төлбөргүй байгуулсан байна.

Түүнчлэн компанийн эцсийн бүтээгдэхүүний өртөгт шууд нөлөөлдөг технологийн бүтээгдэхүүний худалдан авалтад томоохон хувь эзэлдэг ган бөмбөлгийн 90 орчим хувийг бид өөрсдийн ган бөмбөлгийн цехэд үйлдвэрлэж байна.

Дээрх ажлуудын үр дүнд 2012 онд 173,1 сая ам.доллар байсан авлагын хэмжээ 2015 онд 76,9 сая ам.доллар болж 96,2 сая ам.доллараар буурсан байна.

Эрдэнэт үйлдвэрийн бүтээлч хамт олон, удаа дараагийн хямралд бусад үйлдвэрүүд сөхөрч байхад, өөрсдийн дотоод нөөц бололцоог шавхан гарч чаддаг чадвартай, дархалаа суусан нэг цул баялаг бүтээгчид юм. Одоо хэрнээ нэг ч хүний орон тооны цомтгол хийгээгүй, цалин, хөлс, урамшууллаа цаг хугацаанд нь олгосоор байгаагаас гадна харин ч 2013-2015 онуудын зөвхөн зардлын хэмнэлтээс Компанийхаа нийт ажилтнуудад 29,4 тэрбум төгрөгийг урамшуулал болгон олгосон байна.

2016 оны хувьд зах зээлийн төлөв байдал улам хүндрэх төлөвтэй байна. Учир нь зэсийн хамгийн томоохон хэрэглэгч болох Хятад улсын эдийн засгийн өсөлт саарч, зэсийнхээ хэрэглээг бууруулж байна. Үүнээс гадна дэлхий даяар маш тогтворгүй нөхцөл байдал үүсч, цаашид ч улам даамжрах хандлагатай байгаа нь зөвхөн зэсийн гэлтгүй бүхий л эрдэс баялгийн түүхий эдийн үнэ унахад ихээхэн нөлөөлж байна.

Үүсээд буй нөхцөл байдалтай уялдуулан судалгааны байгууллагууд 2016 он болон цаашид зэсийн үнийн төсөөллийг бууруулсаар байна. Бид 1 тн зэсийн үнийг 5268,7 ам.долларын түвшинд төлөвлөгөөндөө тусгаж байгаа боловч 2016 оны I улиралд 1 тн зэсийн үнэ 4668,59 ам.доллар байна.

Цаашид Компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн борлуулалтын орлогын удирдлагыг сайжруулж, шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлж ажиллах юм.


Иймд бид гадаад зах зээлийн хүнд нөхцөл байдалд зохицон ажиллаж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлсэнээр хүндрэлийг хамтдаа амжилттай даван туулна гэдэгт итгэлтэй байна. ■

Эрдэнэт үйлдвэрийн сүүлийн дөрвөн жилийн голлох статистик үзүүлэлтүүдийг сонирхуулж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ




Нэг тн зэсийн тооцоот өөрийн өртөг (ам.доллараар)



ТАТВАР



ОРЛОГО, ЗАРЛАГА




35-43%
2013-2015 онд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар нь нийт орлогын 35-43 хувийг эзэлж байна

127.9
131.6
2013-2015 онд 127.9 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олж, 131.6 тэрбум төгрөгийн зардал хэмнэсэн

ХУДАЛДАН АВАЛТ

Нийт худалдан авалтад импорт орлох бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ



ХЭМНЭЛТ

Шахааны бизнесийг арилгах зорилгоор хийсэн ажлуудын хүрээнд худалдан авалтын гэрээний үнийг зах зээлийн бодит үнэнд нийцүүлэх зорилгоор хяналт тавьж ажилласны үр дүнд нийт 91,32 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна.

2013 онд 27,2 тэрбум
2014 онд 24,12 тэрбум
2015 онд 40,0 тэрбум } **НИЙТ 91,32 тэрбум**

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА /2013-2015 онд/

9.4 тэрбум

Ахмад настнуудын тусламж дэмжлэг

18.3 тэрбум

Ажилчдад буцалтгүй тусламж

6.3 тэрбум

Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтнуудад эмчилгээ, тусламж, нөхөн төлбөр

2014 ОН

3.2
тэрбум төгрөг

2015 ОН

2.6
тэрбум төгрөг



нийт
9,4
тэрбум
төгрөг

3.6
тэрбум төгрөг

2013 ОН

Нийт **1175**
ажилтан хамрагдсан



Нийт ажилчдын 20 хувь орчим нь орон сууцны 8 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн

- Халуун хоолны үйлчилгээг нийт 4300 ажилтанд жилдээ 6.6-7.3 тэрбум төгрөг зарцуулдаг
- 710 ажилтан 352 сая төгрөгийн унааны хөнгөлөлт, 7608 ажилтан 228,5 сая төгрөгийн нүүрсний хөнгөлөлт, хамтын гэрээгээр ажилтнууд 851,1 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг авсан.
- 334 ээж хүүхдээ 3 нас хүртэл нь асрах тэтгэлэг авсан.

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2013 онд
70.7 тэрбум

Компани нийгмийн хөгжлийн бодлогынхоо зардалд нийт зардлынхаа 7 орчим хувийг төлөвлөж зарцуулдаг.

2015 онд
69.5 тэрбум

ХҮНИЙ ХӨГЖИЛ

Сургалтын зардал /тэрбум төгрөг/ } **7.5** Гадаадад Дотоодод
355 хүн **226** хүн

Спортын арга хэмжээнд хамрагдсан хүний тоо } **94000**

ҮЙЛДВЭРЛЭЛ

2015 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн

31.6 сая тн уулын цул олборлож

28 сая тн хүдэр боловсруулж

546190 тн зэсийн баяжмал

5207 тн молибдений баяжмал

2014-2015 онд ордын баруун хойд болон төвийн хэсэгт гүйцээх хайгуулын нийт 172 цооног, 46875 тууш метр өрөмдлөгийн ажлыг богино хугацаанд гүйцэтгэлээ

БАЙГАЛЬ ОРЧИН

ISO14001 Олон улсын стандартыг хэрэгжүүлсэн

Сүүлийн гурван жилд байгалийг дүйцүүлэн нөхөн сэтгээх чиглэлээр сая төгрөгийн нөхөн сэргээлт хийсэн **250**

12000 2013 онд “Ногоон төгөл” төслийн хүрээнд 19 төрлийн 12 мянган мод суулгасан

2015 онд хөрс, ус агаарын шинжилгээг хамгийн олон удаа буюу 11766 удаа хийсэн **11766**

Худалдан авалт

Бизнес дагуулсан бизнес



“Эрдэнэт мед” гэрлийн үйлдвэр

Б.ЭНХЦЭЦЭГ

Эрдэнэт үйлдвэрийн инженер дөрвөн залуу хамтран Монголын хамгийн анхны лед гэрлийн үйлдвэр болох “Эрдэнэт лед”-ийг хамтран байгуулж, орон нутаг төдийгүй томоохон компаниуд бүтээгдэхүүнийг нь худалдан авч буй талаарх мэдээ өнгөрсөн жил нэг хэсэгтээ л “мода” болж, хэвлэл мэдээллийнхний дунд онцлох баатар болоод авсан. Тус үйлдвэр нь Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн тууштай дэмжин ажилладаг дотоодын олон үйлдвэрүүдийн зөвхөн нэг нь.

Тус үйлдвэр нь импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бизнесийг дэмжих мөн Орхон аймгийн эдийн засгийг төрөлжүүлэх бодлогынхоо хүрээндээ Молибдений баяжмал боловсруулах “Шим технологи”, цэвэр зэс үйлдвэрлэлийн “Ачит-Ихт”, амны хаалтны “Цагаан жим”, “Бэрэн” группийн Төмөрлөгийн цогцолбор үйлдвэр, “Мэйнспринг” компанийн Резинэн бүтээгдэхүүний үйлдвэр, “Эрдэнэт хивс” компанийн Нано технологийн даавууны үйлдвэр, Лед гэрлийн үйлдвэр зэрэг олон жижиг, дунд үйлдвэрийг тууштай дэмжиж ажилладаг. Үйлдвэр тойрсон бизнес эрхлэлтийн наад талын жишээ эд. Орхон аймагт 2014 онд мэндэлсэн гарааны бизнесүүдээс гэхэд өдгөө долоон компани амжилттай үйл ажиллагаагаа явуулж байна. Тэд бараг бүгд Эрдэнэт

үйлдвэрт бараа бүтээгдэхүүнээ өдгөө нийлүүлж байгаа бөгөөд анхнаасаа тус үйлдвэрт найдаж, боломж гэж онилон гарч ирсэн бизнесүүд. Гэхдээ тэд цаашид үйл ажиллагаагаа тэлж бусад компаниудтай гэрээлэн ажиллах боломжтой.

Өнгөрсөн онд бараа материал үйлдвэрлэгчидтэй Эрдэнэт үйлдвэр 394 ширхэг гэрээ зурж, ойролцоогоор 300 тэрбум шахам төгрөгийн худалдан авалт хийжээ. Үүнээс 2015 онд импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 37 компаниас 51 тэрбум гаруй төгрөгийн бүтээгдэхүүн худалдан авсан байна. Үүнийг 2012 оны үзүүлэлттэй харьцуулбал зургаа дахин өссөн дүн. Дотоодын үйлдвэрлэгчдээс авч буй бараа бүтээгдэхүүн нь өдгөө 27 нэр төрөл байна. Гэхдээ баяжмалын уутыг л гэхэд нэг биш нэлээд олон компани нийлүүлдэг.

Өнгөрсөн жил Эрдэнэт үйлдвэртэй гэрээлэн ажилласан 37 бизнесийн нэгнийх нь ард хамгийн багадаа 10 ажилтан, нэг ажилтны ард ам бүл дөрөв байгаа гэж тооцвол, 1500 шахам хүний амьдрал гэсэн үг. Эрдэнэт үйлдвэр өөрөө 6000 ажилтантай. Тэдгээр ажилтны ард Эрдэнэт хотын олон гэр бүл бий. Тус үйлдвэрт ажилладаггүй хамаатан садан, ах эгч, үр хүүхэд, аав ээжгүй хүн гэж энэ хотод үгүй. Эрдэнэтийн орд газрын баялаг мөнх биш. Хэтдээ уурхайн баялаг шавхагдахад тэдгээр


хүмүүст амьдрах өөр арга зам, эдийн засгийн тулгуурууд хэрэгтэй. Үүний шийдэл нь импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх чадавхитай үндэсний үйлдвэрлэгчид байж болно.

Эрдэнэт үйлдвэр 2012 онд үндэсний үйлдвэрлэгчдээс 8.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий импорт орлох бүтээгдэхүүн худалдан авсан нь нийт худалдан авалтын гуравхан хувийг эзэлж байв. Үүнээс хойш идэвхтэй дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих бодлого хэрэгжүүлснээр жил бүр дээрх тоо өссөөр иржээ. Өнгөрсөн онд 51.3 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн нь нийт худалдан авалтын 17.3 хувийг эзлэх болсон бөгөөд дотоодын худалдан авалт 2013 онтой харьцуулахад 23.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Орхон аймгийн аж ахуйн нэгжүүдийн хувьд 2015 онд Эрдэнэт үйлдвэртэй нийт 44 тэрбум төгрөгийн 130 гэрээ хийжээ. Үүнийг дотоодын ханган нийлүүлэгчдийн нийт тоотой харьцуулаад харвал 15 хувь нь бөгөөд өнгөрсөн оноос дөрвөн хувиар ахисан үзүүлэлт.

Эрдэнэт үйлдвэрийн худалдан авч буй нийт бараа бүтээгдэхүүний 70 хувийг үндсэн технологийн материал эзэлдэг. Өөрөөр хэлбэл, баяжмал гаргахад өдөр тутам хэрэглэгддэг технологийн материал гэсэн үг. Тус үйлдвэрийн хувьд энэхүү үндсэн технологийн материалуудаа дотоодын аж ахуй нэгжүүдээс авахыг хичээдэг аж. Тухайлбал, үндэсний үйлдвэрлэгчдээс авсан бараа бүтээгдэхүүн дундаа 60 гаруй хувийг нь эзэлж, ахиу жин дардаг Ган бөөрөнцөгийн бэлдэцийг л гэхэд 2013 оноос хойш Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс авч байна. Үндсэн технологийн материал гээд тусад нь авч үзвэл 60 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн хамаарагдах бол бүх нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг оруулбал 30 мянган бараа бүтээгдэхүүнийг худалдан авдаг аж. Энэ бол үзэг, цаас, саван гэх мэт бүтээгдэхүүн бүрийг оруулсан тоо. Өнгөрсөн онд хийсэн 394 гэрээнээс 73 нь гаднын компаниудад ногдож байгаа бөгөөд эндээс авах боломжгүй зайлшгүй шаардлагатай материалуудыг Орос Хятад, Австрали зэрэг улсаас импортолдог.

“2013 онд шинэ удирдлагын баг ажиллаж эхэлснээр шахааны бизнесийг үндсээр нь тасалж, өртөг зардлыг бууруулж хэмнэлттэй байдлаар бараа материалыг үйлдвэрийн бодит ▶

Импорт орлох бүтээгдэхүүний болон орон нутгийн үйлдвэрлэгчдийн худалдан авалт 2013-2015 он



► хэрэгцээнд тулгуурлан худалдан авч байгаа” хэмээн Эрдэнэт үйлдвэрийн Худалдаа, хангамжийн хэлтсийн эдийн засагч С.Эрдэнэбилэгт хэлсэн юм.

Урьдчилгаа өгч худалдан авалт хийдгийн балгаар Эрдэнэт үйлдвэрийн авлагын хэмжээ 2010 онд 40.8 сая ам.доллар байсныг сүүлийн гурван жилд 18 сая болтол буулгаж чаджээ. Зарим ханган нийлүүлэгч бүтээгдэхүүн нийлүүлэхдээ урьдчилгаа төлбөр авчихаад чанарын шаардлага хангаагүй бараа өгөх, гэрээнийхээ үүргийг биелүүлэхгүй алга болж, ажил цалгардуулах тохиолдол 2013 оноос өмнө олон гардаг байв. Энэ нь улмаар компанийн санхүүгийн байдалд хүндрэл авчрах үндэс болж байсан гэхэд хилсдэхгүй. Харин сүүлийн жилүүдэд урьдчилгаа төлбөр өгдөг жишгийг халах арга хэмжээ авснаар 2012 онд урьдчилгаа төлбөргүй гэрээний тоо нийт гэрээ дундаа 32 хувийг эзэлж байсан бол өдгөө 80 хувь болж өсчээ. Энэ нь эргээд ханган нийлүүлэгчдийг илүү хариуцлагатай болгож, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх босго болж өгч байна. Мөн Эрдэнэт үйлдвэртэй хамтран ажиллах дараагийн шинэ бизнесүүдэд ч анхаарах баримжаа, хүрэх стандарт болж байгаагаараа онцлог.

Эрдэнэтийг үйлдвэрийг түшиглэн дотоодын бизнес эрхлэгчид хөл дээрээ босч ирж байгаагийн зэрэгцээ тус үйлдвэрээс төрж өсөн цаашид Монголын уул уурхайн салбарт томоохон байр суурь эзлэх бизнесүүд ч мөн бий. Тэдний нэг нь Засвар механикийн завод бөгөөд тус цех засвар үйлчилгээ хийх, эд анги үйлдвэрлэх гээд үйл ажиллагааны хувьд нэлээд өргөн. Тухайлбал тус завод нь найман тонн хүртэлх жинтэй эд анги үйлдвэрлэдэг. Өнгөрсөн онд л гэхэд 5.3 тэрбум төгрөгийн хэмнэлтийг хийжээ.

Эрдэнэт үйлдвэрийн хувьд тус завод нь импорт орлосон олон эд ангиудыг боломжийн өртгөөр үйлдвэрлэж, зардал хэмнэж буй. Засвар механикийн заводыг Монголын машин үйлдвэрлэлийн төв болгох бодлого бий. Энэ бол олон хүний хувьд, бизнесүүдийн хувьд гарц. Тус заводын үйл ажиллагаа цаашид Эрдэнэт үйлдвэрийг давж, уул уурхайн бусад үйлдвэрүүдэд үйлчилгээгээ үзүүлэх, бүтээгдэхүүнээ нийлүүлэх боломжтой.

Эрдэнэт үйлдвэр нь түүхэндээ хамгийн их буюу 2010 онд 624 тэрбум

төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төлсөн байдаг. Энэ мөнгөний дөрөвний нэг нь Орхон аймгийг хөл дээр нь авч яваа. Энэ төсвийг ирээдүйд бүрдүүлэх бизнесүүд одооноос бойжиж байна. Тэдний аль нэг нь хэд дахин томорч дараагийн Эрдэнэт үйлдвэр болдоггүй юмаа гэхэд хувьдаа хөгжиж өссөөр хамтдаа Эрдэнэт үйлдвэрийн хэмжээнд орон нутгийн төсвөө бүрдүүлж, улмаар улсын төсөвтөө нэмэр болох, олон улсад өрсөлдөх ирээдүй бий. ■

Хөрөнгө оруулалт

Үр ашигт шинэчлэлүүд

Ц.БАДРАЛ

Нүсэр тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон, хана, шат, хаалга гээд хаашаа ч харсан бүх зүйл нь төмөр том зааланд их чимээ нүргэлнэ. Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”-ийн Баяжуулах фабрикийн өөрөө нунтаглах хэсэгт ирээд байгаа нь энэ. Энд дөрвөн том бутлуур эргэн хүдэр боловсруулж байна. Хойд талд суурилуулсан хоёр нь арай том бөгөөд өнгөрсөн жил шинээр суурилуулсан аж. Өөрөө нунтаглах үйлдвэрийг ийнхүү өргөтгөснөөр нийт хүчин чадал зургаан сая тонноор нэмэгдэж жилд 32 сая тонн хүдэр боловсруулах боломжтой болжээ.

Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ шалдаа буусан өнгөрсөн хугацаанд “Эрдэнэт үйлдвэр” зардлаа бууруулж, үр ашгаа нэмэгдүүлэхэд нэлээд анхаарч ажилласан. Компанийн удирдлагууд

сүүлийн гурван жил хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж байгаа ч техник технологи, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх чухал хөрөнгө оруулалтуудыг орхигдуулалгүй хийж байсан аж. Санхүүгийн байдал нь тогтворгүй болсны эсрэг өртөг зардлыг бууруулж орлогоо нэмэгдүүлэх шаг дараатай арга хэмжээ авсны үр дүнд 127.9 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олж, 131.6 тэрбум төгрөгийн зардал хэмнэсэн байна.

Зах зээл дээрх зэсийн үнэ унаснаас гадна сүүлийн жилүүдэд уурхайн хүдрийн агууламж багасч байгаа зэрэг хавсрага хүчин зүйлүүд үйлдвэрийн ашиг орлогод ихээхэн нөлөө үзүүлж, орлого тасалдахад хүргэж байгаа юм. Өнгөрсөн онд тус компани нэг их наяд 54 тэрбум төгрөгийн орлого олсон ч 79.9 тэрбум төгрөгөөр орлого нь тасарчээ. Мөн 381 тэрбум



Өөрөө нунтаглах үйлдвэрийн өргөтгөл

Фотог Б.Цэцээ

▶ төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь 2013 онтой харьцуулахад 27 орчим, 2014 оноос 18 орчим хувиар буурчээ. Өөрөө нунтаглах хэсгийг өргөтгөсний үр дүнд гэхэд л жилд 104.4 мянган тонн зэсийн баяжмал, 664 тонн молебдений баяжмал үйлдвэрлэж зэсийн баяжмалын орлого 240 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа аж. Үр дүнд нь улсын төсөвт 73 тэрбум төгрөгийн татвар нэмж төвлөрүүлэх боломж бүрджээ. Энэ онд л гэхэд 99 сая ам.долларын нэмэлт орлого олох боломжтой хэмээн тооцоолж байгаа юм.

Уг бүтээн байгуулалтад есөн давхар 10 барилгатай тэнцэх барилга угсралтын ажил хийсэн гээд бодохоор ямархуу нүсэр ажлын ард гарсан нь мэдрэгдэнэ. Үүнд 155 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд үйлдвэрийн цэвэр ашгийг жилийн 12 сая ам.долларт хүргэх юм. Шинээр суурилуулсан хоёр бутлуур нь хүний оролцоо багатай, шигшиж дахин бутлах процессыг өөрөө автоматаар гүйцэтгэдгээрээ ажлын цагийг асар ихээр хэмнэж байна. Гэхдээ л өргөтгөл хийснээр 30 орчим ажлын байр шинээр бий болгожээ. Цаашид хүдэр боловсруулах чадлыг 35 сая тоннд хүргэх төлөвлөгөө үйлдвэрийнхэнд бий ажээ.

Мөн өнгөрсөн жил Нунтаглан баяжуулах хэсгийн зэс молебдений хөвүүлэн баяжуулах 82, 84, 85 дугаар машиныг шинэчилсэн юм. Үр дүнд нь зэсийн металл авалт 86.4 хувьд хүрч,

молебдений металл авалт 5.5 хувиар нэмэгджээ. Түүнчлэн хүдэр боловсруулах зургадугаар секцийн хүчин чадлыг нэмэгдүүлж таван сая тоннд хүргэжээ. Ингэснээр баяжуулах фабрикийн 1-6 секц орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн шинэчлэгдэж цаашид жилд 35 сая тонн хүдэр хүлээн авч боловсруулах бүрэн боломж нээгдээд байна.

Гарган авсан зэс, молибдены баяжмалыг шүүн хатаах хэсэгт зэсийн баяжмалын M1500 FBM-77-PP маркийн шинэ даралтат шүүлтүүр угсарч 2013 онд ашиглалтад оруулсан. Үр дүнд нь тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа дээшилж, зэсийн баяжмалын чийглэгийг бууруулж, доголдолгүй үйлдвэрлэл явуулах боломж хангагджээ. Эрдэнэт хотын 40 жилийн ой ирэх жил тохионо. Ерөнхийдөө үйлдвэрийн зарим тоног төхөөрөмж төдий хэмжээний насжилттай, шинэчлэх, засч сайжруулах, орчин үеийн технологиор солих шаардлага бий юм.

Өнгөрсөн жил хийсэн үр ашигтай томоохон хөрөнгө оруулалтуудын нэг нь Ган бөөрөнцөг цувих цехэд нүүрс хийжүүлэх хоёр шатлалт зуух барьж ашиглалтад оруулсан явдал. Өмнө нь тус цехийн бэлдэц халаах зуухыг дизель түлшээр халаадаг байсан юм. Нүүрс хийжүүлэх зуухыг 1.1 тэрбум төгрөгөөр барьж ашиглалтад оруулснаар дизель түлшний үнийн зөрүүнээс хоёр тэрбум төгрөг хэмнэж, ган бөөрөнцгийн өөрийн өртгийг 33 хувиар бууруулсан байна.

Дээрх хөрөнгө оруулалтыг ганцхан жилийн хугацаанд нөхөх бөгөөд нийт үйлдвэрлэлийн зардал жилд нэг тэрбум төгрөгөөр буурч байгаа аж. Басхүү 16 ажлын байр шинээр үүсгэжээ. Мөн өнгөрсөн жил үйлдвэрлэлээ өргөжүүлж 100 мм голчтой ган бөөрөнцөг цувиж эхлээд байна. Ингэснээр Баяжуулах фабрикийн хэрэгцээний 90 хувийг дотоодоосоо хангах болжээ.

Баяжуулах фабрикийн Хаягдлын аж ахуйн коллекторыг шинэчилсэн нь сүүлийн жилүүдэд хийсэн чухал ажлуудын нэг юм. 4.1 км шугам хоолой, ус хуримтлуулах дөрвөн худаг, хязгаарлалтын дөрвөн далан, ус дамжуулах дөрвөн суваг бүхий ус хуримтлуулах хоёрдугаар коллекторын шинэчлэлд 7.7 тэрбум төгрөг зарцуулсан байна. Ингэснээр хаягдлын аж ахуйн найдвартай ажиллагаанд 25 жил санаа зоволтгүй болжээ. Эргэлтийн ус хүлээн авах коллектор нь хаягдлын санд тунасан усыг хүлээн авч түүнийг эргэлтийн усны насосны станциар дамжуулан баяжуулах фабрикийг технологийн усаар хангах зориулалттай газар доорхи байгууламж юм.

Энэ мэт цаг үеэ олсон олон хөрөнгө оруулалт хийснээр “Эрдэнэт үйлдвэр”-ийн олон жилийн тогтвортой ажиллагаа хангагдаж байна. Цаг үеийн бэрхшээл, эдийн засгийн хүндрэлийг амжилттай даван гарахаар зүтгэж буй. Цаашдын үйл ажиллагааны үр ашиг нь Монгол, Орос хоёр улсын эдийн засагт чухал хувь нэмрээ оруулсаар байх нь дамжиггүй. ■



Өөрөө нунтаглах үйлдвэрийг ийнхүү өргөтгөснөөр нийт хүчин чадал зургаан сая тонноор нэмэгдэж жилд 32 сая тонн хүдэр боловсруулах боломжтой болжээ.



МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ

Монгол улсын бизнесийн тогтвортой өсөлт ба хөгжлийг дэмжинэ

Оролцохын ач холбогдол?

Монголд үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллага, мэргэжлийн хүмүүст ирээдүйд өсөж, хөгжихөд нь хэрэг болохуйц өргөн хүрээний, чухал бөгөөд шинэлэг мэдээ мэдээллийг олж авах

Дараагийн Засгийн газрын зүгээс анхаарвал зохих өнөөгийн бизнесийн салбарт тулгамдаж буй гол асуудлуудын талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх; Засгийн газар, улс төрийн намууд болон холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх Чуулга уулзалтын зөвлөмж бичигт өөрийн хувь нэмрийг оруулах

Хамрах хүрээ?

Бизнесийн төрөл бүрийн салбарын төлөөлөл болсон 200 хүн
Илтгэгч болон салбар хуралдааны зочдоор оролцох өндөр түвшний бизнесийн удирдагч, шийдвэр гаргагч 25 хүн

Платинум спонсор:



Алтан спонсор:



Үдийн хоолны спонсор:



Арга хэмжээний спонсор:



Хэвлэл мэдээллийн спонсор:



Дэмжигч байгууллага:



2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Blue Sky зочид буудал

Э-шуудан: saruul@bcmongolia.org, Утас: +976-11-317027/70114442

Онцлох 10 үйл явдал

1. Шинэчлэл

“Эрдэнэт” үйлдвэрийн Баяжуулах fabriкийн Өөрөө нунтаглах хэсгийг өргөтгөн ашиглалтад оруулж, тус үйлдвэрийн хүдэр боловсруулах хүчин чадлыг зургаан сая тонноор нэмэгдүүлсэн. Үүний дүнд хүдэр боловсруулалт энэ онд 5.38 сая тонноор нэмэгдэж, 101.4 мянган тонн зэсийн баяжмал, 664 тонн молибдений баяжмал үйлдвэрлэн 99 сая ам.долларын нэмэлт орлого олох боломж бүрдсэн байна.

Түүнчлэн нунтаглан баяжуулах хэсгийн зэс, молибдений хөвүүлэн баяжуулалтын 82, 84, 85 дугаар машинуудыг шинэчилсний дүнд зэсийн металл авалт 86.4 хувьд хүрч, молибдений металл авалт 5.48 хувиар нэмэгдсэн бол шүүн хагаах хэсэгт зэсийн баяжмалын M1500, FM 77DP маркын шинэ даралтат шүүлтүүр угсарч ашиглалтад оруулснаар зургаадугаар секцийн хүчин чадлыг таван сая тонн болгожээ. Ийнхүү Баяжуулах fabriкийн хам баяжуулалтын 1-6 секцийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн шинэчилэн цаашид жилд 35 сая тонн хүдэр хүлээн авч боловсруулах хүчин чадалтай боллоо.

2. Хэмнэлттэй шийдэл

Ган бөөрөнцөг цувих цех 2015 онд 100 мм голчтой ган бөөрөнцөг цувих технологийг үйлдвэрлэлдээ амжилттай нэвтрүүлсэн. Түүнчлэн шинэ технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх, өртөг зардал бууруулах ажлын хүрээнд нүүрс хийжүүлэх зуухыг ашиглалтад оруулжээ. Дизелийн түлшний хэрэглээг нүүрсний хийгээр сольсноор түлшний үнийн зөрүүгээс хоёр тэрбум төгрөг хэмнэж нэг тонн ган бөөрөнцөгийн өөрийн өртгийг 33 хувиар бууруулсан байна.



3. Бүтээн байгуулалт

Баяжуулах fabriкийн хаягдлын аж ахуйд үйлдвэрлэлийн технологийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор 2015 онд 1100 орчим метрийн урттай М3 даланг 1400 мм голчтой хуваарилах шугам ВК 11, 12-р худгийн эргэлтийн ус хүлээн авах коллекторыг барьж, байгуулжээ.

4. Жижиг, дунд үйлдвэрлэл

“Эрдэнэт үйлдвэр” ХХК шинэ бүтээн байгуулалтыг дэмжин ажиллах санаачилгын хүрээнд өнгөрсөн онд Эрдэнэт хотын 600 гаруй иргэн ажил, орлоготой болжээ. Молибдений баяжмал боловсруулах “Шинэ технологи”, “Эрдэнэт” үйлдвэрийн балансын бус хүдрийн овоолгыг түшиглэн катодын зэсийн “Ачит Ихт” зэрэг үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж буй бол Монгол Улсад өөрийн түүхий эдийг түшиглэсэн ган хайлуулах анхны үйлдвэр “Бэрэн металл” Орхон аймагт нээлтэй хийсэн нь улсын хэтийн хөгжилд онцгой хувь нэмэр үзүүлэх ач холбогдолтой аж. 2014 оны байдлаар “Эрдэнэт” үйлдвэрийн дэмжлэгтэйгээр Орхон аймагт олон бүтээн байгуулалт өрнөсний дунд амны хаалтны үйлдвэр, Монгол Улсад анхдагч лед гэрлийн үйлдвэр, мөн түүхий резин болон резинэн бүтээгдэхүүний үйлдвэр нээлтээ хийж, “Эрдэнэт хивс” компани нано технологийн давууны үйлдвэрлэлээ эхэлсэн.

5. Нийгмийн хариуцлага

2013-2015 он ахмад настнуудын тусламж дэмжлэгт зориулан 9.4 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтнуудад эмчилгээ, тусламж, нөхөн төлбөрт 6.3 тэрбум төгрөг, ажилтнуудын буцалтгүй тусламжид 18.3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. Түүнчлэн “Эрдэнэт” үйлдвэрийн 1302 өрх айлыг гэр, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлж нийт 9.75 тэрбум төгрөгийн тусламж үзүүлсэн аж. Мөн ажилчидаа орон сууцжуулах “Эко 400”, “Москва 300”, “Залуус 600” төсөл боловсруулж, хамтарсан үйлдвэрийн Зөвлөлийн хурлаар шийдүүлдэг буй.

6. Оюуны өмчийн бодлоготой анхны үйлдвэр

“Эрдэнэт үйлдвэр” ХХК 2015 онд үндэсний мэргэжилтнүүдийн оюуны бүтээлийг дэмжин хөгжүүлэх, үр ашигт тулгуурласан урамшууллын системийг хэрэгжүүлэх зорилгоор Компанийн оюуны өмчийн бодлогын цогц баримт бичгийг олон улсын эрх зүйн акт, Монгол Улсын хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулан баталсан. Компанийн оюуны өмчийн бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс өөрийн инженер, техникийн ажилтнуудын мэдлэг, туршлага, ур чадварыг дэмжин тэдний санаачилсан таван төсөлд 91.4 сая төгрөгийн санхүүжилт хийсний зэрэгцээ засвар механикын завод, баяжуулах fabriкийн инженер, техникийн ажилтнуудын санаачилан бүтээсэн шинэ бүтээлүүдийг Монгол Улсын оюуны өмчийн газарт патентжуулах ажлыг эхлүүлдэг байна.

7. Цэнхэр дэвтрийн эзэн

“Эрдэнэт” үйлдвэр Монголын топ 100 аж ахуйн нэгжийг 13 жил тасралтгүй тэргүүлж шилдэг татвар төлөгч, шилдэг нийгмийн хариуцлагатай компаниар шалгарсан. Тус үйлдвэр орон нутгийн төсөвт 123 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь Орхон аймгийн төсвийн байгууллагын ажилтнуудын 45 жилийн цалинтай тэнцэж байна. Мөн улсын төвлөрсөн төсөвт 1.1 их наяд төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 32.5 тэрбум төгрөг, нийтдээ 1.4 их наяд төгрөг төвлөрүүлсэн нь 1000 айлын сууц бүхий 28 орон сууцны хороолол барих хөрөнгө гэсэн үг юм.



8. Хамтын ажиллагаа



Орхон аймаг, “Эрдэнэт” үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд 2013-2015 онд үйлдвэрлэл технологи, зам тээвэр, харилцаа холбоо, байгаль орчин экологи, эрүүл мэндийн чиглэлд нийтдээ 58.6 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэжээ. Тухайлбал, “Эрдэнэт медикал” оношилгоо, эмчилгээний төвийг ашиглалтад оруулсны зэрэгцээ Орхон аймгийн цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, гудамж талбайн гэрэлтүүлэг, автозамын өргөтгөлд хувь нэмрээ оруулжээ. Түүнчлэн Найрамдал өдөрлөг наадмын талбайн сэргээн засварлалт, орон сууцны хорооллууд болон автозамын зогсоолын тохижилт үйлчилгээ, байгаль орчны цэвэрлэгээний нөхөн сэргээлт болон удирдлагын менежментийг дэмжихэд дээрх хөрөнгийг зарцуулсан байна.

9. Хөрөнгө оруулалт

Япон улсад үйлдвэрлэсэн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоногдсон “Эрдэнэт медикал” оношилгоо, эмчилгээний төвийг Японы Медипасс байгууллагад шилжүүллээ. Уг эрүүл мэндийн төв “Эрдэнэт” үйлдвэрийн хөрөнгө оруулалттай бөгөөд холбогдох талууд Японы эрүүл мэндийн менежментийг нэвтрүүлэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан байна. Ийнхүү “Эрдэнэт” үйлдвэр улсынхаа эрүүл мэндийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийснээр иргэд чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой боллоо.

10. Бага зардал, ахиу орлого

Дэлхийн зах зээл дээрх зэсийн ханш унасан, эдийн засаг, санхүүгийн байдал тогтворгүй байгаатай холбогдуулан “Эрдэнэт” үйлдвэр хямралын эсрэг авах арга хэмжээний хүрээнд хэмнэлтийн горимд шилжиж өртөг зардлыг бууруулах, орлогоо нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Үүний дүнд үйлдвэр нийтдээ 127.9 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олж 131.6 тэрбум төгрөгийн зардал хэмнэсэн байна. 2015 онд өртөг зардлыг бууруулах иж бүрэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсний үр дүнд нийт зардлыг 94.1 тэрбум төгрөгөөр, түүний дотор таваарын бүтээгдэхүүний зардлыг 83.7 тэрбум төгрөгөөр бууруулсан тооцоо байгаа юм. Сүүлийн жилүүдэд компанийн гүйцэтгэх удирдлага нэг тонн цэвэр зэсийн тооцоот өртгийг тогтмол бууруулах бодлого баримталснаар 2015 онд нэг тонн цэвэр зэсийн тооцоот өртөг 4820 ам.доллар болж буурсан нь 2012 онтой харьцуулахад 1240.9 ам.доллар буюу 20.4 хувиар буурсан үзүүлэлт.



11. Авьяаслаг “Эрдэнэт”-чүүд

“Эрдэнэт” үйлдвэрийн хамт олны эх орондоо оруулсан олон жилийн бодит хувь нэмрийг үнэлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус үйлдвэрийг 2013 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасан. Мөн 2013-2015 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус үйлдвэрийн хамт олноос Монгол Улсын гавьяат уурхайчин нэг, аж үйлдвэрийн гавьяат ажилтан зургаа, гавьяат дасгалжуулагч нэг, гавьяат тамирчин нэг, нийтдээ есөн гавьяат төржээ.

Нийгмийн хариуцлага

АЙЛЫН ТОМ ХҮҮХЭД

Б.ЭНХЦЭЦЭГ

“Манай усан бассейнаар орсон уу, шинэ эмнэлгээр саатсан уу, “Сэлэнгэ” амралтын газарт очиж амрахгүй юм уу” гэж энэ хотод гаднаас ирсэн хүмүүсээс нутгийн иргэд асуух нь элбэг. Эрдэнэт хотод Монголын хамгийн урт буюу 5.6 км дугуйн зам байх ба эрдэнэтчүүд ямар нэг зардал төсөвгүйгээр өөрсдийн

зам шинэчлэх, гэрэлтүүлэг гэх мэт Орхон аймгийн бүтээн байгуулалтад 5.6 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

“Өнгөрсөн 40-өөд жилийн үйл ажиллагаанаас харахад Эрдэнэт үйлдвэр нийгмийн хариуцлагаараа Монголдоо жишиг компани. Байгуулагдсан цагаасаа эхлэн хажуудаа дагуул хот бий болгож,

Улсын нийгмийн даатгалын шимтгэл төлөгч шилдэг байгууллагуудыг шалгаруулахад Эрдэнэт үйлдвэр шилдгийн шилдгээр тодорчээ. Ер нь тус үйлдвэр улсын төсвийн жинтэй хувийг олон жил нуруундаа үүрч ирлээ. Эрдэнэт үйлдвэргүйгээр Эрдэнэт хотыг төсөөлөхөд бэрхийн адил энэ улсын төсвийн бүрдэлтийг ч тус үйлдвэрийн төлдөг татваргүйгээр харахад хэцүү. Үүний зэрэгцээ нийгмийн хариуцлагыг өндөрт авч яваагийн бас нэг жинтэй үзүүлэлт нь Орхон аймагт орон нутгийн үйлдвэрүүдийн бараа бүтээгдэхүүнийг шууд худалдан авах замаар орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг юм.

Эрдэнэт үйлдвэрийн нийт зардлын долоо орчим хувийг нийгмийн үйлчилгээний нэгжүүд болон нийгмийн хөнгөлөлт, дэмжлэгийн сангууд эзэлдэг аж. Түүний 2.5 шахам хувийг нийгмийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагааны зардал дангаараа авч байна. Хүндрэлтэй үеийн хэмнэлтийн бодлогын хүрээнд дээрх байгууллагууд зардлаа 10-15 хувиар танаж мөн орлогоо нэмэгдүүлж, өнгөрсөн онд нийт 1.5 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Товчхондоо, орон нутгийн байгалийн баялгийг ашиглан үйлдвэрлэл явуулж байгаа учраас Эрдэнэт хот Эрдэнэт үйлдвэрийг даган хөгжих ёстой гэсэн зарчим баримталдаг. Ер нь Эрдэнэт үйлдвэр нийгэм хамгааллын цогц бодлого хэрэгжүүлээд чамгүй удаж байна.

Аймгийн соёлын болон спортын ордон, цэцэрлэг, дунд сургууль, технологийн сургууль, эмнэлэг сувилал зэрэг нийгмийн үйлчилгээний 12 нэгжийг санхүүжүүлэн Эрдэнэт үйлдвэрийн ажиллагсад төдийгүй, Орхон аймгийн нийт иргэнд үйлчилдэг. Тиймээс эдийн засгийн хямралд өртлөө гээд нийгмийн үйлчилгээний цехүүд үүд хаалгаа барих эрхгүй гэж тус үйлдвэрийн удирдлагууд үзэж байна. Учир нь, орон нутагт өргөн хүрээний үйл ажиллагаа явуулдаг Спорт ордон, Уурхайчин соёлын ордон, Эмнэлэг сувиллын цогцолбор, “Сэлэнгэ” амралтын бааз гэх мэт томоохон цехүүд сул зогсоход хүрвэл эрдэнэтийнхэн өлсөхгүй ч, нийгмийн сэтгэл зүйд сайнаар нөлөөлөхгүй нь лавтай. ▶



сүүлийн 3 жилд 44 толгой буга, 100 гаруй толгой тарвага, 60 орчим цацагт хяруул, галуу, нугас “Сэлэнгэ” амралтын баазад нутагшиж байна

дотоод хүч, нөөцөө ашиглан барьсан гэдгээрээ ихээхэн бахархдаг. Одоо энэ замаар үйлдвэрийн ажиллагсад болон иргэд дугуйгаар болон явганаар зорчин эрүүл агаарт бие бялдраа чийрэгжүүлж байна.

Эрдэнэт хотын “Соц” үеийн хуучны таван давхар орон сууцууд нь орчин үеийн шинэ барилгуудаас өндрөөрөө дутах ч өнгө зүсээрээ ард нь орохгүй харагдана. Орхон аймагтай хийсэн хамтын ажиллагааны дүнд Эрдэнэт хотын өнгө төрх өнгөрсөн гурван жилд нэлээд шинэчлэгдсэний нэг илрэл нь энэ ажээ. Зөвхөн орон сууцуудын гадна өнгө үзэмжид анхаарахаас гадна,

энэ хотын нийгэм, эдийн засагт онцгой дэмжлэг үзүүлсээр өдий хүрлээ” хэмээн Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн ерөнхий захирлын Нийгмийн асуудал хариуцсан орлогч С.Сувдаа хэлж байна. Эрдэнэт хотын хувьд Эрдэнэт үйлдвэр бол аав шиг нь улсын хувьд айлын том хүү шиг үүрэг гүйцэтгэж өдийг хүрлээ.

Орчин үед нийгмийн хариуцлагыг олон улсын ISO-26000 стандартаар хэмждэг болсон. Энэ стандарт эдийн засаг, худалдан авалт, байгаль орчны хамгаалал гэх мэт долоон үзүүлэлттэй. Олон улсын стандартын энэ үзүүлэлтүүдээр Эрдэнэт улсдаа тэргүүлж байна. Саяхан Монгол

► Уул уурхайн салбарт 40 гаруй нэр төрлийн нийгмийн хөнгөлөлт байдаг. Эдгээр хөнгөлөлт нь ажилтнууд үр ашигтай, өндөр бүтээлтэй ажиллах нөхцлийг бүрдүүлдэг гэж үздэг. Эрдэнэт үйлдвэр түүнээс 24 нэр төрлийн хөнгөлөлтийг үзүүлдэг байна. Нийгмийн хамгааллын олон хөнгөлөлтийг байнга үзүүлээд ирэхээр аливаа байгууллагын ажиллагсад олон арван жил тогтвортой ажилладагийн тод жишээ нь энэ компани. Тус үйлдвэрт ажилтнууд тогтвортой ажиллаж байгаагийн бас нэг шалтгаан нь цалин, урамшууллын цэгцтэй бодлого. Монгол Улс даяар эдийн засгийн хүндрэлээс улбаатай цомхотгол, цалингийн тасалдал өргөжиж байхад тус үйлдвэрийн ажилтнууд сүүлийн гурван жилд ерөнхий захирлын тушаалаар үндсэн цалингийн хувьд гурван удаа, долоон удаагийн тушаалаар 350 мянгаас нэг сая төгрөгийн урамшуулал, нэмэгдэл авсан байх юм.

Харьяалалтай 8000 хүн, хамааралтай 100.000 хүн

Эрдэнэт үйлдвэр ашиглалтад орсон 40-өөд жилийн тэртээх анхны боловсон хүчин өнөөдөр тэтгэвэрт гарч, үе солигдож байна. Нийт 6000 ажилтнаас гадна ахмад 1780, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хувь тогтоолгосон 500-гаад хүн, хоёр охин компани, гэрээт байгууллагын ажилтнууд гээд нийт 8000 гаруй хүний төлөө нийгэм хамгааллын үйл ажиллагааг Эрдэнэт үйлдвэр явуулж байна. Сүүлийн гурван жилд л гэхэд нийт 142 тэрбум гаруй төгрөгийг нийгмийн хамгааллын бодлогод зарцуулсан аж.

Үйлдвэрийн ажлыг нуруундаа үүрч явсан нэгэн үеийнхэн гавьяаны амралтаа авахад ард нь уул уурхайн бэлтгэгдсэн инженер техникийн ажилтнууд, төрөл бүрийн мэргэжлийн ажилчид үлдэх ёстой. Тэднийг сургаж бэлтгэх ажил их. Үйлдвэрийн захиргаа Үйлдвэрчний эвлэлтэй хийсэн хамтын гэрээнд ажиллагсдын нэг хүүхдийг эцэг эхийнх нь оронд ажилд авна гэсэн заалт бий. Шинээр ажилд орж байгаа хүмүүсийн 30-40 хувийг эцэг, эхийнх нь оронд аваад бусад ажлын байранд гаднаас хүмүүсийг сонгон шалгаруулалтаар ажилд авч байна. Эрдэнэт үйлдвэр сүүлийн гурван жилд сургалтын зардалд 7.5 тэрбум

төгрөг зарцуулсан. Өнгөрсөн оны байдлаар гадаадад 355 хүн, дотоодод 226 хүн үйлдвэрийн гэрээгээр суралцсан байдаг. Тус үйлдвэр мөн хажуудаа Монголын ирээдүйн уул уурхайн салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэдэг Технологийн сургуультай. Энэ сургуулиас төрөн гарах ирээдүйн боловсон хүчнийг Оюутолгой компани ч ажилд авах сонирхолтойгоо илэрхийлээд байгаа.

Уул уурхайн салбар нь дэлхий даяар ажиллах орчны тухайд хүнд нөхцөлд тооцогддог. Хэдий аюулгүй байдлын стандартыг чандлан сахидаг ч үйлдвэрийн осол, хурц хордлогод, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг сөрөг үр дагаварууд ажиллагсдын дунд гардаг. Эрдэнэт үйлдвэрийн хувьд өнгөрсөн гурван жилд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон ажилтнуудын нөхөн төлбөрт 6.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байдаг. Гэвч өвчин туссаны дараа нь нөхөн төлбөр өгөхийг урьтал болгохын оронд “Эрүүл мэнд” хөтөлбөр хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгийн хяналтыг сайжруулснаар нөхцлийг дээрдүүлж чаджээ. Өөрөөр хэлбэл, ажилтнуудын дунд зонхилдог таван өвчний үзүүлэлт буурч, 2013 онд 20 хүний нэг нь эдгээр өвчлөлд өртдөг байсан бол өмнөх онд 70 хүний нэг нь болж багасчээ. Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгөөр Орхон аймагт бүтээн байгуулсан “Эрдэнэт Медикал” оношилгоо эмчилгээний төвийг Японы эрүүл мэндийн “Медипас” байгууллагын менежментээр ажиллуулахаар болж, өнөөдөр үйл ажиллагаа нь эхлээд байна.

Эрдэнэт үйлдвэр Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хоёр жил тутам хамтын гэрээ үзэглэж, гэрээний биелэлтээ дүгнэдэг. Нийт 112 заалттай хамтын гэрээний биелэлт 2014 онд 98 хувьтай байсан бол 2015 онд 99.1 хувьтай гэж дүгнэгджээ. Өмнөх гэрээнд тухайлбал унаа, нүүрсний хөнгөлөлт, орон сууцны дэмжлэг, халуун хоол, хор саармагжуулах бүтээгдэхүүн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн хангамж, ажиллагсдын эрүүл мэндийг сахин хамгаалах, гавьяаны амралтаа авч байгаа хүмүүст нэг удаагийн тусламж үзүүлэх гээд олон заалт туссан. Үүнээс Эрдэнэт үйлдвэрийн зүгээс санаачилсан нэг заалт нь “цалинтай ээжүүд” юм. Хүүхдээ гурван нас хүртэл асарч байгаа ээжид сар бүр 400 мянган төгрөгийн

дэмжлэг үзүүлэх нь бусад салбарт бол цалингийн хэмжээний мөнгө билээ. “Ажилчдынхаа төлөө Үйлдвэрчний эвлэлтэй хамтын гэрээ байгуулж, ийм олон үүрэг хүлээж, түүнийгээ биелүүлж, ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа компани Монголд Эрдэнэт үйлдвэр л байна” гэж С.Сувдаа хэллээ. 2016 онд Хамтын гэрээг нэг жилийн хугацаатай хийжээ. Хэдийгээр дэлхийн зах зээлд Эрдэнэт үйлдвэрийн экспортод гаргадаг бүтээгдэхүүнүүдийн үнэ доошилсоор байгаа ч Үйлдвэрчний эвлэлтэй хийдэг гэрээний заалтуудын чанар ба биелэлтийг бууруулахгүйг хичээж байгаа гэнэ.

Эрдэнэт үйлдвэр болон түүнтэй холбоотой компаниудад нийт 8000 хүн ажилладаг ч ард нь 100.000 хүний амьдрал ямар нэг байдлаар холбоотойгоор өрнөж байдаг. Тиймээс ч орон гэрийн асуудалд Эрдэнэт үйлдвэр оролцох нь зайлшгүй шаардлага. Тус үйлдвэрийн орон сууцны дэмжлэгээр сүүлийн гурван жилд 1302 ажилтны орон сууцны асуудлыг шийдсэн байдаг. Мөн цаашид хамтарсан үйлдвэрийн Зөвлөлийн хурлаар дэмжигдсэн “Орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэт хотод маань “Залуус-600”, “Москва-300”, амины орон сууцны “Эко-400” хорооллууд бий болохоор төлөвлөгджээ. Мөн орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл, журмыг шинэчилснээр ажилтнууд урьдчилгаа 30 хувьдаа найман сая төгрөгийн дэмжлэг авах боломж бүрджээ. Мөн Нийгмийн дэмжлэгийн санг ажиллагсадаа орон сууцжуулах төслийн нэгж хэлбэрээр өөрчлөн зохион байгуулах санаачилга гарч, судалгаа хийж байгаа аж. Зөвхөн хорооллууд бариад зогсохгүй цаашид Эрдэнэт үйлдвэр хаалт-хөгжлийнхөө бодлогын нэг хэсэг болох нөхөн сэргээх чиглэлийнхээ хүрээнд төсөл хэрэгжүүлж томоохон цэцэрлэгт хүрээлэн байгуулах ховордсон ан амьтдыг сэргээн нутагшуулах ажлыг эхлүүлж тодорхой амжилт үзүүлж явна.

Монголын нийгмийн өмнө том үүрэг хариуцлага хүлээн ажиллаж байгаа аж ахуйн нэгж Эрдэнэт үйлдвэр 38 дахь жилдээ зөвхөн үйлдвэрийн харьяаны 8000 ажилтнаа харж хандах бус нийт 100 мянга шахам хүнтэй том хотыг чирсээр өдийг хүрлээ. Байгалийн баялаг мөнх бус учир тус үйлдвэрийн дараагийн том зорилтуудын нэг Эрдэнэт хотыг чирэгчгүй хот болгох. ■

Зураг түүх өгүүлнэ



Эрдэнэтийн овоонд геологи хайгуулын ажил хийгдэж байгаа нь, 1964 он



Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захирлын нэгдүгээр орлогч Д.Лхагвасүрэн анхдагчдын хамт



Анхны тэсэлгээ. 1978 он



Анхны баяжмалыг экспортод гаргав, 1978 он



XX зууны манлай бүтээн байгуулалт “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнав. 2013 он



Баяжуулах фабрикийн өргөтгөлийг ашиглалтад оруулав. 2015 оны зургадугаар сар.



Эрдэнэт үйлдвэр Орхон аймгийн ЗДТГ-тай хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав. 2016 он

Сурвалжлага

Ирээдүйн машин үйлдвэрлэлийн төвд

Ц.ЭЛБЭГ

Эрдэнэт үйлдвэрийн Засвар, механикийн заводод ажил жинхэнэ ундарна. Энд тэндгүй том том эд ангиуд, экскаваторын шанага, төмөр эдлэлүүд, элдэв янзын зорогч машинууд. Механик боловсруулалтын цехийн дарга Д.Галбямба энэ нь Баяжуулах фабрикийн тийм загварын бутлуурын хуяг, тэр нь “Libher” экскаваторын шанага, тийм төрлийн насос, наадах чинь белаз машинных гэх зэргээр үйлдвэрээ танилцуулж явлаа. Тэр их найрсаг хүн юм.

Засвар, механикийн завод нь Механик, Цутгалтын гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Нийт 622 ажилтантай. Хүн бүр өөрийн үүрэгт ажилдаа л анхаарч, үйлдвэртэй танилцаж яваа биднийг анхаарах сөхөөгүй. Жилд 2200 тонн механик боловсруулалт, 100 тонн резин эд анги, 5000 тонн цутгамал үйлдвэрлэх хүчин чадалтай. Жижиг эрэг, шурагнаас эхлээд найман тонн хүртэлх жинтэй том эд анги хүртэл 3000 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Баяжуулах фабрикийн бутлуур, тээрмийн хуяг, насосны хэрэгцээг бүрэн хангаж байгаа аж. Эдний хамгийн бахархуштай нь импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй явдал. Энэ төрлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилго тавьж ажилласнаар 2014 онд 3.7, 2015 онд 5.3 тэрбум төгрөг хэмнэжээ. Үүнийг импортоор авч байгаа бүтээгдэхүүний үнэ, үйлдвэрлэлийн зардлын зөрүүгээр тооцсон байна. Энэ жилийн төлөвлөгөөгөөр мөн 5.6 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллана. Тухайлбал, шүднүүд нь хугарсан “Libher” экскаваторын шанагыг шинээр худалдаж авахын оронд засварын заводдоо шүдийг нь үйлдвэрлээд л гагначихна.

Бидний бяцхан танилцах аялал Механик цехээс эхэлсэн юм. Цехийн суурь хүчин чадал 20 тонн хүртэлх жинтэй, таван метр голчтой эд анги боловсруулж, 12 тонн хүртэлх жинтэй


эд ангийг уужимсган зорох суурь машинтай. 30 мм зузаантай төмөр хайчлах хайч болон сүүлийн үеийн технологи болох лазер зүсэгчээр тоноглогджээ. Энэ цехэд нь заводын үйлдвэрлэлийн процессын сүүлийн дамжлагууд хийгдэх бөгөөд эндээс эцсийн бүтээгдэхүүн болон гардаг. Үндсэндээ энд уул уурхайн техник, технологийн бүх л хэсгүүдийг үйлдвэрлэж, засч сэлбэх боломжтой.

“Эрдэнэт үйлдвэр”-ийн Засвар механикийн завод нь Монголын аж үйлдвэрийн том түшиц байж иржээ. Тэд зөвхөн Эрдэнэтэд нийлүүлдэггүй. Дотоодын 40 гаруй компанид бүтээгдэхүүн нийлүүлдэг байна.

“Эрдэнэт үйлдвэр”-ийн Засвар, механикийн завод нь Монголдоо хамгийн том машин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв. Анх үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн сэлбэгийг үйлдвэрлэх, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор байгуулсан. Уурхайтайгаа бараг л нас чацуу. 1980 оны арванхоёрдугаар сарын 30-нд цутгуурын хэсэг анхны хайлалтаа хийж байсан аж. Цутгуурын хэсэг илүү сүрдмээр. Эндхийн том (бүр илүү том) кран, техник хэрэгсэл, зузаан хананууд бага зэрэг түгшүүр төрүүлнэ. Механик цехийн дэргэд гэрэл гэгээ бага нэвтрэх юм. Биднийг Цутгуурын цехийн дарга Ц.Зоригоо дагуулан үйл ажиллагаатай танилцуулж байна. Тэр ахимаг насны,

намба тогтсон, энэ цехэд 20 гаруй жил ажиллаж байгаа нэгэн. Ажлаа ч сайн мэдэх юм. Дөнгөж дотогш нэвтрэхэд ямар нэг зүйлийг хүчтэй нүдэж буй битүүвтэр чимээ гарч байв. Чимээ гарах бүрт бетон шал доргино. Энэ нь цутгуурын хэвийг бэхжүүлж байгаа хэрэг ажээ.

Хэвийг элсээр хийнэ. Учир нь галд тэсвэртэй, хэлбэрт орохдоо амархан.



Жижиг хэмжээтэйг бол хэдэн хүн хялбархан бэхжүүлчих нь. Эсвэл нэг машинд хийгээд л хоромхон зуурт хэд хэдээрээ бэлэн болно. Харин энэ чимээ, чичиргээгээр баримжаалахад их л том бүтээгдэхүүнд зориулсан хэв бололтой. Өнөөх эрэг шураг, жижиг шүдлүүр ▶

▶ гэгчлэнгээс экскаваторын шанагыг ч энд цутгана. Харин хэвний загварыг модоор урладаг байна. Технологийн шинэчлэл хийж гурван хэмжээст зоролт хийдэг машинтай болсноор өмнө нь хүний гараар 14 хоног зорж, сийлдэг байсан ажлыг гурав хоног болгон богиносгосон байна.

“Эрдэнэт үйлдвэр”-ийн Засвар механикийн завод нь Монголын аж үйлдвэрийн том түшиц байж иржээ. Тэд зөвхөн Эрдэнэтэд нийлүүлдэггүй. Дотоодын 40 гаруй компанид бүтээгдэхүүн нийлүүлдэг байна. Гэхдээ энэ нь нийт бүтээгдэхүүний ердөө нэг хувь нь. Зах зээл гарснаас хойш цутгуурын цех бүрэн хүчин чадалдаа хүрч ажилласан нь ховор ажээ. Үүнээс урьд дулаан цахилгааны станцууд гэхчлэн улсын томоохон үйлдвэрүүд тус заводод захиалга өгч, бүтээгдэхүүн худалдан авдаг байж. Одоо энэ бүхэн

хаана ч, хэн нь ч бахархан ярих юм.

Харин энэ жил 5200 тонн цутгалтын захиалга авчээ. Цаашид завод импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо, төрлийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа нь хүчин чадлаа бүрэн гүйцэд ашиглах шаардлагыг бий болгож байна. Түүнчлэн баяжуулах үйлдвэр хүчин чадлаа нэмэгдүүлж жилд 35 сая тонн хүдэр боловсруулах зорилго тавин ажиллаж байгаа учир түүнийг даган заводын хамт олны ажил ч нэмэгдэх нь. Гэхдээ хамгийн чухал нь чанар хэмээн Засвар, механикийн заводын дарга Б.Чинзориг ярьсан юм. “Импорт орлох бүтээгдэхүүний онцлог нь өнөөгийн зах зээл, техникийн шаардлагыг бүрэн хангасан байх ёстой. Түүнээс биш, харахад адилхан, хямд боловч стандарт хангахгүй бол импорт орлох бүтээгдэхүүн гэж боломгүй” гэж тэр хэлсэн.

Өнөөдөр Засвар, механикийн заводод

төдийгүй Монгол Улсын хэрэгцээнд ч хангалттай ажээ. Технологийн хувьд хийгдсэн нэг томоохон шинэчлэл нь резиний үйлдвэрлэл. Уул уурхайн салбарын ялангуяа баяжуулах технологийн дэлхийн чиг хандлага нь тоног төхөөрөмжийн дотрыг резинээр хуяглах болж байгаа аж. Учир нь элэгдлийн хугацаа урт, техникийн өөрийн жин багасч, түүнтэй уялдан цахилгаан зарцуулалт, тоног төхөөрөмжийн жигд ажиллагаа, бусад механизмд ирж байгаа ачаалал багасдаг гээд эдийн засгийн олон талт ач холбогдолтой. Эхний хуягийг хийчихсэн боловсруулалтын ажил явагдаж байгаа аж. Энэ жилдээ багтаж жижиг тээрмүүдийг бүрэн хангаж, том тээрмийн резин хуяг үйлдвэрлэж эхлэхээр төлөвлөжээ.

Тус заводын хамт олон бүтээгдэхүүн үйлдвэрлэж импортыг бууруулж байгаагаас гадна мэргэжлийн ур чадвар, дадал туршлагаараа гадагш чиглэсэн мөнгөний урсгалыг багасаж байна. Тэд өнгөрсөн жил Баяжуулах фабрикийн конусан бутлуурын хуягийг газар дээр нь сэргээн засварлах ажил хийжээ. Энэ ажлыг өмнө нь гаднын компаниуд хийдэг байсан аж. Үүний үр дүнд 500 мянган ам.долларын хэмнэлт хийсэн байна. Цаашид ч ийм төрлийн засварыг хийж чадах нь үүнээс харагдаж байна. Ер нь Монголд гаднаас уул уурхайн тоног төхөөрөмж оруулж ирэх нь ихээхэн өндөр зардалтай учир техникээ зөв зохистой удаан хугацаанд ашиглах нь чухал. Тиймээс засвар үйлчилгээ чухал юм. Ялангуяа задлахгүйгээр сэргээн засварлах арга сүүлийн үеийн технологийг эзэмших нь үр ашгаар илүү. Тийм учраас энэ чиглэлд анхаарч ажиллаж байгаа аж.

Өнөөдрийн хүчин чадал, нөөц боллоонд тулгуурлан хайс хашаа, сандал, гэрэлтүүлэг гэх мэт тохижилтын бүтээгдэхүүн хийж эхэлжээ. Мөн бэлэг дурсгалын бүтээгдэхүүнүүд ч хийдэг болж. Ирээдүйд Монголын машин үйлдвэрлэлийн төв болгохоор уурхайн “хаалт, хөгжлийн төлөвлөгөө”-нд тусгасан. Уурхайн үйл ажиллагаа зогссон ч заводын үйл ажиллагаа хэвээр үлдэх бөгөөд улам ч өргөжин бие даасан том үйлдвэр болно. Тиймээс бүтээгдэхүүнийг хэвээр чанар стандартыг хадгалж, нэр төрлийг олшруулж, үнийн хувьд өрсөлдөх чадвартай байлгаж зах зээл дээр байр сууриа олох бодлого хэрэгжүүлэх аж. Энэ чиглэлд судалгаа, шинжилгээ хийнэ хэмээн Б.Чинзориг ярьсан. Тэд бусад компанитай хамтарч ажиллахад бэлэн байна. ■



Цутгуурын цех энэ жил 5200 тоннын захиалга авчээ

үгүй болсныг Зоригоо “шахааны бизнестэй л холбоотой байх” хэмээн тайлбарласан. Сүүлийн гурван жилд “Эрдэнэт үйлдвэр” хэмнэлтийн бодлого барьж үйлдвэрлэлийн зардлаа бууруулж чадсан гол хүчин зүйл нь шахааны бизнесээс салж чадсан явдал хэмээн

тун чухал ажил өрнөж буй. Монголд анх удаа туузан дамжуургын ролик үйлдвэрлэх шугамыг нэвтрүүлэх гэж байна. Ирэх долдугаар сард угсарч дуусгах төлөвлөгөөтэй. Жил бүр 10 мянган ширхгийг үйлдвэрлэх чадамжтай байх бөгөөд энэ нь Эрдэнэт үйлдвэрийн

Инноваци

Оюунлаг Эрдэнэт

Б.ҮҮРИЙНТУЯА

Монгол, Америкийн хамтарсан “Эрдмин” үйлдвэр жилдээ 300 тонн цэвэр зэс гаргах юм байна. Үүгээр барилгын цахилгаан утас үйлдвэрлэж импортыг орлон, экспортлох алсын хараатай үйл ажиллагаа явуулж байна. “Эрдмин”-ээс гадна жилдээ 10 мянган тонн катодын зэс боловсруулах хүчин чадал бүхий бас нэгэн үйлдвэр Эрдэнэт хотод бий. Эдгээр үйлдвэр уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийг түшиглэн хөгжиж буй жижиг, дунд үйлдвэрүүдийн олон жишээний нэг. Татвар, төсвийн орлогын хувьд “Эрдэнэт үйлдвэр” аймгийн төсвийн 90 гаруй хувийг бүрдүүлэх бөгөөд Монголын уул уурхайн салбарт үлгэр жишээ болж буй хамгийн том үйлдвэр.

Өдгөө 38 дахь хавартай золгож буй тус үйлдвэр хэдэн жилийн өмнөөс инновацийн хөгжлийг дэмжих үүднээс нэлээд зоримог алхам хийгээд буй аж. Ийнхүү нийгмийн өмнө хүлээх олон хариуцлагын нэг гэж үзэн Компанийн оюуны өмчийн бодлогын цогц баримт бичгийг боловсруулан инновацийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай гэх хүчин зүйлсийн уялдаа холбоог хангахад чиглэсэн менежментийн зохион байгуулалтын өөрчлөлтийг чухалчилж дээрх баримт бичгийг олон улсын эрх зүйн акт, Монгол Улсын хууль, тогтоомжид нийцүүлэн баталсан байна. Ийнхүү Компанийн оюуны өмчийн бодлого, Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны журам, Компанийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах журам, Шинжлэх ухаан, технологи, инновацийн сангийн журам, Ерөнхий захирлын нэрэмжит “Инноватор” цомын эзэн баг, хамт олныг шалгаруулах, урамшуулах журмуудыг багтаасныг “Эрдэнэт үйлдвэр”-ийн Хөгжлийн хэлтсийн Инновацийн



төвийн координатор Д.Энхтунгалаг уламжиллаа.

Монголын оюуны өмчийн газарт 1981-1991 онд шинэ бүтээл, ашигтай загварын 18660 патент олгогдсоноос 60 хувь нь үйлдвэрлэлд нэвтэрсэн бол 1996-2016 онд 8000 патент бүртгэгдэж, ердөө 10 хувь үйлдвэрлэлд нэвтэрчээ. “Эрдэнэт үйлдвэр”-ийн Ерөнхий захирлын хөгжлийн асуудал эрхэлсэн орлогч Б.Намхайнямбуу “Манай үйлдвэр оюуны өмч, шинжлэх ухааны ажлуудад нэлээд анхаарч ажилладаг ч сүүлийн жилүүдэд харьцангуй зогсонги байдалтай болж ирсэн. Гэхдээ бид 2013 оноос эхлэн Инновацийн төвийг хөгжлийн төвийн дэргэд байгуулан ажиллаж байна. Түүнчлэн Засгийн газрын тусгай сангийн хүрээнд “Эрдэнэт үйлдвэр”-ийн шинжлэх ухаан, технологи инновацийн сангийн журам батлагдсан. Төвийг Инноваци хөгжлийн төв гэж нэрийдсэн бөгөөд оюуны өмч, инноваци, бүтээмж гэсэн үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна” гэсэн юм. Улмаар тус үйлдвэр оюуны өмчтэй аж ахуйн нэгжээр тодорч уул уурхайн салбартаа оюуны өмчийн бодлоготой анхны компани болжээ.

Олон улсад ноу хау, лиценз, патент

тухайн компанийн үнэ цэнийг өсгөх хүчин зүйл болдог юм байна. Тэгэхээр эдгээрийг цогцлоосноор инноваци “бүрэлдэж”, бүтээмж өсөх нь. Энэ утгаараа “Эрдэнэт үйлдвэр” импортыг хэмнэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримталж, улмаар өнгөрсөн онд 98 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зургаа орчим тэрбум төгрөгийн хэмнэлт үзүүлсэн гэдгийг холбогдох мэргэжилтнүүд тооцжээ. Эдгээр 98 бүтээгдэхүүнд булинг шахах шахуурга, механик түлхүүр гэсэн бүтээгдэхүүнүүдэд оюуны өмчийн зохиогчийн эрхийн лиценз авахаар Оюуны өмчийн газарт хандаад байгаа аж.

Олон улсын оюуны потенциалын индексээр монгол хүн эхний тавд жагсдаг ч ашиглалтын хувьд сүүлээсээ тавд байдаг гэсэн судалгаа бий. Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” 1978 онд ашиглалтад орсон цагаасаа эхлэн шинэ бүтээл, оновчтой саналыг бүртгэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, үр ашгийг тооцох, шагнал-урамшуулал олгох бүхэл бүтэн систем ажиллаж иржээ. Харин нэг ч бүтээлд эрхийн хамгаалалт хийлгэж байгаагүй юм байна. Иймд компанийн ▶



“Эрдэнэт үйлдвэр” 1978 онд ашиглалтад орсон цагаасаа эхлэн шинэ бүтээл, оновчтой саналыг бүртгэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, үр ашгийг тооцох, шагнал-урамшуулал олгох бүхэл бүтэн систем ажиллаж ирсэн.

► оюуны өмчийн бодлогын хүрээнд өнгөрсөн онд Монгол Улсын оюуны өмчийн газарт мэдүүлэг гаргаж Засвар, механикын завод, Баяжуулах фабрикын инженер техникийн ажилтнуудын зохион бүтээсэн шинэ бүтээлүүдийг патентжуулах ажлыг эхлүүлээ. Ийнхүү саяхан зэс хайлуулах үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-г “Эрдэнэт үйлдвэр”-ийн инженерүүд хийж, Аж үйлдвэрийн яамны бодлогын зөвлөлөөр хэлэлцүүлсний дүнд ажлын хэсэг байгуулагдан яам албан ёсоор хүлээн аваад буй аж. “Энэ юуг хэлж байна гэхээр олон улсын хэмжээнд яригдах ТЭЗҮ-ийг инженер, техникийн

монгол ажилчид хийх бүрэн чадавхтай болсныг харуулж байна” хэмээн Б.Намхайнямбуу чухалчилсан юм. Энэ нь цаашид ажилтнуудын оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, зах зээлд арилжаалах анхны алхмууд хийгдэж, компани нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа аж. Түүнчлэн дээрх шинэ бүтээлүүд нь “Эрдэнэт үйлдвэр”-ийн оюуны өмчийн бодлого, компанийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах журмын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн оюуны өмч гэдгийг Д.Энхтунгалаг онцлов. Нөгөө талаар энэ явдал ажилчдын хийж бүтээх эрч хүч, сурч мэдэх хүсэл хийгээд эзэмшсэн мэргэжилээрээ илүү туршлагажих нөхцлийг бүрдүүлэх болон хэрэгжилт, бүтээмжийг үр дүнгээр урамшуулах таатай орчин, боломжийг нээж өгсөн гэж болох.

Ажилтны мэдлэг, туршлага, оюун санааны төдийгүй сэтгэлгээний ур чадвар нь үйлдвэрийн хөгжлийн түлхүүр, үнэт зүйл гэж үздэг “Эрдэнэт үйлдвэр”-ийн хувьд оюуны өмчийн соёлыг төлөвшүүлэх, оюуны өмчийг бүтээх, хамгаалах, ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулахад ихээхэн анхаарч, өргөн хүрээ бүхий олон талт харилцааг зохицуулах үүднээс дээр хэлсэнчлэн баримт бичиг боловсруулж үндсэн дөрвөн журам баталжээ.

“Эрдэнэт үйлдвэр” инновацийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг бүтээх, түгээх, баяжуулах, тэдгээрийг ашиглах мэргэжилтэн, инженер, техникийн ажилтнуудаас гадна судалгаа, шинжилгээний лаборатори гээд олон чиглэлд дэмжлэг, санхүүжилт зэргийг удирдлагын зүгээс зохих ёсоор үзүүлж ирсэн. Цаашид оюуны өмчийн бодлогын хүрээнд олон зүйл хийхээр төлөвлөсөн байгаагийн нэг нь мөчлөг урсгалд тээврийн технологи нэвтрүүлэх тухай ярьж буй. Ил уурхайд таван км-ээс дээш замаар ачаатай тээврийн хэрэгсэл явах нь үр ашиггүй болдог тул туузан дамжуурга нэвтрүүлэх хэрэгтэй юм байна. Үүнийг хэрэгжүүлбэл эдийн засгийн хувьд хэмнэлт хийх боломж бий аж. Энэ үүднээс дээрх саналыг мөн л инновацид суурилан оюуны өмчийн бодлоготой уяа ёстой гэдгийг тус үйлдвэр хэдийнэ “ухаарчээ”. Үүний энгийн илрэл гэвэл компанийн дотоод нөөц, боломжид

тулгуурлан мэргэжилтнүүдийн гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний ажлуудыг туршилт, дадлагажуулалттай нягт уялдуулан үйлдвэрлэлд ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор компанийн инженер техникийн ажилтнуудын санаачилсан инновацийн төсөлд анх удаа санхүүжилт олгосон нь шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлээр гаднын байгууллагуудын гэрээт ажлын зардлыг бууруулжээ.

Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны журам нь шинжлэх ухаан, технологи, инновацийн төсөл хэрэгжүүлэх, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, импорт орлох, экспортыг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэх мэдлэгийг бий болгож, менежмент хийх үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулсан.

Компанийн санхүүжилтээр гүйцэтгэсэн ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах журам нь шинэ бүтээлд оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэснээр эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бий болгох, үр дүнгийн ашгийг хуваарилахтай холбогдон гарах харилцааг зохицуулсан.

Компанийн шинжлэх ухаан, технологи, инновацийн сангийн журам нь компанийн оюуны өмчийн бодлогын хүрээнд шинжлэх ухаан, техник, инновацийн зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, төслийн үр дүнгээр хэрэгжүүлэгч нарыг урамшуулах, сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавихтай холбогдон гарах харилцааг зохицуулна.

Ерөнхий захирлын нэрэмжит “Инноватор” цомын эзэн баг, хамт олныг шалгаруулах, урамшуулах журам нь компанийн оюуны өмчийн бодлогыг хэрэгжүүлэхэд үндсэн нөхцөл болж чадахуйц мэдлэг, чадамж, туршлага, ур чадварт тулгуурласан хамтын ажиллагааны үр дүнгээр бий болсон бүтээлийн гүйцэтгэлийг үнэлэн, үр ашгийг тооцон урамшуулахад холбогдон гарах харилцааг зохицуулна. ■

Үзэл бодол

Эрдэнэт ба...хаялга, улс төр, шороон үхэр...



Б.ЦЭНДДОО /нийтлэлч/

Эрдэнэт үйлдвэр бол нэг талаасаа хүйтэн дайны хаялга байлаа. Учир нь 1970-аад оны эхээр дэлхийн томоохон зэс үйлдвэрлэгч Чилид төрийн эргэлт гарч, тэндхийн Зөвлөлтлөг удирдагч Сальвадор Альендагийн засгийн газар унав. Улмаар Чилийн коммунист намын удирдагч Луис Корвалан Москва руу зугтаалаа. ЗХУ тэргүүтэй социализм байгуулагчид зэсийн хэрэгцээгээ хангах, найдвартай эх уурхайг шинээр байгуулах хэрэгцээ гарчээ.

Чухам энэ хэрэгцээ нь мал аж ахуйн хоцрогдсон орноос аж үйлдвэржин хөгжих мөрөөдөл тээн урагшилж явсан монголчуудын үндэсний мөрөөдлийн нэгэн биелэл болон хэрэгжих ерөөлтэй байжээ. Чехословак-монголын геологичдын нээгээд удаагүй байсан Эрдэнэтийн орд газарт Москвагийн сонголт буулаа. Ингээд Зүүн европт дэгдсэн социалист дэглэмийн эсрэг үзэл санаа, “Прагын хавар” зэргээс үүдэн мартагдаж байсан Эрдэнэтийн зэсийн ордын хайгуул, судалгааны ажил эргэн амилж “Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны шинэ жишээ” болон хөгжиж эхэлэв.

Монголын тусгаар тогтнол, эрх чөлөөний замнал нь үндэсний сэхээтэн, язгууртан, төрийн зүтгэлтнүүдийн гавьяа мөн үү гэвэл тийм. Гэхдээ ХХ зууны эхнээс аваад ХХI зуун дамнан өрнөж, дэлхийн газрын зураг болон улс төрийн уур амьсгалыг өөрчилсөн үйл явдлууд монголчуудад их төлөв ашигтай тусч ирсэн, шийдвэрлэх нөлөөтэй байсан нь сонин. Жишээлэхэд, дэлхийн

нэгдүгээр дайнаас албан бус тусгаар тогтнол, харин хоёрдугаар дайнаас нь хууль ёсны тусгаар тогтнол, 1990-ээд онд өрнөсөн социализмын задралаас улс төр эдийн засгийн тусгаар тогтнол, ардчилал хожсон нь үүний жишээ.

Тухайн үеийн уул уурхайн ашиглалтын технологи, социалист маягийн хандлага нь Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийг дагасан олон мянган хүнтэй хот байгуулахад хүргэлээ. Энэ нь малаасаа салж хотшин суурьших эрмэлзэл дүүрсэн монголчуудын баяр дээр баяр нэмж байж. Түүнчлэн уул уурхайн “хаалтын бодлого” гэж байгаа ч үгүй болохоор нөөц дуусахын хэрд яах тухай асуудал хэнийг ч зовоосонгүй. Ерөөсөө Зөвлөлт байгаа цагт, коммунизм байгуулсаар яваа үед ямар ч муу юм тохиолдохгүй гэсэн итгэлтэй үндэстний хувьд илүү дутуу юманд санаагаа зовоохыг хүссэнгүй. Эрдэнэтийн ордыг ашигласан хот лусын санг эзэгнэсэн мэт ҮҮрд тэлэн хөгжих сэтгэгдлээр нийгмийг амьсгалуулах аж. Монголчууд баяр хөөртэй байлаа.

Хоёр. Эрдэнэт ба үзэл суртлын (ПиАр) ажил

Эрдэнэт бол байгуулагдсан цагаасаа эхлээд манай нийгмийн уур амьсгал, улс төрийг тодорхойлж ирсэн юм. Уул уурхайн энэхүү аварга бүтээн байгуулалтыг нэг талаас Монгол-Зөвлөлтийн найрамдлын үр шим, БНМАУ-д социализм байгуулсны үр дүн, МАХН-ын зөв мэргэн бодлогын ач гавьяа болгон сурталчиллаа. 1970-аад онд Эрдэнэтийг тойрон өрнөсөн

ПиАр бол тал нутагт өрнөсөн хамгийн том үзэл суртлын цогц ажил болж чадсан юм. Хүн ардын амжиргааны түвшин, үйлдвэрлэлийн бүтээмж зэргийг “Эрдэнэтметр”-ээр хэмжин суртчилна. Уурхай ашиглалтад ороход, бүрэн хүчин чадлаараа хөдлөхөд “амжиргааны түвшин ингэж ахина”, “цалин орлого тэгж нэмэгдэнэ” гэсэн сурталчилгаа тэр үеийн сонин хэвлэлээр дүүрэн.

Хэдийгээр ийм амлалтууд нь суртал ухуулгын чанартай, одоогийнхоор бол сонгуулийн өмнөх амлалтуудтай агаар нэгэн зүйл байсан ч гэсэн ард нийтээрээ сэтгэл хангалуун үлдэж байлаа. Нэг талаас нүдэн дээр хот босч тал нутгийн өнгө төрх хувирч байлаа. Хамгийн гол нь “Эрдэнэтэд ажилчин элсүүлэх хөдөлгөөн”, “Хувьсгалт залуучуудын эвлэлийн гишүүдэд олгох шинэ хот байгуулах илгээлт” зэрэг нь хөдөө хоригдсон хүмүүст хот суурин руу шилжилт хөдөлгөөн хийх боломж олгожээ.

1959 онд малаа хураалгаснаас болоод хөдөө нутагт хоргодох юмгүй болсон малчид хот руу идэвхтэй шилжиж эхэлсэн юм. Гэтэл ардын засаг монголын малыг нийтээр нь улсын өмч болгох гэснээс биш хөдөө талыг малчингүй болгох зорилго тавиагүй байлаа. Харин ч мөлжлөг гээчийг үүсгэдэг хувийн малаасаа салж улс нийгмийн хонь ямаа хариулах болсондоо сэтгэл тэнийсэн хүмүүсээр хөдөө нутаг дүүрэх учиртай аж. Ингээд хөдөөнөөс хот руу чиглэсэн миграцид хатуу чанга хориг тавьж, иргэдийн ерийн шилжилт хөдөлгөөнийг хүртэл чанд хянах болжээ. Иргэншин амьдрах, хотшин суурьшихын зах зухыг амссан, бум бужигнасан газар цэнгэлтэй аж төрөх хүсэлд автсан мянга мянган хүний мөрөөдөл бас биелж байлаа.

Гурав. Эрдэнэт ба улс төр

Эрдэнэт нь байгуулагдсан цагаасаа эхлээд монголын улс төрийн хувь заяаг тодорхойлж ирсэн юм. Энэхүү буфер улс хэрхэн хөгжиж, социализмыг малчид хүртэл хичнээн сайхан байгуулж байгааг харуулах үзүүлэн, Зөвлөлтийн дагуул улс хэрхэн дэвжиж босдгийн үлгэр төдий байсангүй. Юм бүхэнд “зөвлөлтэй санал нэг” явж ирсэн МАХН, БНМАУ-ын удирдагчдад Эрдэнэтийн үйлдвэрийн хамтын ажиллагааны нөхцлүүдийг хянан үзэх нь

► бүү хэл тэр талаар бодох ч зүрх эхэндээ байсангүй. Гэвч наяд оны эхээр нам төрийн удирдлагад байсан Сайд нарын Зөвлөлийн дарга Д.Содном нарын эдийн засагчид уг бүтээн байгуулалтын сүүдэртэй талыг харжээ. Гэрээний нөхцлүүдийг шинжин үзэхэд жил ирэх тутам Монголын талд ашиггүй, харин ч алдагдалд орж, өр нэмэгдэхээр нөхцөл, заалтууд байгааг тэд анзаарч эхэлсэн байна. Ингээд гэрээний нөхцлүүдээ шинэчлэх шаардлага гарсан тухай яриа хөөрөө өрнөж эхэлжээ.

Тухайн үед нам төрийн удирдагч Ю.Цэдэнбалын ужиг өвчин даамжран “мартамхай” болж, түүний гэргий

нь хамтаар Москвадаа эргүүлэн татаж, БНМАУ-ыг удирдах Ж.Батмөнх тэргүүтэй шинэ багийг томилуулав.

Дөрөв. Эрдэнэт ба Улс төрийн “Шороон үхэр”

Үүнээс хойш ч монголын улс төрийн хувь заяа, үндэсний сонголтын тусгал нь Эрдэнэт дээр хамгийн тод илэрсээр ирлээ. Учир нь монгол улсын топ-10 татвар төлөгчийг Эрдэнэт тэргүүлсээр ирсэн. Энэ нь улсаа голлон тэжээгч үнээ гэсэн үг шүү дээ. Эрдэнэтийн ашигтай ажиллагаа, үр дүнгээс улсын эдийн засаг хамаарч, тэр утгаараа эрх

ламжтай “Шороон үхэр”-ийг шинжин үзэж “Лондоны металлын бирж дээр зэсийн үнэ ийм байгаа нь... засгийн газрын боломжийг нэмж, эсвэл хязгаарлах нь”, “үхэр хариулаач нь зэсийн үнэ өндөр байхад мөнгөөр туйлаад сурчихсан нэгэн тул...эсвэл хямралын үед ажиллаж байсан учраас хэмнэлтийн туршлагаа ашиглан ажиллаж” гэхчэн таамаг, прогнозоо дэвшүүлдэг.

Зурхайн үхрийн шинж 12 жил, жарнаар давтагдах байдалтай бол уурхайн үхрийн шинж сонгуулийн дүнг заримдаа дагах ч шиг байдаг. Лав л сүүлийн хориод жилийн турш



А.И. Цеденбал-Филатова засаг барьж байсан цаг. “Авгай”-г тойрон хүрээлэгчид “Зөвлөлтийн эсрэг үзэлтнүүд хүчээ авч байна. Тэднийг цэвэрлэх шаардлага гарч байна гэсэн дүгнэлт гаргаж Д.Содном нарыг нам засгийн удирдах бүрэлдэхүүнээс зайлуулах операцийг эхлүүлжээ. Зөвлөлтийн саналыг эхэлж тандалгүй эхлүүлсэн тэдний ажиллагаа, эцсийн сөрөг үр дүнгээс болгоомжилсон Кремлийн удирдагчид яаралтай арга хэмжээ авлаа. Гучаад жилийн тэртээ монгол төрийг удирдуулахаар илгээсэн Ю.Цэдэнбалыг гэргий Анастасиягийнх

баригчдын эдийн засгийн бодлогын хувь заяа шийдэгдэнэ гэсэн үг.

Иймээс засгийн эрхэнд гарсан хүчин хамгийн түрүүнд “Сүүтэй үнээ” ба “Үхэр хариулагч”-даа санаа тавьдаг уламжлалтай болж. Уламжлалт цагаан сар гармагц тухайн оны цаг улирлын “шороон үхэр”-ийг зурхайчид шинжин “Үхрийн омруу цагаан байгаа нь хавартаа цас унахын шинж...үхэр хариулаач нь хөл нүцгэн алхаж яваа нь... доодост ээлтэй...” гэхчлэн төлөглөдөг.

Харин сонгууль бүрийн дараа ажиглагчид Эрдэнэтийн зэсийн агуу-

Лондонгийн металлын бирж дээрх зэсийн үнийн график монголын улс төртэй сонин байдлаар (мэдээж тохиолдол байх) уялдаж иржээ.

Тав. Эрдэнэт ба зуд, хямралын хаялга

Ардчилсан хувьсгалаас хойш МАХН дангаараа эрх барьсан жилүүдэд ган, зудын давтамж таардаг юм. 1993-1996 ба 2000-2004 онуудад ган зуд дараалан мал аж ахуйг сүйдлэн алдаж, малчдыг амжиргааг доройтуулсан. Хэрвээ хуучин шигээ бүх мал улс ►

► нийгмийн мэдэлд байсан бол хэрхэхийг тэнгэр мэдэх байсан биз? Харин эрхбиш мал хувьчлагдаж хөдөө аж ахуй хувь хүний хариуцлага дээр тулгуурлаж байсан учраас ган зудыг давж чадсан юм.

Харин ардчилсан хүчин дангаараа болон голлон засаглаж ирсэн цаг үе нь Лондоны металлын бирж дээр зэсийн үнэ хамгийн их унасан цагтай давхцдаг. 1998 онд Д.Дорлигжавыг Эрдэнэтийн захирлаар томилогдож байхад, 2013 онд Ц.Даваацэрэнг томилогдон ирснээс хойшхи үе энэхүү зэсийн үнийн уналттай давхцдаг байна.

Энэ утгаараа МАН эрх барих үед мөнгөөр цалгисан үе таарч, АН эрх барих үед үндэсний үйлдвэрлэлээ аварч, авч үлдэхэд чиглэсэн менежмент голлож байсан гэсэн үг. Тохиолдлоор таарсан ган зуд, үнэ ханшийн уналтыг ёрлон ярихаасаа илүү туршлага талаас нь харахад сонин юм. Өөрөөр хэлбэл, МАН зудтай тэмцэн мал өсгөх аргатай дарга нараар илүүрхэж, АН эдийн засгийн хямралтай тэмцэх туршлагатай менежерүүдээр аархаж болохоор болж гэсэн үг.

Үнэхээр Эрдэнэтийг 1998-2000 удирдсан, 2013-оноос өнөөг хүртэл авч яваа багийнхан хямралыг туулсан туршлага, ямарч хүнд үеийг давж чадах нь харагдаж байгаа, туршлага менежментээрээ бахархдаг юм байна.

Эрдэнэт үйлдвэрийн удирдах багийнхан жил бүрийн ажлын тайлангаа олон нийтийн өмнө илтгэдэг болоод гурван жилийн нүүр үзэж байгаа аж. Тэдний бахархал нь цаггалдсан үеийн үрэлгэн удирдлагын арга барилыг хямралын үеийн хэмнэлтийн менежмент болгож хувиргаж чадсан явдал байна. Улмаар цаашид ч тодорхой хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа хямрал хүндрэлийн амжилттай туулах туршлага хуримтлуулж, итгэл найдвар бий болгож чадсандаа сэтгэл дүүрэн байна.

Ц.Даваацэрэнгийн баг Эрдэнэтийг удирдахаар 2012 онд ирэхэд тонн нь бараг 8000 ам.доллар байсан зэсийн үнэ Лондоны металлын бирж дээр жил дараалан уруудсаар 4600 орчимд буугаад байна. Жил тутам мянгаар буусан гэсэн үг. Буугаад зогсохгүй 2015 онд өөрийн өртгөөсөө доош оржээ. Өнгөрсөн оны байдлаар нэг тонн зэсийг 4820 долларын өртгөөр бүтээгээд 4600-орчмоор зарж байна гэсэн үг. (Нэг

тонныг нь 2012 онд 6060 долларын өртөгтэй бүтээж байсан. Хэмнэлтийн бодлогын үр дүнд тонн зэсийн өртөг 2000 орчим доллараар буусан гэж тооцно шүү дээ). Эрдэнэт үйлдвэр хэр алдагдалтай ажилласан бэ гэж та асуух байх. Харин танд Эрдэнэт үйлдвэрийн өнгөрсөн оны цэвэр ашиг 9 тэрбум байна гэж хэлэх хариулъя. Улсад 381 тэрбум төгрөгийн татвар төлөөд шүү. Мэдээж тэр том үйлдвэрийн хувьд бага, 2011, 2012 оныхтой харьцуулахад даанч бага ашиг л даа. Гэхдээ л ашиг.

Хямралын үед нэг талаасаа олборлолтыг нэмэгдүүлэх, нөгөө талаас нь зэсийн өөрийн өртгийг хямдруулах хоёр чиглэлээр ажилласан байна.

Баяжуулах фабрикийн өргөтгөлийг өнгөрсөн зун ашиглалтал оруулснаар анх удаагаа 30 гаруй сая тонн хүдэр боловсруулж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлснээр 62,9 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон аж.

Нэг талаас Эрдэнэт нь томоохон үйлдвэрлэгч, тэр утгаараа томоохон худалдаг авагч билээ. Иймээс худалдан авалтын үнэ бодитой, хэмнэлттэй байх нь зэсийн өртгийг хямдруулах гол гарц байж таарна. Үнийн бодлогыг хэрэгжүүлж худалдан авсан бараа материалын бодит үнийн бууралтаас 63 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Мөн нийт гэрээ хэлцлийн дотор “Урьдчилгаа төлбөргүй гэрээ” ердөө 32 хувьтай байсныг өөрчилж 80 хувьд хүргэсэн амжилтаа “ашиггүй, шахааны бизнес” –ийг шахан зайлуулсан том ололт гэж үзэж байгаагаа ерөнхий захирлын худалдааны асуудал хариуцсан орлогч Б.Болдбаатар ярилаа.

2013-2015 онуудад дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ унаж эдийн засаг санхүүгийн байдал тогтворгүй болсон энэ үеүдэд хямралын эсрэг авах арга хэмжээний хүрээнд хэмнэлтийн горимд шилжиж, өртөг зардлыг бууруулах, орлогоо нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээний үр дүнд үйлдвэр нийт 127,9 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олж, 131,6 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлт гаргаж ажилласнаа эдийн засаг эрхэлсэн захирал Б.Алтанхуяг тайлагнажээ.

Харин үйлдвэрлэл хариуцсан захирал Д.Даваасамбуу бол 1998-2000 оны зэсийн хямралын үед мөн албан тушаалд томилогдон ажиллаж, хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэн

нэвтрүүлсэн туршлагатай топ менежерүүдийн нэг билээ.

Эрдэнэт үйлдвэр нь өнгөрсөн зууны уул уурхайн технологийн тусгал болсон бүтээн байгуулалт учраас дагуул хот, аймгаа үүрч явах үүрэг хүлээдэг газар юм. Тус үйлдвэрийн үе үеийн ажилчын нийгмийн асуудал, тэтгэвэр тэтгэмж, тэдний гэр бүлд учирсан бэрхшээлийг хуваалцах гээд орчин цагийн уул уурхайн ямарч компанид байдаггүй үүрэг хариуцлага эрдэнэтээр дүүрэн. Магадгүй Оюутолгой, Таван толгой, Риотинто-гийн тайланд хэзээ ч гарахгүй “...мянган айлыг орон сууцны зээлэнд хамрагдахад туслалаа үзүүлж”, “ар гэрт тэтгэмж олгож” гэхчлэнгийн мэдээлэл тэнд бий. Иймээс Эрдэнэт бол нийгмийн хариуцлагаараа онцгойрдог үйлдвэр.

Хямралын үеийн хүнд нөхцөлд ч Эрдэнэт үйлдвэр нийгмийн хариуцлагаа ухамсартай биелүүлж ирсэн байна. Энэ хугацаанд нэг ч хүн цомхголоор ажлаас халаагүй, ҮЭ-тэй байгуулсан гэрээгээ 99 хувиар биелүүлж чадсан тухай Нийгмийн асуудал хариуцсан орлогч С.Сувдаа хэлж байна.

Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар бүс нутгийн оношлого эмчилгээний “Эрдэнэт медикал” төвийг нээсэн явдлыг Хөгжлийн бодлого хариуцсан орлогч Б.Намхайнямбуу онцолж байлаа. Ирэх тавдугаар сард албан ёсоор нээлтээ хийх энэ эмнэлгийг япончуудаас бүрдсэн менежментийн баг удирдах юм байна. Хамгийн орчин үеийн тоног төхөөрөмжтэй энэ эмнэлэг оношилгоо, шинжилгээний ажлаа эхлүүлчихсэн, оочер дугаар нь битүү байгаа аж.

“ОПЕК-ийн орнууд нефьтийн үнэ дахиад хоёр жил дараалан унахад сүйд болчихолгүй давж гарах санхүүгийн чадавхитай” хэмээн тоймчид хэлж байна. Харин ерөнхий захирал Ц.Даваацэрэн, Эрдэнэт үйлдвэр нь хямралыг даван гарч чадах менежмент нэвтрүүлж, туршлага хуримтлуулж чадсан гэдэгт итгэлтэй байна. Энэхүү нээлттэй тайлан толилуулах үйл ажиллагаа бол улс үйлдвэрийн ил тод байдлын илэрхийлэл бөгөөд хоёр улсын хамтарсан хөрөнгө оруулалттай компаний менежментийг хамгийн тодорхой байдлаар сурталчлан таниулахад чиглэсэн байна. ■

“Эрдэнэт” үйлдвэр фото дуранд



Хүдрийн ил уурхайн тэсэлгээ



“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн дэргэдэх “Хангарьд” спорт клубын хөлбөмбөгийн талбай